

Монголын Хүн Ам ба  
Хөгжил нийгэмлэг



Хүн Амын Сургалт  
Судалгааны Төв



НҮБ-ын  
Хүн Амын Сан

# МОНГОЛЫН ХҮН АМЫН СЭТГҮҮЛ

*Дугаар 10, 2004*

## **ӨМНӨХ ҮГ**

Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэг, Хүн Амын Сургалт Судалгааны Төвтэй хамтран НҮБ-ын Хүн Амын Сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 10 дахь дугаарыг бэлтгэн эрхэм уншигч та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарын “Судалгаа” хэсгээс Монголын хүн амын нас хүйсийн бүтцийн өнөөгийн болон ирээдүйн чиг хандлагын талаарх сонирхолтой бүтээлтэй танилцахаас гадна Улаанбаатар хотод шилжин ирэгсэдийн ажил эрхлэлтэнд нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ сэдэвт судалгааны ажлын үр дүн, тэндээс гарсан дүгнэлт зөвлөмжүүдтэй танилцах болно. Сэтгүүлийн “Сургалт” хэсгээс судалгааны мэдээллийг богино хугацаанд үр дүнтэй боловсруулах, мөн Монгол Улсын ястангуудын тоо байршилд гарч буй өөрчлөлтууд, болон Олон Улсын хүн амын статистикийн үүсэл хөгжил, өнөөгийн байдал зэрэг онол арга зүйн бүтээлүүдтэй танилцах болно. Түүнчилэн “Үзэл бодол” хэсгээс та бүхэн нийгмийн халамж үйлчилгээний үр ашиг, чанарыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй нийгмийн ажилтанг бэлтгэх ажлыг эрчимжүүлэх асуудлын талаар уншиж болно.

Монгол Улсын хүн ам, хөгжлийн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оюун ухаан, мэдлэг чадвараа зориулж буй нийт эрдэмтэн судлаачид, мэргэжилтэн оюутан залуучууд та бүхэндээ мөн сэтгүүлийн дугааруудыг бэлтгэн хэвлэхэд байнгийн дэмжлэг, туслалцаа үзүүлж байдаг НҮБ-ын Хүн Амын Сангийн Суурин төлөөлөгчийн Газарт сэтгүүлийн редакцийн нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

## **РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ**

## ТОВЬЁОГ

хуудас

### МОНГОЛ ХЭСЭГ

#### СУДАЛГАА:

МОНГОЛЫН ХҮН АМЫН НАС ХҮЙСИЙН БҮТЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ИРЭЭДҮЙН ХАНДЛАГА.....	5
Монгол Улсын Их Сургууль, Хүн Амын Сургалт Судалгааны Төв, Рикардо Ньюверт	
УЛААНБААТАР ХОТОД ШИЛЖИН ИРЭГСДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТЭНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ.....	24
Б.Нарантулга	

#### СУРГАЛТ:

СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙН АСУУДАЛ.....	44
Д. Чимгээ	
ОЛОН УЛСЫН ХҮН АМЫН СТАТИСТИКИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ БА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	53
Д. Тунгалаг	
МОНГОЛ УЛСЫН ЯСТАНГУУДЫН ТОО, БАЙРШИЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ.....	57
М. Баянтар, Г. Нямдаваа, З. Баярмаа	

#### ҮЗЭЛ БОДОЛ:

НИЙГМИЙН АЖИЛТАН БЭЛТГЭХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ АСУУДАЛ.....	72
Ч.Дагвадорж	

### ENGLISH SECTION

#### SURVEY:

AGE AND SEX DISTRIBUTION OF THE MONGOLIAN POPULATION: PRESENT AND FUTURE IMPLICATIONS.....	78
Population Teaching and Research Center, National University of Mongolia, Neuper. R	

#### PERSPECTIVES AND ISSUES:

KNOWLEDGE, ATTITUDES& PRACTICES ON FAMILY PLANNING AMONG INDUCED ABORTION USERS IN AN URBAN SETTING.....	97
Demberelsuren. J	
DEMOGRAPHIC TRANSITION IN ASIA.....	114
Enkhtsetseg. B	
СЭТГҮҮЛД ХЭВЛЭГДЭХ МАТЕРИАЛЫН СТАНДАРТ	121

# МОНГОЛ ХЭСЭГ

- Судалгаа
- Сургалт
- Үзэл бодол

# **СУДАЛГАА**

---

# МОНГОЛЫН ХҮН АМЫН НАС ХҮЙСИЙН БҮТЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ИРЭЭДҮЙН ХАНДЛАГА

Монгол Улсын Их Сургууль, Хүн Амын  
Сургалт судалгааны төв  
Рикардо Ньюперт

Хүн амын судалгааны нэг чухал хэсэг нь хүн амын нас, хүйсийн бүтцийн судалгаа байдаг. Хүн амын нас, хүйсийн бүтцийг судлах нь нэг талаар бизнес, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд зэрэг салбарыг шаардлагатай бодлого боловсруулах, төлөвлөлт хийх, нөгөө талаар хүн ам зүйн хучин зүйлсийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтөнд тусгахад ихээхэн ач холбогдолтой юм.

Энэхүү ажлаар Монгол Улсын хүн амын нас, хүйсийн бүтцийн өнгөрсөн, одоо, ирээдүйн өөрчлөлт, чиг хандлагыг авч үзэж, энэ талаар сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүлж, дүгнэлт хийсэн байна. Мөн хүн амын нас, хүйсийн бүтцийг харуулахуйц зарим үзүүлэлтийг тооцсон ба хүн амын моментумыг судалж, Монгол Улсын хүн ам моментумаараа өсөх хандлагын талаар хэтийн тооцоо хийсэн нь нэлээд шинэлэг, ач холбогдолтой зүйл болжээ.

Түүнчлэн хүн амын төрөлт буурч, улмаар хүн амын өсөлтийн бууралт ажиглагдаж байгаа энэ үед хүн амын өсөлтийн талаарх судалгаа, шинжилгээний ажил хийж буй хүмүүст ашиглаж болохуйц бодит баримт, суурь материал болох юм.

## Удиртгал

Хүн ам зүйн судалгаанд хүн амын нас, хүйсийн бүтцийг судлах нь хүн ам, нийгэм, эдийн засгийн бодлого боловсруулах, хүн амын хүчин зүйлсийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинжилгээнд тусгахад чухал ач холбогдолтой. Хүн амын нас, хүйсийн байдал нь нийгэм, эдийн засаг, соёлын асуудлуутай нягт холбоотой учраас түүнийг шинжлэх шаардлагатай байдаг. Тухайлбал, сургуульд хамрагдалт, ажиллах хүчний нөөц, гэрлэх, төрөх, шилжих гэх мэт. Түүнчлэн зарим нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ нь нас хүйсийн бүтцээс хамааран өөр өөр байдаг. Нас хүйсийн бүтцийн мэдээлэл нь нийгмийн чиг хандлагыг тайлбарлах, зах зээлийг тодорхойлох, ирээдүйн төлөвлөлт хийхэд чухал ач холбогдолтой. Мөн нийгмийн мөн чанар, функцийг ойлгоход чухал байдаг (Rowland.D.T, 2003). Үүний зэрэгцээгээр хүн амын түүхэн хөгжил хувьслыг болон ирээдүйн хэтийн төлвийг тодорхойлно.

Хүн амын бүтэц нь хүн амын өсөлт, өөрчлөлтийн бүрэлдэхүүн хэсгүүд болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнөөс хамаардаг билээ. Төрөлт, нас баралтын өндөр түвшин нь хүн ам залуужих үндэс болдог. Энэ нь хүүхэд болон залуучуудын эзлэх хувийн жин өндөр байна гэсэн үг юм. Төрөлт, нас баралт буурахын хэрээр хүн ам насжиж, насанд хүрсэн залуу, дунд болон ахимаг насны хүмүүсийн эзлэх хувийн жин өсдөг. Шилжин ирэх хөдөлгөөн нэмэгдсэнээр насанд хүрсэн залуу эрэгтэйчүүдийн (эмэгтэйчүүдийн) хувийн жин эрс нэмэгдэхэд хүргэдэг. Түүнчлэн дайн, улс төрийн тогтвортгүй байдал, эдийн засгийн хямрал гэх мэт гэнэтийн үзэгдлийн үр дүнд зарим насны бүлгийн хүмүүсийн хувь багасна. Үүнийг тухайн үеийн төрөлтийн бууралт, нас баралтын өсөлт зэргээр тайлбарладаг.



Цаашилбал, хүн амын бүтэц нь бидэнд хүн амын ирээдүйн шинж байдлын талаар үнэтэй мэдээллийг өгнө. Жишээ нь, залуу насын бүтэцтэй хүн амын хувьд нөхөн үржихүйн насын эмэгтэйчүүдийн хувийн жин өндөр байдаг учраас хүн амын хурдацтай өсөх боломж бүрддэг. Түүнчлэн энэхүү байдал нь боловсрол болон ажил эрхлэлтийн салбарт хөрөнгө оруулалтыг тодорхой хугацаанд нэмэгдүүлэхийг шаардана. Нөгөөтэйгүүр, хүн ам насжихын хэрээр тэтгэвэр, эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилт болон ажиллах хүчний нийлүүлэлтийн бууралтын асуудлуудад анхаарах хэрэгтэй болдог.

Энэхүү ажлын зорилго нь Монголын хүн, амын нас хүйсийн бүтцийг судлах явдал юм. Үүний зэрэгцээ хүн амын бүтэцтэй холбоотой зарим сэдвүүдийг энд хөндөх болно. Тухайлбал, хүн амын моментум, зорилтот насын бүлгийнхний өсөлтийн ялгаатай байдал зэргийг судлах юм. Мөн Монголын хүн амын хүн ам зүйн шинж байдлын талаарх цогц шинжилгээг хүн ам зүйч, эдийн засагч, нийгэм судлаачдад болон бодлого боловсруулагчдад хүргэхийг зорьсон. Судалгаанд Үндэсний Статистикийн Газрын 1969, 1979, 1989, 2000 оны тооллого (УСГ, 1994; 2001) болон хүн амын хэтийн тооцоог ашиглав (УСГ, 2002).

### **Монголын хүн амын бүтцийн өөрчлөлт**

Хүн амын нас, хүйсийн бүтцийг хүн амын суваргаар харуулах нь хамгийн тохиромжтой арга юм. Энэ нь насын бүлэг бүр дэх эрэгтэй, эмэгтэй хүн амыг хувийн жин буюу тоогоор харуулдаг хэвтээ байрлалтай тэгш өнцөгт дүрслэл юм. Суурь хэсэгт залуу насын бүлгийн хүн амыг, зүүн гар талд эрэгтэй хүн ам, баруун гартаа эмэгтэй хүн амыг байрлуулах зарчимтай. Хүн амын насын бүтцээс хамааран суварга нь өөр өөр хэлбэртэй байж болно. Жишээлбэл, залуу бүтэцтэй хүн амын хувьд суварга пирамид хэлбэртэй, харин хүн ам насжих тутам суварга тэгш өнцөгт хэлбэрт дөхөж очно. Шилжих хөдөлгөөн болон гэнэтийн үзэгдэл, үйл явцаас хамааран суваргын хэлбэр гажуудаж болох талтай (PRB, 2000).

Зураг 1а-аас 1г-д Монгол Улсын 1969, 1979, 1989, 2000 хүн амын суваргыг дүрслэн харууллаа. Суваргыг хувийн жингээр бус, тоогоор зурсан бөгөөд үүнээс хүн амын бүтэц бүрэлдэхүүнийг төдийгүй, хүн амын хэмжээний өөрчлөлтийг харж болно. Зургаас хараад Монгол Улсын хүн амын бүтэц бүрэлдэхүүн нэлээд өөрчлөгджээ. Хүн ам ерөнхийдөө залуу насын бүтэцтэй байснаа завсрын гэж хэлж болохоор бүтцэд шилжсэн байна. Ялангуяа 1989 ба 2000 оны хооронд хүн амын нас, хүйсийн бүтэц нэлээд өөрчлөгдсөн байна. 2000 оны хүн амын суваргыг харвал 0-4 болон 5-9 насын хүн амын тоо 10-14 насын хүн амын тооноос бага байна. 1989 оны тооллогоор 0-9 насын хүн амын хувийн жин 29.6 байснаа 2000 он гэхэд 20.7 хувь болж буурчээ. Энэхүү байдал нь хүн амын төрөлтийн түвшин ихээхэн буурч, хүн ам хөгшрөх хандлагатай болж байгаа буюу хүүхэд залуучуудын хувийн жин буурч, насанд хүрэгсэд буюу хөгшин хүмүүсийн хувийн жин өсөж байгааг харуулж байна. Монгол Улсын хувьд 1990-ээд оноос эхлэн төрөлийн түвшин тогтвортойгоор буурсаар байгаа бөгөөд 1980-аад онд ТНК 6 буюу түүнээс дээш байсан бол 1990-ээд онд 3 буюу түүнээс доогуур түвшинд хүрч очсон байна. (УСГ, 1995)



#### Эх үүсвэр:

УСГ, 1994. Монгол Улсын хүн ам, Улаанбаатар

УСГ, 2001. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Үндсэн үр дүн,  
Улаанбаатар

1969 оны хүн амын нас, хүйсийн суваргаас харахад, 20-24 -өөс дээш насны бүлгүүдэд хүн амын тоо ерөнхийдөө ойролцоо бөгөөд цөөн насны бүлэгт хүн амын тоо ялгаатай байгаа ажиглагдаж байна. Энэ нь өнгөрсөн зууны эхний хагас дахь нас баралтын өндөр түвшин, улс төрийн тогтвортой байдал, ялангуяа Дэлхийн хоёрдугаар дайны дараах хэмэгдүүлэлттэй холбоотой юм. 1969 оны хүн амын нас, хүйсийн суваргаас харахад суурь хэсгээрээ өргөссөн буюу төрөлтийн түвшин өсөж, нас баралтын түвшин буурч эхэлснийг харж болно. Тухайн үеийн Про нааталист бодлого, сүм хийдэд олноор шавилан суж байсан лам нарын тоо цөөрсөн, Европын анагаах технологийг нэвтрүүлсэн зэрэг нь 1940-1950-аад онд хүүхэд, залуу үеийнхний нас баралтыг бууруулж, суваргын суурийг өргөсөхөд (хүүхэд, залуу үеийнхний тоо нэмэгдэх) нөлөөлсөн юм. (Neupert, 1996). Хүн амын төрөлтийн түвшин үүний дараачийн 25 орчим жилд хэвээр үргэлжилсэн бөгөөд 2000 оны хүн амын нас, хүйсийн суваргаас хүн амын төрөлтийн түвшингийн бууралт 1990-ээд оноос эхэлсэн нь тодорхой харагдаж байна. 1969 оны суваргаас харвал 24-өөс дээш насны эмэгтэй хүн амын тоо эрэгтэй хүн амаас бага байв. Энэ нь эхийн эндэгдлийн өндөр түвшнээр тайлбарлагдах бөгөөд харин 1989 оны суваргад энэхүү байдал нь төдийлөн ажиглагдахгүй байна.

Хүснэгт 1-д хүн амын нас хүйсийн бүтцийг сонгосон үзүүлэлтүүдээр харуулав. Хүйсийн харьцаа нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэй хүн амын тоог харуулдаг. Монголын хувьд эрэгтэй, эмэгтэй хүн амын тоо бараг адилхан байна. Харин 2000 онд эмэгтэй хүн амын тоо ялимгүй өндөр болсон нь

магадгүй эмэгтэй хүн амын дундаж наслалтын өсөлттэй холбоотой байж болох талтай. Ерөнхийдөө ихэнх улс орны хувьд эмэгтэй хүн амын тоо арай илүү байх хандлага ажиглагддаг. Голч нас гэдэг нь хүн амыг тооных нь хувьд тэнцүү хоёр хэсэгт хувааж буй нас бөгөөд хүн амын тэн хагас нь голч наслас залуу, тэн хагас нь голч наслас дээш наслы хүн ам байна гэсэн үг юм. (PRB, 2000). Монгол Улсын хувьд голч наслас харахад ерөнхийдөө залуу хандлагатай ба 1969-1989 онд төдийлөн өөрчлөлт гараагүй байна. Харин 2000 онд мэдэгдэхүйц өссөн нь төрөлтийн бууралтын үр дүн гэж хэлж болно. Ерөнхийдөө голч нас нь 30 ба түүнээс дээш байвал хөгшин наслы бүтэцтэй хүн ам гэж тооцогддог. Хүүхдийн ачаалал нь хөдөлмөрийн буюу 15-64 наслы 100 хүн амд ногдох 0-14 настай хүүхдүүдийн тоогоор тодорхойлогдоно. Монголын хувьд хүүхдийн ачаалал бага байгаа нь залуу наслы бүтэцтэй улс гэж дүгнэхэд хүргэж байгаа боловч төрөлтийн бууралтын улмаас 1990-ээд оноос энэхүү үзүүлэлт буурч байна. Харин хөгшчүүдийн ачаалал гэдэг нь хөдөлмөрийн наслы 100 хүн ам тутамд ногдох 65 ба түүнээс дээш наслы хүн амын тоогоор илэрхийлэгдэнэ. Монголын хувьд энэхүү үзүүлэлт нь хөгшин настай хүн амын хувийн жин бага байгааг харуулж байна. Нийт ачаалал нь хүүхэд ба хөгшин настай хүн амын ачааллын нийлбэр дүн юм.

**Хүснэгт 1. Нас, хүйсийн бүтцийг тодорхойлогч сонгосон үзүүлэлтүүд, Монгол Улс, 1969, 1979, 1989, 2000**

Үзүүлэлтүүд	Он			
	1969	1979	1989	2000
Хүйсийн харьцаа	99,4	99,8	99,5	98,5
Голч нас	18,7	17,3	18,6	21,6
Хүүхдийн ачаалал	89,6	88,8	78,3	58,9
Хөгшин наслы хүн амын ачаалал	12,1	10,2	7,7	5,7
Нийт ачаалал	101,7	99,1	86,0	64,6
Хөгшрөлтийн индекс “Асран халамжлагч”-ийн харьцаа	13,5 58,9	11,5 72,5	9,9 72,3	9,7 58,1

**Эх үүсвэр:**

УСГ, 1994. Монгол Улсын хүн ам, Улаанбаатар

УСГ, 2001. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Үндсэн үр дүн, Улаанбаатар

Хөгшрөлтийн индекс гэдэг нь 0-14 наслы 100 хүүхдэд ногдох 65-аас дээш наслы нийт хүн амын тоогоор илэрхийлэгдэнэ. Эндээс Монгол Улсын нийт хүн амд хүүхдийн эзлэх хувийн жин өндөр, хөгшин наслы хүн амын эзлэх хувийн жин бага байгааг харж болно. Хэрэв энэ үзүүлэлт 100-аас дээш байвал хөгшин наслы бүтэцтэй хүн ам гэж үздэг. Хүн амын нас, хүйсийн бүтцийг тодорхойлогч бас нэг сонирхолтой үзүүлэлт бол “асран халамжлагчид”-ын харьцаа бөгөөд үүнийг 50-64 наслы 100 эмэгтэйд ногдох 80-аас дээш наслы хүн амын тоогоор тодорхойлно. Ихэнх улс орнуудад 80-аас дээш наслы ахмадуудыг тэдний охид болох 50-64 наслыхан асран халамжилдаг бөгөөд дээрх үзүүлэлт нь ахмадуудыг асран халамжлах хүний нөөц ямар байгааг харуулдаг ажээ. Монголын хувьд дундаж наслалтын доогуур түвшинтэй холбоотойгоор энэхүү

үзүүлэлт нэлээд бага байгаа буюу 2000 оны байдлаар 100 боломжит асран халамжлагчдад 14.4 настайчууд ногдож байна. Хөгшин насны бүтэцтэй улс орны хувьд энэ үзүүлэлт 50-аас илүү, зарим тохиолдолд 100-д ойрхон байдаг ажээ.

Насны бүтэцтэй холбоотой гарч ирдэг хамгийн чухал үзүүлэлт бол зорилтот насны бүлгүүд байдаг. Энэ нь тухайн улс орны нийгмийн зүгээс онцгой анхаарал шаарддаг насны бүлгүүд юм. Хүснэгт 2 ба Зураг 2-т 1969-2000 онууд дахь зорилтот насны бүлгийг харууллаа. Энэ нь боловсролын эрэлт хэрэгцээ ихтэй залуучууд болон хөдөлмөрийн зах зээлд их хэмжээгээр нийлүүлэгдэж байгаа, түүнчлэн орон сууцны асуудал хурцаар тавигдаж байгаа залуу насны болон насандаа хүрсэн хүмүүс юм. Хөгшин насны хүн амын тоо бага байгаатай холбоотойгоор тэдний нийгэмд учруулах дарамт нь төдийлөн их биш байна. Дараагийн бүлэгтээ энэхүү нэхцэл байдал нь ирээдүйд хэрхэн өөрчлөгдхөхийг харуулах болно.

#### **Хүснэгт 2. Сонгосон зорилтот насны бүлгүүд, Монгол Улс, 1969, 1979, 1989, 2000**


Зорилтот насны бүлгүүд	Нас (жилээр)	Хүн амын тоо				Хувийн жин (нийт хүн амд эзлэх)			
		1969	1979	1989	2000	1969	1979	1989	2000
Нялхас	0-1	38 323	59 015	71 539	49 804	3,2	3,7	3,5	2,1
Хүүхдүүд	1-4	160 478	208 946	259 582	196 219	13,4	13,1	12,7	8,3
Бага сургуулийн нас	8-11	130 538	173 856	212 571	249 699	10,9	10,9	10,4	10,5
Дунд сургуулийн нас	12-18	156 885	275 936	331 121	406 128	13,1	17,3	16,2	17,1
Хөдөлмөрийн нас	эрэгтэй: 15-59; эмэгтэй: 15-54	532 576	750 984	1 043 759	1 371 561 646 535	44,5	47,1	51,1	57,8
Нөхөн үргижихүйн насны эмэгтэйчүүд	15-49	231 136	338 141	480 329		19,3	21,2	23,5	27,2
Өрх толгойлох насны эрэгтэйчүүд	22-28	50 299	73 370	128 769	158 094	4,2	4,6	6,3	6,7
Хөгшин насны хүн ам	65 ба түүнээс дээш	71 942	79 082	82 628	82 003	6,0	5,0	4,0	3,5
Нийт хүн ам		1 197 595	1 595 006	2 043 954	2 373 493				

#### **Эх үүсвэр:**

УСГ, 1994. Монгол Улсын хүн ам, Улаанбаатар

УСГ, 2001. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Үндсэн үр дүн, Улаанбаатар

Зураг 2. Зорилтот насын бүлгүүд, Монгол Улс, 1969,



**Эх үүсвэр:**

УСГ, 1994. Монгол Улсын хүн ам, Улаанбаатар

УСГ, 2001. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Үндсэн үр дүн, Улаанбаатар

### Монголын хүн амын бүтцийн ирээдүйн чиг хандлага

Үндэсний Статистикийн Газар 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын мэдээлэлд үндэслэн хүн амын хэтийн тооцоог хийсэн. Энэхүү бүлэгт дээрх хэтийн тооцооны үр дүнг ашиглан хүн амын нас, хүйсийн бүтэц ирээдүйд хэрхэн өөрчлөгдхийг авч үзэх болно. Хүснэгт 3-т 2000-2020 он хүртлэх хүн амын жилийн дундаж өсөлтийн түвшин ямар байхыг дунд хувилбараар тооцон гаргасныг харуулав. Хэтийн тооцоог төрөлт, нас барагт, шилжих хөдөлгөөний ирээдүйд өөрчлөгдж болох чиг хандлага дээр үндэслэсэн болно. Хэтийн тооцоонд төрөлт буурна, (2000-2005 онд нэг эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин 2.4 байснаа 2015-2020 онд 1.9 болж буурна) нас барагт ч мөн адил буурна (2000-2005 онд дундаж наслалт эрэгтэй хүн амын хувьд 63.8 байснаа 2015-2020 онд 68.8, эмэгтэй хүн амын хувьд 68.8 байснаа 73.4 болж) гэсэн таамаглал дэвшүүлсэн бөгөөд хүн амын өсөлт маш удаан байх болно. Гэхдээ 1970-1980-аад оны хүн амын өсөлттэй холбоотойгоор удаан хугацаанд хүн ам нэгээс илүү хувиар өсөх учраас энэхүү өсөлтийг бага гэж үзэж болохгүй юм. Хүн амын төрөлт доогуур байх үеийн хүн амын өсөлтийг хүн амын моментум гэж нэрлэх бөгөөд энэ талаар дараагийн бүлэгт авч үзнэ.

### Хүснэгт 3. Хүн амын хэтийн тооцоо, Монгол Улс

Онууд	Хүн амын тоо	Жилийн дундаж өсөлт (%)
2000*	2 389 661	
2005	2 562 261	1,40
2010	2 741 774	1,36
2015	2 918 624	1,26
2020	3 087 048	1,13




**Эх үүсвэр:** УСГ, 2002. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого:

Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар

УСГ, 2003. Монгол Улсын статистикийн эмхэтгэл., Улаанбаатар

\*2000 оны хүн амын тоо нь Хүснэгт 2-с ялгаатай байгаа болно. Хүснэгт 2 нь 2000 оны 1-р сарын 5-ны тооллогын дун ба Хүснэгт 3-н мэдээлэл нь 2000 оны дундаж хүн амын тоо болно.


Зураг За-с Зв-д 2000, 2010, 2020 онд хүн амын нас, хүйсийн бүтэц ямар байхыг харуулжээ. Эдгээр суваргууд нь Зураг 1а-аас 1г-д харуулсан суваргуудын “хүлээгдэж буй” үргэлжлэл бөгөөд төрөлт, нас баралтын өндөр түвшнээс төрөлт, нас баралтын доогуур шатанд шилжиж буй хүн ам зүйн шилжилтийн үйл явцыг харуулж байна. Гэхдээ үүнийг хангалттай бууралт гэж үзэж болохгүй юм. Учир нь эмэгтэй хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалт нь 2000-2005 онд 68.8 жил байснаа 2015-2020 онд 73.4 жил болж нэмэгдэж байгаа боловч ихэнх хөгжлийн орнуудад дундаж наслалтын энэхүү хэмжээний уртсалт ойролцоогоор 10 жил байдаг байна.



**Эх үүсвэр:**

УСГ, 2002. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар

Дээрх суваргуудаас хүн амын насжилтын үйл явц, өөрөөр хэлбэл насанд хүрэгсэд болон хөгшин насны хүн амын өсөлт нь хүүхэд, залуучуудын өсөлтөөс илүү хурдан явагдахыг харж болно. Энэхүү чиг хандлага нь нэлээд аажим явагдах ажээ. Жишээлбэл, 2020 оны хүн амын суваргын суурь нь 1975-79, 1980-84 оны үелрэлтэй харьцуулахад (25-29 ба 30-34 настай) бага байгаа боловч бусад үелрэлүүдтэй харьцуулахад бага биш байна. Зураг 4-т 2020 оны хүн амын нас, хүйсийн суваргыг 2000 онтой харьцуулан үзүүллээ.



#### Эх үүсвэр:

УСГ, 2002. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар

Өмнөх зургууд нь суваргын өөрчлөлтийг, ялангуяа 2000 оноос эхэлсэн өөрчлөлтийг харуулж байгаа ба суваргын хэлбэрийг ажиглавал хүн ам нь завсрын гэж хэлж болох хэв маягаас “төгс боловсорсон” хүн амд шилжиж буй шилжилт ажиглагдаж байна. Үндсэндээ 2020 оны хүн амын нас, хүйсийн суваргыг харвал залуу ба хөгшин хүн амын хоорондох завсрын шинжтэй байгаа боловч хүүхэд залуучуудын тоо харьцангуй өндөр байна. Залуу болон дунд насны хүн амын тооноос хүн амын төрөлт нь эргэн нөхөгдөх түвшинтэй ойролцоо байгааг харж болно.

Хүснэгт 4 ба 5, ялангуяа Хүснэгт 5 нь дараагийн 20 жилд Монголын хүн амын нас, хүйсийн бүтцийг харуулах үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөхийг харуулав. Хүснэгтүүд хөдөлмөрийн насны хүн ам эрчимтэйгээр өсөж, харин хөгшин насны хүн ам удаанаар өсөхийг, цаашлаад залуу насны хүн амын буурахыг харж болно. Өмнө авч үзсэн төрөлтийн огцом гэж нэрлэгдээд байгаа бууралт нь бодит байдлаар нь авч үзвэл аажмаар буурч байгаа хэрэг юм. Учир нь өнгөрсөн үеийн төрөлтийн өндөр түвшин нь нөхөн үржихүйн насны хүн амын хувийн жин өндөр байхад хүргэж байгаа ба хэдийгээр төрөлтийн түвшин доогуур байгаа ч төрсөн хүүхдийн тоо их байна.

**Хүснэгт 4. Нас, хүйсийн бүтцийг тодорхойлогч сонгосон  
үзүүлэлтүүд, Монгол Улс, 2000, 2010, 2020**

	Үзүүлэлтүүд	Он		
		2000	2010	2020
	Хүйсийн харьцаа	98,5	98,5	98,3
	Голч нас	21,6	25,4	30,2
	Хүүхдийн ачаалал	58,9	40,1	35,1
	Хөгшин насын хүн амын ачаалал	3,9	4,0	4,6
	Нийт ачаалал	62,7	44,1	39,7
	Хөгшрөлтийн индекс	6,6	10,0	13,2
	“Асран халамжлагч”-ийн харьцаа	25,2	23,6	16,6

**Эх үүсвэр:**

УСГ, 2002. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар


**Хүснэгт 5. Сонгосон зорилтот насын бүлгүүд, Монгол Улс, 2000, 2010, 2020**

Зорилтот насны бүлгүүд	Нас (жилээр)	Хүн амын тоо			Хувийн жин (нийт хүн амд эзлэх)		
		2000	2010	2020	2000	2010	2020
Нялхас	0-1	48 604	50 406	50 719	2,0	1,8	1,6
Хүүхдүүд	1-4	199 095	207 647	200 125	8,3	7,6	6,5
Бага сургуулийн нас	8-11	249 688	194 798	190 576	10,4	7,1	6,2
Дунд сургуулийн нас	12-18	406 128	371 918	360 395	17,0	13,6	11,7
Хөдөлмөрийн нас	эрэгтэй:15-59; эмэгтэй: 15-54	1 323 005	1 690 055	1 824 786	55,4	61,6	59,1
Нөхөн үргихийн насны	15-49	650 939	820 050	871 700	27,2	29,9	28,2
эмэгтэйчүүд							
Өрх толгойлох насны	22-28	158 094	195 143	186 143	6,6	7,1	6,0
эрэгтэйчүүд							
Хөгшин насны хүн ам	65 ба түүнээс дээш	82 561	109 196	147 227	3,5	4,0	4,8
Нийт хүн ам		2 389 661	2 741 774	3 087 048			

**Эх үүсвэр:**

УСГ, 2002. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар

**Зураг 5. Тооцоологдсон зорилтот насын бүлгүүд, Монгол**



#### Эх үүсвэр:

ҮСГ, 2002. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар

Энэхүү бүлгийг дараах асуултаар төгсгөх нь зүйд нийцэх болов уу. Монголын хүн амын нас, хүйсийн бүтцэд гарч буй өсөлт, өөрчлөлт нь нийгэм эдийн засгийн хөгжлийн үйл явцад ямар зэрэг нөлөөтэй байна, эсрэгээр хүн амын сайн сайхан байдал болон эдийн засгийн хөгжилд ямар нэгэн саад учруулж байна уу? Энэхүү асуултанд хариулахын тулд хүн ам зүйн ном зохиолд олонтаа дурьдагдаг боловч цөөн судлагдсан хүн амын моментум гэсэн үйл явцыг гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй юм.

#### Хүн амын моментум

Хүн амын моментум гэдэг нь хүн ам өөрөө өргэн нөхөх түвшинд хүрсний дараах үеийн хүн амын үргэлжлэн өсөх хандлагыг хэлнэ. Өнгөрсөн үеийн өндөр төрөлт нь залуу насын хүн амын өндөр хувийн жин эзллэхэд хүргэдэг. Эдгээр залуу насын хүн ам, хүүхэд төрүүлэх насандаа байх хугацаанд төрөлтийн түвшин нас баралтыг давсаар байна. Энэ насын томоохон бүлэг хүн ам хөгширч нас барснаар хүн амын моментум зогсоно. Нас баралт төрөлттэй тэнцэж эсвэл төрөлтөөс давж хүн амын өсөлт зогсонги байдалд ордог. Төрөлтийн өргэн нөхөгдөх түвшин гэдэг нь хосууд өөрсдийгөө нөхөх, хоёр эсвэл хоёроос үл ялиг илүү тооны хүүхэдтэй байх төрөлтийн түвшинг хэлнэ. Гэхдээ энэ нь яг хоёр хүүхэдтэй байна гэсэн үг бус, нас баралтыг бас тооцож тусгасан байдаг (PRB, 1998; Rowland, 2003).

Энэхүү хэсэгт Монголын хүн амын моментумыг судлах болно. Юуны өмнө Зураг 1-ийг харна уу. Зургаас харахад нөхөн үргижүүйн, ялангуяа 15-39 насын эмэгтэй хүн амын тоо түүнээс дээш насын бүлгийн эмэгтэйчүүдтэй харьцуулахад их байна. Мөн 1970-1980 аад оны ТНК 6 ба түүнээс дээш түвшинд хүрч байсан өндөр төрөлт болон нас баралтын тогтвортой бууралтын үр дүнд 10-14 насын хүн амын тоо их байна. Өмнө өгүүлсэнчлэн, сувартын суурь хэсгийн эхний 2 үелрэл нь төрөлтийн бууралттай холбоотой юм. Гэхдээ эдгээр үелрэлүүд нь төрөлтийн бууралтын хэмжээ төдийлөн их биш байгааг харуулж байна. Тухайлбал: ТНК 1990 онд 6.4 байснаа 1995 онд 2.8, 2000 онд 2.2 болж буурсан байна. (ҮСГ, 2003). Хүснэгт Зв-д 2020 оны хүн амын нас, хүйсийн бүтэц

ямар байхыг тооцоолон харуулжээ. Суваргаас харахад төрөлт тогтвортой буурч байгаа хандлага ажиглагдаж байгаа (25-29 нас) ба хэтийн тооцоонд (нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 2-с ялимгүй өндөр) таамаглагдаж байгаа шиг доогуур төрөлт биш байна. Өмнө өгүүлсэнчлэн, төрөлтийн түвшин доогуур байсан ч хүн ам одоогийн болон дараагийн 10 жилд өссөөр байх болно. Хүн амын өсөлтийн түвшин нь жилд 1 ба түүнээс дээш хувь байх бөгөөд энэхүү хандлагыг хүн амын моментумаар тайлбарлана.

Хүн амын моментумыг судлах өөр нэг хандлага бол үелрэл бүрэлдэхүүний аргаар *стационарь* хүн амын хэтийн тооцоонд үндэслэн судлах арга юм. Стационарь хүн ам гэдэг нь төрөлтийн эргэн нөхөгдөх түвшин болон нас баралт нь тогтонги хүн ам юм. Үүний үр дүнд хүн амын өсөлт нь тэг байх ба ойролцоогоор 100 жил насны бүтэц хэвээр хадгалагддаг байна. Түүнчлэн тухайн улсын хүн ам 100 жилд төрөлтийн эргэн нөхөгдөх түвшин тогтмол, нас баралт буюу дундаж наслалт тогтмол, шилжих хөдөлгөөн байхгүй гэж таамагласан үед бүхэл бүтэн зууны дараа хүн ам стационарь болох ажээ. (Rowland, 2003). Моментумын түвшинг эхний хүн амын хэмжээтэй харьцуулан тодорхойлох ба энэхүү өсөлтийг хувиар илэрхийлнэ.

Хүснэгт 6-ийн эхний баганад 2000 оны дунд үеийн тооллогын хүн амыг нас баралт нь тогтмол: дундаж наслалт эмэгтэй хүн амын хувьд 68.1, эрэгтэй хүн амын хувьд 63.8 байхаар таамаглал дэвшүүлжээ. ҮСГ-с 2000-2004 оны хүн амын хэтийн тооцоог хийхдээ нас баралтын түвшин нь ийм байхаар таамаглал дэвшүүлсэн байна. (ҮСГ, 2002). Төрөлтийн эргэн нөхөгдөх түвшин буюу нэг эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин нь 2.24 гэж таамаглагдсан. Ийнхүү таамаглал дэвшүүлсний дараагаар хэтийн тооцоо хийхэд 100 жилийн дараа хүн ам 3,769,627 болох ажээ. Үүнээс харахад 2000-2100 он хүртлэх 100 жилийн хугацаанд хүн ам 1.38 саяар буюу 57.7 хувиар өсөхюм. Энэ нь моментумын хэмжээг харуулж байна. Ерөнхийдөө, Монгол Улсын хүн амын төрөлт ба нас баралтын чиг хандлага 2000-2004 оныхтой адил байвал 100 жилийн дараа хүн ам 57.7 хувиар өснө гэсэн үг юм. Цаашилбал, төрөлт буурсан ч хүн ам 2060 он хүртэл өснө гэдгийг харуулж байна. Үүний дараагаар хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд тогтвортой байвал хүн амын өсөлт зогсох ба зарим үзүүлэлтүүд тогтвортых хандлагатай болно. Энэ нь хэрэв төрөлт одоогийн түвшинтэйгээ ойролцоо буюу одоогийн түвшнээ хадгалж чадвал хүн амын өсөлтөнд нэг их бууралт ажиглагдахгүй, өөрөөр хэлбэл хүн ам абсолют хэмжээгээрээ буурах болоогүй гэдгийг харуулж байна. Хэрэв нас баралт буурвал хүн амын моментум нь 2060 оноос цааш хүн амыг өсөхөд хүргэж болох юм.

**Хүснэгт 6. Төрөлт, нас баралтын ялгаатай түвшинд үндэслэсэн хэтийн тооцоо,  
Монгол Улс**

Он	Ялгаатай төсөөллүүд дэх хэтийн тооцоо			
	ТНК=2.24	ТНК =1.80	ТНК =2.50	ТНК =2.24
	$e(0)_{\text{эр}}=63.8$	$e(0)_{\text{эр}}=63.8$	$e(0)_{\text{эр}}=63.8$	$e(0)_{\text{эр}}=73.3$
	$e(0)_{\text{эм}}=68.1$	$e(0)_{\text{эм}}=68.1$	$e(0)_{\text{эм}}=68.1$	$e(0)_{\text{эм}}=78.0$
2000	2 389 661	2 389 661	2 389 661	2 389 661
2010	2 746 436	2 649 330	2 803 642	2 825 826
2020	3 136 387	2 928 155	3 259 144	3 309 833
2030	3 422 935	3 090 119	3 625 108	3 707 207
2040	3 606 277	3 105 974	3 922 593	4 020 622
2050	3 725 150	3 035 615	4 175 251	4 270 352
2060	3 758 922	2 871 846	4 359 273	4 426 269
2070	3 752 880	2 655 586	4 525 889	4 528 888
2080	3 766 454	2 466 725	4 720 765	4 646 275
2090	3 773 774	2 298 010	4 909 437	4 761 349
2100	3 769 627	2 124 851	5 099 169	4 861 861


**Эх үүсвэр:** 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо-нд үндэслэн судлаачдын хийсэн хэтийн тооцоо

Хүснэгт 6-ийн хоёр дахь баганад төрөлтийн түвшин доогуур буюу ТНК 1.8 байх үед хүн ам хэрхэн өөрчлөгдхийг тооцож үзье. Харин төрөлтөөс тооцсон дундаж наслалтыг өмнөх тооцоололтой адил байхаар таамаглал дэвшүүллээ. Энэ үед хүн ам моментумаараа 2040 он хүртэл өсөх бөгөөд энэ хугацаанд хүн ам 716,313-р нэмэгдэх ба өсөлтийн хувь 30 байх ажээ. 2040 оны дараагаас хүн амын бууралт ажиглагдаж эхэлнэ. Гэхдээ энэ нь хүн амын төрөлтийн түвшин доогуур байсан ч хүн ам 40 жилийн туршид өснө гэдгийг харуулж байна. Хүснэгт 6-н 3-р баганад ТНК-г 2.5 байхаар таамаглав. Харин дундаж наслалтыг өмнөх 2 тооцоололтой адилхан байхаар төсөөллөө. Энэ тохиолдолд хүн ам энэ зууны төгсгөл гэхэд 5 саяд хүрэх ажээ. Хүснэгт 6-н 4-р баганад ТНК нь одоогийнхтой адилхан түвшинд буюу нэг эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин 2.24, харин төрөлтөөс тооцсон дундаж наслалт эрэгтэйчүүдийн хувьд 73.3, эмэгтэйчүүдийн хувьд 78.0 байна гэж төсөөлсөн. Дундаж наслалтыг ийнхүү авсан нь санамсаргүй зүйл биш бөгөөд, ҮСГ-аас хийсэн 2025 оны Улаанбаатар хотын хүн амын дундаж наслалтын хэтийн тооцооллыг ашигласан. Өөрөөр хэлбэл, эрүүл мэнд, боловсрол, сайн сайхан байдалд хангалттай хөрөнгө оруулалт хийхийн тулд хүн амыг хэд хүргэх вэ гэсэн асуултын хариу юм. Энэхүү таамаглалын үндсэн дээр хүн амын ирээдүйн хэмжээг тодорхойлбол 2100 онд 4.9 сая болох ажээ.

Хүснэгт 6-ийн 3 ба 4-р баганын хувьд нэг нь зөвхөн төрөлт өссөн үед, нөгөө нь зөвхөн нас баралт буурсан үед хүн ам хэд болохыг харьцуулахад ихээхэн ач холбогдолтой. Таамаглагдаж буй төрөлтийн өсөлт нь төдийлөн өндөр биш юм. Ихэнх улс орнуудын жишгээс харахад хэрэв төрөлт буурвал түүнийг эргэж нэмэгдүүлэхэд нэлээд төвөгтэй

байдаг. (Weeks, 2002). Өндөр хөгжилтэй боловч төрөлтийн түвшин нь доогуур байгаа улс орнуудад төрөлтийг аль болох нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлдэг байна. Эдгээрийг З хэсэгт ангилан үзэж болно. Үүнд: Санхүүгийн дэмжлэг/туслалцаа үзүүлэх, албан байгууллага, нийгэмд эцэг эхийг нь дасган төлөвшүүлэх, хүүхэд болон эцэг эхэд нийгмийн талаас нь тусламж үзүүлэх зэрэг багтана. (McDonald, 2002). Дээрх арга хэмжээнүүд нь харьцангуй зардал ихтэй. Жишээлбэл, санхүүгийн тусламж нь гэр бүлд төдийгүй хүүхдүүдэд олгогддог. Хүүхэд асарсны тэтгэмж нэлээд өндөр өртөгтэй. Мөн эцэг, эхчүүдийн хүүхдээ асарч байх хугацаанд төлөгдөх нийгмийн хамгааллын төлбөр нэлээд өндөр өртөгтэй. Монголтой адил улс орны хувьд дээрх про наталист арга хэмжээнүүдэд зарцуулах нөөцийг нийгмийн үйлчилгээг сайжруулж, өргөжүүлэх, дэд бүтцэд хөрөнгө оруулах чиглэлээр ашиглаж болох юм. Энэхүү төсөөлөл нас баралт буурна гэж таамаглагдсан. Хүн амын төрөлт эргэн нөхөгдөх түвшиндээ байвал 2100 он гэхэд хүн ам 5 саяд хүрнэ. Хоёр таамаглалыг харьцуулбал, 2070 он хүртэл нас баралт буурсан гэж таамаглаж буй (4 дэх төсөөлөл) төсөөллөөр тооцоологдсон хүн ам нь төрөлт өсөж, нас баралт тогтвортой байна гэсэн таамаглалын үндсэн дээр тооцоологдсон хүн амаас (3 дахь төсөөлөл) илүү өссөн байна. Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, нийгмийн эмзэг бүлгийнхний амьжирааны түвшинг дээшлүүлэх зэрэг нь юуны өмнө нас баралтыг бууруулах ба энэ нь про наталист бодлогоос бага зардалтай байх болно. Улмаар энэ нь хүн амын өсөлтийг хангах бөгөөд илүү мэдрэмжтэй, зөв, оновчтой бодлоготой байхыг харуулж байна.

Зураг 6-д таамаглагдаж буй 4 төсөөлөл дэх хүн амын өөрчлөлтийг дүрслэн харуулав. Гурав ба 4 дэх төсөөллийн дагуу тооцоолсон хүн ам өрөнхийдөө ойролцоо байна. Өмнө үзсэнээр, зөвхөн 2070 онд төрөлтийн эргэн нөхөгдөх түвшин нь өндөр байхаар төсөөлөн тооцоолсон хүн ам нь нас баралтын түвшин доогуур байна гэж төсөөлөн тооцоолсон хүн амаас ялимгүй илүү гарахыг харж болно.



**Эх үүсвэр:** 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо-нд үндэслэн судлаачдын хийсэн хэтийн тооцоо

Энэ нь стационарь хүн амын загварыг ашиглан бодит байдлыг тодорхойлж буй судалгаа юм. Бодит хүн ам нь загвараар тодорхойлгэсэнтой адил байх нь цөөн бөгөөд, түүнээс хэр зэрэг ялгаатай байх эсэх нь нэлээд сонирхолтой байдаг. Энэхүү шинжилгээний

Үр дүн нь төрөлт одоогийн доогуур түвшиндээ хадгалагдаж, эсвэл одоогийнхоосоо илүүтэй буурсан ч Монгол Улсын хүн ам өсөх болно гэдгийг харуулж байна. Түүнчлэн, төрөлтийг өсгөхөөс илүү нас баралтыг тогтвортой бууруулах нь хүн амыг өсөлтийг хангахад чухал нөлөөтэй байна.

## Хэлэлцүүлэг

Хүн амын өсөлтийн тухайн түвшингээ хэвээр хадгалах эсвэл дэмжих бодлого баримталдаг улс орнуудыг хоёр бүлэгт хувааж болох юм. Эхний бүлэгт төрөлт бага, хүн амын өсөлт удаан, өндөр хөгжилтэй Европ, Хойд Америкийн орнууд, түүнчлэн Япон зэрэг улсууд багтана. Засгийн газрууд нь хүн амынхаа өсөлтийг эдийн засгийн дутагдаж буй хүчин зүйл гэдгийг хүлээн зөвшөөрч, ажиллах хүчний хомсдол, одоо болон ирээдүйд улам өсөх хандлагатай байгаа тэтгэврийнхэн буюу өндөр настны тоо нэмэгдэж байгааг олж хараад байна. Хоёр дахь бүлэг нь хуучинсаг, гэр бүлийн талаархи уламжлалт ойлголт ноёрхдог, мөн үндэсний зорилтоо биелүүлэхэд хүн амын удаан өсөлт нь сөрөг нөлөөтэй гэсэн байр сууринаас хүн амынхаа өсөлтийг бага гэж үздэг, хөгжиж буй орнуудын төлөөлөл юм (Weeks, 2002). Хөгжиж буй зарим улсуудад төрөлтийг дэмжих пронаталист бодлогыг хуульчилсан байдаг ч бодлогын хэрэгжилтэнд хүн ам зүй, нийгэм, эдийн засаг, экологийн талаас нь судлан шинжилж, бодит үндэслэлтэй хандах нь чухал юм. Манай орны хувьд, гурван гол асуудлын хүрээнд анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.

Юуны өмнө хөгжиж буй орнуудын хувьд нэн тэргүүнд хүн амын өсөлт ба эдийн засгийн хөгжлийн хоорондын харилцан хамаарал байгааг авч үзэх нь чухал. Энэхүү харилцан хамаарлыг гурван асуултаар хураангуйлан нэгтгэж болох юм (Weeks, 2002). Үүнд:

Хүн амын өсөлт эдийн засгийн хөгжлийг хурдасгах уу?

Хүн амын өсөлт нь эдийн засгийн хөгжилтэй хамааралгүй юу?

Хүн амын өсөлт нь эдийн засгийн хөгжилд хохирол үзүүлэх юу?

Хүн амын өсөлт ба эдийн засгийн хөгжил гэсэн хоёр хувьсагчийн хоорондын хамаарлын талаар хийгдсэн олон судалгаануудад энэхүү хамаарал эерэг, зарим нь сөрөг, нэг хэсэг нь бүр харилцан хамааралгүй болох тухай дүгнэсэн байдаг (Cassen, 1994). Нэлээд сүүлийн үеийн судалгаанууд уг асуудлыг дан ганц макро эдийн засаг талаас нь бус микро түвшинд илүү маргаантай байгаа асуудал болгон авч үзэж байна. Тухайлбал, хүн амын өсөлтийн ядууралд үзүүлэх үр нөлөө, эмэгтэйчүүдийн үүрэг, эрүүл мэнд, хүний нөөцийн хөгжил, байгаль орчин, шилжих хөдөлгөөн зэрэг асуудлуудыг хөндөж судалсан байдаг. Ихэнхи судалгааны үр дүн төрөлтийн түвшин өндөр хөгжиж буй орнуудын хөгжлийн олон зорилтуудад хүн амын хурдан өсөлт нь сөрөг нөлөөтэй болохыг харуулсан байдаг. Энэ нь төрөлт болон хүн амын өсөлтийн бүх түвшинд, бүхий л цаг хугацааны туршид улс орнуудын баялаг, тэдгээрийн хүн амын хэмжээг үл тоомсорлосон болон хөгжлийн бүхий л аспектуудад хамаагүй гэсэн үг биш юм. Гэхдээ ерөнхийд нь авч үзвэл олонхи судалгаанууд хөгжлийн олон зорилтууд нь бага төрөлтийн түвшин, хүн амын удаан өсөлтийн үед илүү амжилттай хэрэгжинэ гэж дүгнэсэн байдаг (Cassen, 1994).

Хүүхэд болон өсвөр үеийнхний хувийн жин өөрчлөгдөж, өсөлт хурдацтай буурах тохиолдолд манай орны хөгжил болон гэр бүлийн сайн

сайханд ашигтай байж магадгүй юм. Хүн амын ачаалал эрүүл мэнд, боловсролын системд бага туссанаар хүн амд хүргэх үйлчилгээ сайжрахаас гадна газар зүйн болон нийгмийн бүлгүүдийг илүү өргөн цар хүрээтэй хамрах боломжтой болно. Өрхийн түвшинд, гэр бүлүүд олон хүүхдэд санхүүжилт хийхийн оронд өөрсдийн сайн сайхан амьдралын төлөө хөрөнгө оруулах боломжтой болно.

Энэ 10 жил болон ирэх 10 жилд манай улсын хүн амын насны бүтэц эдийн засгийн үйл явцад нэн таатай нөлөөтэй байх болно гэсэн байр сууринеас асуудалд хандах нь чухал юм. Нийт хүн амын дотор хүүхэд насны хүн амын эзлэх хувийн жин багасч, өндөр настны эзлэх хувийн жин төдийлэн нэмэгдэхээргүй байна. Үүнтэй уялдан нийгмийн бусад зардлуудад зориулагдаж буй нөөцийг улс орныхоо дэд бүтцийг сайжруулахад шууд зарцуулах боломж бүрдэж байгаа юм. Түүнчлэн хөдөлмөрийн насны хүн амын тоо нэмэгдэх болно. Эдийн засгийн хөгжлийн хурдац нэмэгдэхийн хэрээр ажиллах хүчний нөөцийг үр дүнтэй эргэлтэд оруулж эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг бий болгоно. Хүн ам зүйн ийм үе шатыг эерэг утга агуулгаар нь “хүн ам зүйн урамшуулал” гэж нэрлэдэг.

Манай улсын өнөөгийн болон ирээдүйн хүн амын насны бүтэц нь Азийн олон улс, орнуудын нэгэн адил эдийн засгийн хөгжлийн үйл явц эрүүлжих нөхцөл “хүн ам зүйн урамшуулал” болж болохоор байна. Гэхдээ манай улсын эдийн засгийн уламжлалт үндэс суурь нь нүүдлийн мал аж ахуй гэдгийг анзаарч үзвэл, энэ салбарт ядуу малчдыг бий болгохгүйгээр хөдөлмөр эрхлэх насны хүн амыг шингээх өсөх, байгаль орчны сөрөг үр дагаврууд, албан бус секторын хамгийн доогуур зэрэглэлд амь зууж буй хот руу шилжин ирэгчдийн түлхэж буй хүчин зүйлсийг арилгах зэрэг асуултууд гарч болох юм. Мал аж ахуйн эсвэл эдийн засгийн бусад салбарт ирээдүйн ажиллах хүчнийг шингээх үр дүнтэй ажил эрхлэлтийг бий болгох хангалттай хөрөнгө оруулалт орж ирэх үү? Уг асуултанд бидний хийсэн судалгааны ажил хариулт өгөх боломжгүй хэдий ч эдгээр нөхцөл байдалд нухацтай судалгаа, шинжилгээний ажил хийх шаардлагатай байна.

Хоёр дахь чухал сэдэв нь хүн амын моментум юм. Өмнөх хэсэгт өгүүлсэнчлэн төрөлтийн түвшин бага боловч хүн амын өсөлт үргэлжлэх болно. Үүнтэй уялдан тодорхой түвшинд хүртэл Монголын хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх нь зайлшгүй юу эсвэл үгүй юу гэсэн асуулт гарч байна. Хэрвээ төрөлт эргэн нөхөгдөх түвшиндээ хэвээр байвал дараагийн 50 жилийн туршид хүн ам үргэлжлэн өссөөр байх талаар өмнөх хэсэгт харуулсан билээ. Энэхүү өсөлт нь нас баралтын эрчимтэй болон тогтвортой бууралтын үйл явцтай зэрэгцэх болно. Иймд манай орны хувьд хүн амын өсөлтийн асуудал улс орны төлөвлөсөн ашиг сонирхлоос илүү байх уу? Өөрөөр хэлбэл, хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх төрөлтийн пронаталист бодлого нь манай орны хувьд чухал гэж үзэж болох уу? гэсэн дараагийн логик асуулт гарч ирнэ. Бүлгийн эхэнд авч үзсэн нэг дэх асуудлын адилаар энэ удаа бүрэн төгс хариулт өгөх боломжгүй юм. Гэхдээ энэ сэдвийг судлах, хэлэлцүүлэх нь чухал байна.

Хүн амын хурдацтай өсөлт хөгжилд тустай гэж үзэх зарим нэг үндэслэл байдаг. Европ болон АНУ-ын хөгжлийн түлхүүр нь хүн амын түргэн болон зохистой өсөлт байв. Зарим түүхчдийн үзсэнээр Европ дахь аж үйлдвэрийн хувьсгалын томоохон хүчин зүйл нь нас баралтын бууралт, түүнээс үүдэлтэй хүн амын өсөлт байсан юм. Түүхэн талаас нь

өнөөгийн аж үйлдвэржсэн орнуудын хөгжилд хүн амын өсөлтийн зерэг нөлөөг олж харж болох боловч тэдгээр орнууд болон өнөөгийн хөгжиж буй улс, орнуудын хооронд асар их ялгаа байгаа билээ. Өнөөдөр хөгжил буурай орнууд хөгжингүй орнуудын хөгжлийн үе шатыг нь давтахгүй байна. Тухайлбал, хөгжилтэй орнуудын хөгжлийн алхмаа эхэлж байсан үетэй харьцуулахад ажлын байр бий болгох хөрөнгө, санхүүжилтын хэмжээ өнөөдөр хэд дахин их байна. Хөгжингүй орнуудын түүхийн харьцуулж болох үе шатанд байгаа өнөөгийн буурай хөгжилтэй орнууд эдийн засгийн өсөлтийн хувьд тухайн үеийнхээс хавьгүй илүү байгаа ба харин хүн амын өсөлт нь харьцангуй өндөр байна. Өөрөөр хэлбэл, хөрөнгө шингээлт ихтэй технологи, хүн амын хурдан өсөлт нь ажлын байрыг бий болгох шалгарсан арга зам биш бөгөөд тогтвортой хөгжлийн үйл явцыг хангахгүй болох нь харагдаж байна. Нийгэм, эдийн засгийн хөгжлийг хүн амын өсөлтөөр дэмжиж байхын тулд хүн амын өсөлт тодорхой бүтэц, зааг хязгаарт багтаж, тэрхүү бүтцийн болон удирдлага зохион байгуулалтын орчноос хамаарч хүн амын өсөлтийн зерэг, сөрөг нөлөө илрэх болно. Иймд агуулгын энэ тал болон хүн амын өсөлтийн хооронд харилцан хамаарлыг цогц байдлаар системтэйгээр судлах нь хамгаас чухал юм.

Эдийн засгийн хөгжлийн эхлэл нь хөрөнгө оруулалт гэдэгт анхаарах нь чухал юм. Хөрөнгө нь зөвхөн тоног төхөөрөмж, барилга байшинд бус, харин хүний капиталд тухайлбал, боловсрол, эрүүл мэнд, мэдлэг олж авах, хэрэгжүүлэхэд зарцуулагдах хэрэгтэй. Эдийн засгаа өсгөхийн тулд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ёстой. Хүн амын өсөлтийн өндөр түвшинд хөрөнгө оруулалтын өндөр түвшин байх ёстой. Хэрвээ тухайн улс орны хүн амын өсөлт нь хөрөнгө оруулалтын түвшингээс давж байвал тэр улс орон ядуурлын тойргоос гарч чадахгүй. Эдийн засгийн өсөлт нь олон хүнийг тэжээж чадах хэдий ч ядуурлаас бүгдийг нь хамгаалахад хүрэлцэхгүй (Weeks, 2002; Leibenstein, 1957). Иймд өнөөгийн хөгжил буурай орнуудад олон хүн ам бус харин хүний нөөцийн чанар илүү чухал бөгөөд аливаа зорилгоо цөөн хүн ам дээр л хэрэгжүүлж чадна.

Гурав дахь сэдэв бол хөгжиж байгаа орны төрөлтийг дэмжих бодлогын бодит үр нөлөөг авч үзэх болно. Дээр дурьдсанчлан төрөлтийг нэмэгдүүлэх бодлого нь өртөг ихтэй байхаас гадна үр дүн нь тун эргэлзээтэй байдаг. Энд таван жишээг эргэцүүлэн авч үзье.

Сингапурын Засгийн газар 1965 онд тусгаар тогтолынхoo дараа эхлээд гэр бүл төлөвлөлтийн арга дээр суурилсан төрөлтийг бууруулах хүчтэй бодлогыг, дараа нь хоёр ба түүнээс олон хүүхэдтэй хосуудын тоог аажмаар бууруулах бодлогыг баримталжээ. Сингапурын төрөлтийн нийлбэр коэффициент (THK) буюу нэг эмэгтэйн төрүүлсэн дундаж хүүхдийн тоо 1966-1985 оны хооронд 4.5-1.5 хүүхэд хүртлээ буурсан юм. Эдийн засаг, нийгэм, улс төрийн олон янзын нөхцөл байдлын улмаас Засгийн газар нь төрөлтийг дэмжих эрчимтэй арга хэмжээнүүдийг авахаар бодлогоо өөрчилсөн байна. Гол санаа нь ажил эрхэлж байгаа эхчүүдэд хүчтэй дэмжлэг үзүүлэхүйц гэр бүлийг дэмжих бодлого байв. Засгийн газраас ажил эрхэлж буй эхэд нийтлэг татварын хөнгөлөлт үзүүлэх, ажил олгогчдын зүгээс хүүхэд нь өвдсөн үед асарч байгаа эхчүүдэд тусгай чөлөө олгох, мөн төсвөөс хүүхдийн асаргааны мөнгийг аль болох нэмэгдүүлэхэд анхаарч байв (Тармужи, 1999). Энэ бүх арга хэмжээний зорилго нь төрөлтийг эргэн нөхөгдөх түвшинд хүртэл нь нэмэгдүүлэх явдал байжээ. Гэвч энэ зорилго биелэгдээгүй бөгөөд 1990-

ээд оны сүүл гэхэд ТНК 1.8 болж өсчээ. Энэхүү өсөлт нь залуу насын эмэгтэйчүүд төрөлтөө хойшлуулсантай холбоотой байж болох юм. 2000 оны байдлаар нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо буюу ТНК=1.5 болтлоо эргээд буурсан байна (Weeks, 2002).

Хуучнаар Бүгд Найрамдах Ардчилсан Герман улсад 1976 онд төрөлтийг урамшуулах нэлээд хэдэн арга хэмжээ авагджээ. Тухайлбал, хүүхэд төрүүлсэн эхчүүдэд цалингийнх нь 70-80 хувьтай тэнцэх тэтгэмж, нийгмийн бусад тэтгэлэг олгохын зэрэгцээ төрсний дараа нэг жилийн хугацаатай амралт эдлүүлж байв. Гэсэн хэдий ч зарим эмэгтэйчүүдийн гэрлэлт нэмэгдсэн атал төрөлт нэмэгдээгүй юм (van de Kaa, 1987; Monnier, 1990).

Франц нь дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад урт хугацааны туршид төрөлтийн бага түвшинтэй байсан юм. Францын Засгийн газраас 2 ба түүнээс дээш хүүхэдтэй хосуудад сар бүрийн тэтгэлэг олгож байсан ч уг тэтгэлэг төрөлтөд нөлөөлж буй эсэхийг бодитой илэрхийлэх боломжгүй байна. Ганц бие эхчүүд мөн нэгэн адил сар бүрийн тэтгэлэг улсаас авдаг ба Францын бүх эхчүүд хүүхдээ 3 нас хүртэл нь хүүхэд асрах газраар үйлчлүүлж, хүүхдээ өсгэхийн зэрэгцээ ажлаа ая тухтай хийх нөхцлөөр хангагдсан байдаг байна (Bergman, 1996). Ийм аргаар төрөлтийг нэмэгдүүлэх үр нөлөө хангалттай биш боловч ТНК 1.8 болоход хувь нэмэр үзүүлсээр байгаа ба Европ дотроо хамгийн өндөр төрөлттэй орны нэг болоод байна.

Урьдчилан тооцоогүй хүчин зүйлүүдийн улмаас төрөлтийг дэмжих бодлого амжилтанд хүрэхгүй байх тохиолдол байдаг. Жишээ нь Чилид 1970-80 оны үед Пиночетийн засгийн газар үндсээрхэг үзэл санааны үүднээс хүн амаа өсгөх тухай уриалсан байна. Харамсалтай нь үйл явдал эсрэгээр эргэжээ. 1973 оны цэргийн эргэлтээр Аллендегийн Засгийн газар унасны дараа Пиночетийн засаг захиргаа татварын журмыг чангатгаснаар орлого зогсож, ажилгүйдлийн түвшин нэмэгдсэн байна. Үүнтэй уялдан гадагш шилжих хөдөлгөөн, орой гэрлэлт нэмэгдэж, гэрлэгчид жирэмслэлтээс сэргийлэх арга, хэрэгслийг өргөн хэрэглэх болжээ. Хүн ам өсөөгүй нь ойлгомжтой бөгөөд харин бууралтын үйл явц үргэлжилсэн байна.

Төрөлтөө бууруулах хүн амын шийдвэр дэх нөхөн үржихүйн зан үйлийг өөрчлөх нь нэлээд хүндрэлтэй байдаг. 1996 онд Румыны Засгийн газар хүн амын төрөлт бууралтын хандлагыг зогсоохын тулд үр хөндөлтийг хориглосон бодлого гаргасан боловч хууль бус үр хөндөлт хийгдсээр байв. Түүнчлэн Засгийн газар гаднаас импортоор орж ирсэн жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэхийг хориглосон байна. Богино хугацаанд төрөлтийн түвшин өссөн боловч 1987 онд нууцаар үр хөндүүлэх явдал нэмэгдэж эхэлсэн төдийгүй гэр бүл төлөвлөлтийн бусад аргуудын /ихэвчлэн хуанли хөтлөх, угаалга хийх/ хэрэглээ нэмэгджээ. 1966 онд ТНК 1.9 байснаа 1989 онд 2.3 болж бага зэрэг нэмэгдсэн байна. Румыныг удаан хугацаагаар удирдсан Николай Чеуйжескугийн засаглал 1989 онд төгсгөл болж, эрх мэдлийг өөрчилсөн юм. Шинэ Засгийн газрын анхны хууль эрх зүйн баримт бичиг нь эхийн эндэгдлийг бууруулах зорилгоор үр хөндөлтийг хуулиар зөвшөөрсөн явдал байв (Serbanescu, et al. 1995). 2000-аад оны эхэн гэхэд ТНК 1.3 болж буурчээ.

Эдгээр жишээнүүд нь нэгэнт буурчихсан төрөлтийн түвшин, ялангуяа нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшинд ойр байгаа төрөлтийн түвшинг нэмэгдүүлэхэд хэр төвөгтэй болохыг илтгэн харуулж байна. Төрөлтийг дэмжих Засгийн газрын бодлогууд нь өртөг зардал их, бага

байхаас үл хамааран төрөлтийн түвшинг үл мэдэг нэмэгдүүлдэг эсвэл огт нөлөөгүй байдаг байна.

Аль ч тохиолдолд, улс орон хүн амаа өсгөх нь зөв зүйтэй боловч ялангуяа нөөц хязгаарлагдмал болон хүчтэй хүн амын моментум тогтсон манай улсын хувьд дээр хэлэлцсэн З асуудлыг маш анхааралтай авч үзэх нь чухал юм.

## Дүгнэлт

Хуучин социалист байсан олон улс оронд төрөлтийн бага түвшин нь нэг талаас гэр бүл дэх эдийн засгийн хязгаарлагдмал байдал ялангуяа орон сууц, бараа таваарын хомсдлын хариу үйлдэл, нөгөө талаас эмэгтэйчүүдийн боловсрол, ажиллах хүчний оролцоонд онцгой анхаарах болсны үр дүн юм. Манай улсын хувьд төрөлтийг дэмжих хүчтэй бодлогын үр дунд хүн ам 1970-1980-аад оны үед маш эрчимтэй өссөн билээ. Гэсэн хэдий ч эдийн засгийн бэрхшээлтэй байдлаас үүдэн төрөлт буурч эхэлсэн. Бодлого боловсруулагчдын цөөнгүй хэсэг нь улс орны хүн ам зүйн өнөөгийн байдал нь эдийн засгийн хөгжлийг хангахуйц байх ёстой гэсэн өөр ойлголт, үзэл бодолтой байдаг. Улс орны эдийн засаг, нийгмийн бүтэц нь төрөлтийг нэмэгдүүлснээр хүн амын өсөлтийг бий болох хангалттай түвшинд хүртлээ хөгжөөгүй байна гэж хэлж болох юм. Хүн амын байдлыг үндсэргэх төлөв байдлын үүднээс авч үзвэл цөөн, чадварлаг, боловсролтой, эрүүл хүн ам нь тооны хувьд олон, чанаргүй, боловсролгүй, эрүүл мэнд дорий хүн амаас илүү чухал юм.

Монголын өнөөгийн болон ирээдүйн хүн амын маргаантай асуудлууд нь улс орны эдийн засгийн салбар, мал аж ахуйн эдийн засгаас үл хамааран өнгөрсөн үеийн төрөлтийн өндөр түвшний үр дунд хөдөлмөрийн насны хүн амын тоо олон байхад оршиж байна.

Төрөлтийг нэмэгдүүлэхэд нөөцийг дайчлахаасаа илүү хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулах, нас баралтыг бууруулах, ядуурлыг бууруулахад хөрөнгө оруулалт хийх нь ач холбогдолтой юм. Түүнчлэн академик болон судалгааны байгуулагууд улс орны хэмжээнд төрөлтийг нэмэгдүүлэх бодит боломж, түүний үр дагаврыг шинжлэх ухаанлаг талаас нь судлан шинжлэх шаардлагатай байна. Сэдвийн маргаан нь хийсвэр үзэл санаа дээр бус бодит баримт дээр үндэслэсэн байх хэрэгтэй.

## Номзүй

1. ҮСГ, 1994. Монгол Улсын хүн ам, Улаанбаатар
2. ҮСГ, 2001. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Үндсэн үр дүн, Улаанбаатар
3. ҮСГ, 2002. 2000 оны Хүн ам Орон сууцны улсын тооллого: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар
4. ҮСГ, 2003. Монгол Улсын статистикийн эмхэтгэл, Улаанбаатар
5. Bergman, B. R. 1996. Хүүхдийг ядуурлаас хамгаалах нь: АНУ Франц улсаас чухам юуг суралцаж болох вэ. Нью-Йорк, АНУ

6. Cassen, R. 1994. Хүн ам ба хөгжил: Хуучин маргаан, шинэ тохиролцоо. Нью Брунсвик, АНУ, хуудас 1-26
7. Leibenstein, H. 1957. Эдийн засгийн буурай хөгжил ба өсөлт. Нью-Йорк, АНУ
8. Monnier, A. 1990. “БНАГУ-ын гэр бүл төлөвлөлтийн бодлогын үр нөлөө: дахин-хувьсал”. Хүн ам сэтгүүл (Англи хэл дээр), эмхэтгэл 2, хуудас 127-140
9. Neupert, R. 1996. "Монгол Улсын хүн ам ба бэлчээрийн эдийн засаг" Ази-Номхон далайн бүсийн хүн амын сэтгүүл , эмхэтгэл 11, дугаар 4, хуудас 27-46
10. PRB (Хүн амын лавлах товчоо) Хүн амын гарын авлага (4 дэх хэвлэл). Вашингтон, АНУ
11. Rowland, D. T. 2003. Хүн ам зүйн ойлголт ба арга загварууд. Оксфорд, Англи
12. Serbanescu, F., L. Morris, P. Stupp, A. Stanescu. 1995. “Румын улсын үр хөндөлт ба ЖУСХ-ийн хэрэглээний талаарх одоогийн бодлогын үр нөлөө”. Гэр бүл төлөвлөлтийн судалгаа сэтгүүл, эмхэтгэл 26, хуудас 76-87.
13. Van de Kaa, D. 1987. “Европын улс орнуудын хоёр дахь хүн амын зүйн шилжилт”. Хүн амын эмхэтгэл. эмхэтгэл 42, дугаар 1, хуудас 1-57
14. Weeks, J. 2002. Хүн ам. Ойлголт ба Асуудлууд. (8 дахь хэвлэл) Белмонт, АНУ

## УЛААНБААТАР ХОТОД ШИЛЖИН ИРЭГСДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТЭНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ

Б.Нарантулга  
Эдийн засгийн магистр, МУИС, ЭЗС,  
ХАССТ-ийн судлаач/ ЭША

*Хот хөдөөгийн хөгжлийн ялгаа, үүнээс улбаалан хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн нэмэгдэж, хотжих хөдөлгөөн эрчимтэй явагдаж байгаа энэ үед шилжих хөдөлгөөнд оролцоход хургэж байгаа хамгийн гол шалтгаан нь ажил эрхлэх, амьжиргаагаа дээшлүүлэх явдал болоод байна.*

Ажил эрхлэлт нь хүн амын орлого, хэрэглээ, боловсрол, эрүүл мэндийн байдал, цаашлаад амьжиргааны түвшинд шууд нөлөө үзүүлдэг хүчин зүйл учраас шилжигсдийн хувьд ажил эрхлэлтийн байдал ямар байгаа нь нэлзээд анхаарал татсан асуудал юм.

Судлаач энэхүү ажилдаа шилжих хөдөлгөөнд оролцогчдыг хүлээн авч буй хамгийн гол бус болох Улаанбаатар хотод шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтийн байдал ямар байна, ажил эрхлэлт тэдний ахуй, амьдралд хэрхэн нөлөөлж байна гэсэн асуултанд хариулт өгөхийг зорьсон байна.

Түүнчлэн 2000 онд Монгол Улсын Засгийн Газрын хүсэлтээр НҮБХАС санхүүгийн дэмжлэг үзүүлэн МУИС-ийн ХАССТ-өөс явуулсан “Монгол Улсын Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа”-ны мэдээллийг ашиглан гүнзгийрүүлсэн шинжилгээ хийж, нийслэлд шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтэнд нөлөөлөгч хүчин зүйлүүдийг тодорхойлжээ.


...”Хүн ам, байгаль орчин, хөгжлийн асуудал нь асар өргөн цар хүрээтэй, үнэндээ бол хотжилттой холбогдсон асуудал юм. Өөрөөр хэлбэл, “хүн төрлөхтний оршин суух явдал дахь амьдралын чанарыг сайжруулах” нь хотжилтын хурдац, хотын хүн амын хэт их төвлөрөл, түүнээс үүсэх үр дагавраар хүн амын байршил, тархалт, тоо хэмжээ, нас, хүйсийн бүтэц болон бусад үзүүлэлтүүдэд өөрчлөлт гарч байлаа.

Монгол Улсын хүн амын шилжих хөдөлгөөн нь улс орны түүх, нийгэм, эдийн засгийн хөгжлийн үеүдтэй нягт холбоотой байсаар ирсэн бөгөөд түүний шууд үр дагавраар хүн амын байршил, тархалт, тоо хэмжээ, нас, хүйсийн бүтэц болон бусад үзүүлэлтүүдэд өөрчлөлт гарч байлаа.

Манай улсын хувьд хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн нь цоо шинэ асуудал биш бөгөөд, 1940-өөд оноос нийслэл болон төв суурин газруудад засаг захиргааны нэгжүүд төвлөрч, үйлдвэр, аж ахуйн нэгжүүд олноор байгуулагдан, тэдгээрт ажиллах хүч шаардагдаж эхэлснээр хөдөөнөөс хотод шилжин суурьших явдлыг дэмжиж, улмаар хотод шилжин суурьших нэхцлийг бүрдүүлсэн юм. (“Хүн ам ба Хөгжил” Дээд хэмжээний уулзалт, 2001 он) Тухайн үед шилжих хөдөлгөөнийг хянан, ажлын байрны эрэлт хэрэгцээтэй уялдуулж байснаас ажиллах хүчний тархалт, байршилтын асуудал зүй зохистойгоор шийдвэрлэгдэж байлаа. (Хүн Ам ба Хөгжил Дээд хэмжээний уулзалт, 2001 он)

Харин зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр нийгэм, эдийн засгийн тогтолцооны өөрчлөлт, бус нутгийн хөгжлийн ялгавартай байдлаас хамааран төвийн бүсийн аймаг, хотууд, ялангуяа Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн эрчимтэй явагдаж, 1995-2000 оны байдлаар шилжих хөдөлгөөнд оролцсон 10 хүн тутмын 6 нь Улаанбаатар хотод оршин сууж, тус хотын 5 ба түүнээс дээш насны нийт хүн амын 15 орчим хувийг бүрдүүлжээ. (ҮСГ, 2001 он)

**Зураг 1. Шилжих хөдөлгөөний түвшин, бүсээр,  
1995-2000 он**



**Эх сурвалж:** УСГ, Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогоо,  
Статистикийн эмхэтгэл

Зураг 1-с харахад Баруун болон Төвийн бүсийн хүн ам шилжих хөдөлгөөнд хамгийн ихээр өртсөн бөгөөд Улаанбаатараас бусад бүх бүс нутагт шилжин явсан хүн ам нь шилжин ирснээсээ эрс их байна.

Улаанбаатар хотод хүн ам ихээр шилжин ирж, суурьшиж байгаатай холбоотойгоор хүн амын жилийн дундаж өсөлт бусад бүсээс харьцангуй өндөр байна. (Зураг 2)

Улмаар шилжих хөдөлгөөний энэхүү урсгал ойрын 5 жилд буурахгүй, зөвхөн Улаанбаатар хотод л цэвэр шилжих хөдөлгөөний эерэг утга ажиглагдах болжээ. (УСГ, 2002)

ХАССТ-с явуулсан судалгааны үр дүнгээс харахад, судалгаанд хамрагдсан нийт хүн амын 1/4 орчим нь дахин шилжих хүсэлтэй байгаа ба тэдний 40 орчим хувь нь нийслэлд шилжин суурьшихаар төлөвлөж байгаагаас хүн амын ирээдүйн шилжилтийн хамгийн гол бүс нь Улаанбаатар хот хэвээрээ байх нь гэж дүгнэж болно. Энэ нь Улаанбаатар хотын татах хүчин зүйлүүд буюу дэд бүтэц, харилцаа, холбооны хөгжил, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний хангамж зэрэг хүчин зүйлээс хамаарч байна.


Тухайлбал, 2000 оны байдлаар Монгол улсын нэг хүнд ногдох ДНБ жилд 420 мянган төгрөг байхад, Улаанбаатар хотын оршин суугчдын хувьд энэ үзүүлэлт 680 мянга орчим төгрөг байгаа ба Дархан-Уул, Орхон аймгийг оруулахгүйгээр авч үзэхэд бусад аймгуудаас 2.3 дахин өндөр үзүүлэлт байна. (УСГ, 2002)

Хот руу чиглэсэн энэхүү “их нүүдэлтэй” холбоотойгоор шийдлээ хүлээх болсон олон асуудлын нэг нь хотын хөдөлмөрийн зах зээлд их хэмжээгээр нийлүүлэгдэж байгаа ажиллах хүчийг шингээх буюу шилжин ирэгсдийг ажлын байраар хангах, цаашлаад амьдралын баталгаатай болгох асуудал юм.

Баруун бус нутагт: Ховд, Увс, Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай, аймгууд  
Хангайн бус нутагт: Баянхонгор, Хөвсгөл, Булган, Архангай, Өвөрхангай, Орхон аймгууд  
Төвийн бус нутагт: Сэлэнгэ, Төв, Дундговь, Дорноговь, Өмнөговь, Говьсүмбэр, Дархан-Уул аймгууд

Зүүн бус нутагт: Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудыг оруулав.

**Зураг 2. 1995-2000 оны хүн амын жилийн дундаж өсөлтийн түвшин, бүс нутгаар**



**Эх сурвалж:** УСГ, Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого, Статистикийн эмхэтгэл

Хүн амын хотод шилжин суурьших гол шалтгаан нь ажил эрхлэлт болоод байгаа (ХАССТ, 2000) энэ үед Улаанбаатар хотын хүн амын ажил эрхлэлтийн түвшин хөдөөгийн хүн амын болон улсын дундаж ажил эрхлэлтийн түвшинтэй харьцуулахад доогуур түвшинд байгаагаас гадна (Хүснэгт 1) бүртгэлгүй буюу далд ажилгүйдэл, нийгмийн хангамж, хамгаалал муутай албан бус секторт ажиллагсад нэмэгдэх болов. (ОУБХ, 2001)

Хотжилтын түвшинтэй уялдан ажил эрхлэлтийн байдалд гарч буй нэг өөрчлөлт бол ажиллагсдын эдийн засгийн салбарын бүтэц бөгөөд бүс нутгууд дахь хотжилтын түвшин нэмэгдэхийн хэрээр анхдагч<sup>1</sup> салбарт ажиллагсдын хувийн жин буурч, хоёрдогч<sup>2</sup>, гуравдагч<sup>3</sup> салбаруудад ажиллагсдын хувийн жин өсөж байгаа явдал юм. Ерөнхийдөө, Улаанбаатар хотод хүн амын тоо буюу хэрэглэгчдийн тоо нэмэгдэж, зах зээлийн хүрээ тэлсээр байгаа нь хоёрдогч ба гуравдагч салбаруудын хөгжил эрчимтэй явагдахын үндэс болж байна.

Хотжилтын түвшин хамгийн багатай Баруун бүсэд анхдагч буюу хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын эзлэх хувь өндөр (74 хувь) байхад, эсрэгээр хотжилтын түвшин өндөр Улаанбаатарт хамгийн бага байна. Улаанбаатар хотын ажиллагсдын 70.5 хувь нь гуравдагч, 2.2 хувь нь анхдагч, үлдсэн хувь нь хоёрдогч салбарт ажиллаж байна. (А.Солонго, Б.Мөнхжаргал, 2003)

**Хүснэгт 1. Ажиллах хүчний үзүүлэлтүүд, бүсээр, 2002 он (хувиар)**

Үзүүлэлтүүд	Бүсүүд						Улсын дүн
	Хангай	Баруун	Төв	Зүүн	Улаанбаатар		
Ажиллах хүчний оролцооны түвшин*	71.6	74.3	66.6	63.4	50.4	62.7	
Ажил эрхлэлтийн түвшин**	68.3	70.9	64.5	60.8	49.4	60.5	
Ажилгүйдлийн түвшин***	4.7	4.4	3.1	4.7	2.0	3.4	

Тэмдэглэл: \* 15-түүнээс дээш насны нийт хүн амд ажил эрхэлж байгаа болон ажилгүй байгаа нийт хүн амын эзлэх хувь.

\*\*-Ажиллагсад ба 15 ба түүнээс дээш насны хүн амын харьцаа.


\*\*\*-Бүртгэлтэй ажилгүйчүүд ба эдийн засгийн идэвхтэй хүн амын харьцаа.

Эх сурвалж: УСГ, Монгол Улсын Статистикийн эмхээтыгэл, 2002 он

Улаанбаатар хотын хөдөлмөрийн насны хүн амын хувийн жиншилжих хөдөлгөөний нөлөөгөөр өндөр байгаа боловч (УСГ, 2002) ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн доогуур байгаа нь эдийн засгийн идэвхгүй хүн ам, тухайлбал, хөдөлмөрийн насны суралцагсад болон хөдөлмөрийн чадваргүй хүн амын хувийн жингийн өндөр түвшинтэй холбоотой юм. Түүнчлэн нийслэлд бүртгэлтэй ажилгүйчүүдийн түвшин улсын дундаж болон бусад бүсүүдээс доогуур байгаа нь оршин суугчдын эдийн засгийн идэвхи сул байгааг харуулж байна.

Бүртгэлтэй ажилгүйдлийн түвшинээр Улаанбаатар хамгийн бага байгаа ч тооцоологдсон ажилгүйдлийн түвшингээр авч үзэхэд 20.2 хувь буюу Зүүн бүсийн дараа орж байна. Энэ нь нийслэлд бодит ажилгүйдэл өндөр хувьтай байгааг харуулж байна, нөгөө талаар хөдөө орон нутагт эдийн засгийн бүтцийн бүтээмж багатай мал аж ахуйн салбар давамгайлсан байдагтай холбоотой юм. (А.Солонго, Б.Мөнхжаргал, 2003)

**Зураг 3. Ажилгүйдлийн түвшин, хотын хүн амын эзлэх хувь, аймаг нийслэлээр 2000 оноор**



Эх сурвалж: УСГ, ХАОСТ, Хүн амын эдийн засгийн идэвхи: Сэдэвчилсэн судалгаа, 2001 он

<sup>1</sup>Анхдагч: ХАА, <sup>2</sup>Хоёрдогч: Аж үйлдвэр, <sup>3</sup>Гуравдагч: Үйлчилгээний чиглэлийн салбарууд

Ерөнхийдөө хүн амын ажилгүйдлийн түвшин ба хотжилтын түвшин хоёрын хооронд эерэг хамаарал ажиглагдаж байна. (Зураг 3) Өөрөөр хэлбэл, хотын хүн амын хувийн жин өсөх нь араасаа ажилгүйдлийн өндөр түвшнийг дагуулж байна гэсэн үг юм. Үүнийг нэг талаас олноор ирж суурьшиж буй ажиллах хүчийг ажлын байраар бүрэн хангаж чадахгүй байгаатай, нөгөөтэйгүүр эдийн засгийн идэвхитэй хүн амын хувийн жингийн хэт хурдан өсөлттэй холбон тайлбарлаж болох юм.

### **Судалгааны ажлын зорилго, шинэлэг байдал**

Энэхүү судалгааны ажил нь дараахь үндсэн зорилготой. Үүнд:

- Улаанбаатар хотод шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтийн байдлыг гүнзгийрүүлэн судалж, ажил эрхэлж байгаа болон ажил эрхлэхгүй байгаа хүн амын ахуй амьдралд гарсан өөрчлөлтийг харьцуулан дүгнэлт хийх;
- Шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтэнд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодорхойлох, тэдгээр хүчин зүйлүүдийн хамаарлыг судлах.

*Судалгааны шинэлэг байдал:*

Шилжих хөдөлгөөн, хотжилт, ажил эрхлэлт зэрэг асуудлын талаар хийгдсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд олонтаа тохиолддог. Гэвч шилжих хөдөлгөөн ба ажил эрхлэлтийн асуудлыг судалгааныхаа гол обект болгон, тэдгээрийн уялдаа холбоо, шилжигсдийн ажил эрхлэлтийн байдал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар нарийвчлан хийсэн судалгааны ажил өнөөг хүртэл хийгдээгүй байна.

Түүнчлэн шилжигсдийг хүлээн авагч, хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнийг тодорхойлогч гол бүс болох Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн ажил эрхлэлтэнд нөлөөлөгч хүчин зүйлсийн судалгааг хийснээр Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөнд оролцогчдын нийтлэг дүр төрхийг тодорхой хэмжээгээр харуулж чадна гэж үзсэн болно.

### **Ойлголт, тодорхойлолтууд**

*Шилжих хөдөлгөөн*

Энэхүү ойлголтоор тухайн аймаг, хотын хил хязгаарыг даван өөр аймаг, хотод шилжин суурьшсан хөдөлгөөнийг авч үзсэн.

*Шилжигч*

Шилжих хөдөлгөөнд оролцогч буюу сүүлийн 5 жилийн хугацаанд Улаанбаатар хотод шилжин суурьшсан хүмүүсийг хамруулж байна.

*Ажил эрхэлж байгаа хүн ам*

Сүүлийн долоо хоногт ажил эрхэлсэн эсэхээр шалгуур болгон тодорхойлсон. Сүүлийн 7 хоногт ядаж нэг өдөр ажил эрхэлсэн буюу бараа, үйлчилгээ бий болгоход оролцсон хүмүүсийг ажил эрхэлж байгаа хүн амд багтаан үзэв.

Хүн ам зүйн хүчин зүйл. Энэхүү ойлголтыг дараахь үзүүлэлтүүдээр илэрхийлнэ.

- Нас

Шилжин ирэгсдийн насыг ажил эрхлэлтийн байдалтай холбон 15-24, 25-44, 45-ба түүнээс дээш насыхан гэж ангилсан.

- Өрхийн ам бүлийн гишүүдийн тоо

Тухайн шилжин ирсэн өрхөд амьдарч байгаа нийт хүний тоо бөгөөд, 1, 2-5, 6-9, 10 буюу түүнээс дээш гэсэн 4 ангиллаар авч үзэв.

- Боловсролын түвшин

Хүн амын боловсролын түвшин нь ажил эрхлэлтийг шууд тодорхойлогч хэмжигдэхүүн юм. Шилжин ирсэн хүн амыг боловсролын түвшнөөр нь Бүрэн дундаас дээш, Бүрэн дунд ба түүнээс доош, Боловсролгүй гэсэн 3 бүлэгт ангилаад, бүлэг бүрт хамаарах категориудыг нэгтгэн үзсэн.

*Нийгэм, эдийн засгийн хүчин зүйл: Энэхүү ойлголтод дараахь үзүүлэлтүүдийг оруулсан.*

- Тухайн өрхийн нэг хүнд ногдох сарын хэрэглээний түвшин

Тухайн өрхийн нэг хүнд ногдох сарын хэрэглээний түвшинг 1998 онд ҮСГ-аас явуулсан “Хүн амын амьжиргааны түвшний судалгаа”-с тодорхойлсон нэг хүнд ногдох сарын хэрэглээний түвшнээр ангилан авч үзсэн. Үүнд:

11005 төгрөгөөс доош бол	Нэн ядуу
--------------------------	----------

11006-14674 төгрөг:	Ядуу
---------------------	------

14675-22012 төгрөг :	Ядуу бус бага орлоготой
----------------------	-------------------------

22013-33018 төгрөг :	Ядуу бус дундаж орлоготой
----------------------	---------------------------

33019 төгрөгөөс дээш :	Ядуу бус өндөр орлоготой
------------------------	--------------------------

- Шилжин ирэхээс өмнөх байршил

Улаанбаатар хотод шилжин ирэхээс өмнө сууж байсан газрын байршил бөгөөд Нийслэл, Аймгийн төв, Тосгон, Сумын төв, Хөдөө, Гадаад гэсэн ангиллаар орсон.

- Шилжилтийн шалтгаан

Тухайн шилжигчийн Улаанбаатар хотод шилжин суурьшихад голлон нөлөөлсөн шалтгааныг авч үзсэн ба ажил эрхлэх, бусад гэсэн 2 ангиллаар оруулав.

- Орон сууцны нөхцөл

Энэхүү үзүүлэлт нь ажлын байртай болоход нөлөөлөгч нэг хүчин зүйл гэж таамагласны үндсэн дээр загварт оруулсан. Өрхийн амьдарч буй сууцны төрөл, зориулалт халаалт, үндны ус, гэрэлтүүлэг, бие засах газрын төрөл зэрэг ахуйн нөхцлийн 9 үзүүлэлтийг нэгтгэн индекс зохиож, орон сууцны нөхцөл сайн, дунд зэрэг, муу гэж ангилан тодорхойлов.

- Бүртгэлийн статус

Улаанбаатар хотод шилжин ирээд засаг захиргааны шилжүүлэг хийлгэсэн эсэхээр шалгуур болгон авсан ба нэг талаас шилжигчдийг бүртгэн авах үндсэн нөхцөл нь ажлын байрны баталгаа, нөгөө талаас бүртгэл нь ажлын байртай болоход нөлөөлнө гэж үзээд энэ үзүүлэлтийг авсан.

### **Хамаарах хувьсагч**

Таамаглагдаж буй хүчин зүйл буюу ажил эрхэлж буй байдал гэсэн ойлголтоор илэрхийлэгдэж байна.

### **Үл хамаарах хувьсагч**

Тухайн үзүүлэлтэнд нөлөөлнө гэж тааварлагдаж байгаа хүчин зүйлүүд болох хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс юм.

### **Хамаарах байдал**

Үзүүлэлтүүдийн хамаарах байдал гэдэг нь нэг үзэгдлийн аливаа нэг утгад нөгөө үзүүлэлтийн тодорхой нэг утга харгалзах явдлаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл хамаарах хувьсагч нь үл хамаарах хувьсагчдаас тодорхой хэмжээгээр хамааралтай байна гэсэн үг юм.

### **Шинжилгээний аргууд ба мэдээллийн эх үүсвэр**

Энэхүү ажилд 2000 онд МУИС-ийн Хүн Амын Сургалт Судалгааны Төвөөс явуулсан “Монгол Улсын Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа”-г хоёрдогч мэдээллийн эх үүсвэр болгон ашиглаж, шинжилгээ хийв. Түүнчлэн 1989, 2000 оны тооллогуудаар цуглуулагдсан мэдээлэл, 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэн гаргасан сэдэвчилсэн судалгаанууд болон бусад холбогдох эрдэм шинжилгээний ажлууд, онол болон арга зүйн материалуудыг ашигласан.

Уг ажилдаа математик аргууд, шинжлэх ухааны хийсвэрлэлт, харьцуулалт, анализ, график тооцоо, эконометрик, статистик аргууд болон судалгааны мэдээлэлд статистик шинжилгээ хийх SPSS багц программыг ашиглав.

Улаанбаатарт шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтэнд нөлөөлөгч хоёр хүчин зүйлийн шинжилгээг  $\chi^2$ -ийн аргад тулгуурласан дурын хэмжээс бүхий хүснэгтүүдийн тооцоонд ашиглагддаг хамаарлыг тодорхойлох Cramer's V гэсэн нэрлэсэн хэмжигдэхүүнийг ашиглан тодорхойлов.

Ажил эрхлэлтийн байдал гэсэн хамаарах хувьсагч нь тийм, үгүй гэсэн хоёр сонголттой Dummy хувьсагч, үл хамаарах хувьсагчид нь Dummy болон нэрлэсэн түвшний хувьсагчууд учраас ажил эрхлэлтэнд нөлөөлөгч хүчин зүйлийн шинжилгээг ложистик регрессийн загварыг ашиглан үнэлсэн. Үүний үндсэн дээр хүн ам зүйн хүчин зүйлийн ажил эрхлэлт дэх нөлөөлөл, хүн ам зүй ба нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийн ажил эрхлэлт дэх нөлөөллийг тодорхойлогч загваруудыг гаргалаа.

### **Мэдээллийн хязгаарлагдмал байдал**


Шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтэнд нөлөөлөгч хүчин зүйлүүдийг тодорхойлохдоо хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс гэсэн үл хамаарах хувьсагчдыг сонгосон. Гэвч хоёрдогч мэдээллийн эх үүсвэрийг ашигласнаас үл хамаарах хувьсагчууд тодорхой асуултуудын хүрээнд хязгаарлагдмал байдлаа сонгогдсон тул хүссэн үр дүнгээ гаргах боломж хязгаарлагдмал байв. Өөрөөр хэлбэл, судалгааны асуулгаар цуглуулагдсан мэдээллүүдийг ашиглан ажил эрхлэлтэнд нөлөөлөгч үзүүлэлтүүдийг тодорхойлсон болно.

## Судалгааны логик хүрээ, таамаглал

Энэхүү ажлын судалгаа, шинжилгээний хүрээ нь 2000 онд МУИС-ийн Хүн Амын Сургалт Судалгааны Төвөөс НҮБ-ын Хүн Амын Сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр явуулсан “Монгол Улсын Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа” болон уг сэдэвтэй холбоотой эрдэмтэд, судлаачдын онол, таамаглал, судалгааны ажлууд, ном, эрдэм шинжилгээний бусад бүтээлүүд, өөрийн санал, дүгнэлт дээр үндэслэгдэн боловсруулагдсан болно.

Шинжилгээний хүрээнд шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтийн байдал гэсэн хувьсагчийг сонгож, хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсэд хамаарах дараах хувьсагчуудаас хамааруулан шалтгааны загвараар шинжилгээг хийлээ. Уг загварыг схемээр харуулбал:

**Зураг 4. Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн ажил эрхлэлтийн шалтгааны загвар**



Судалгаанд дараах таамаглалуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. Шилжин ирэгсдийн ажил эрхлэлтийн байдалд нас, боловсролын түвшин нь голлон нөлөөлөгч хүчин зүйлүүд юм.
2. Гэр бүлийн хэмжээ, шилжилтийн шалтгаан, өрхийн сарын хэрэглээний нэг хүнд ногдох түвшин, орон сууцны нөхцөл, бүртгэл зэрэг үзүүлэлтүүд нь хамаарах хувьсагчид дунд зэргийн нөлөө үзүүлнэ.
3. Сонгосон хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд нь ажил эрхлэлтийн байдлыг тайлбарлах чадвар сайтай хувьсагчид юм.
4. Эрэгтэй, эмэгтэй хүйсийн хувьд үл хамаарах хувьсагчууд ялгаатай байдлаар тодорхойлогдоно.


**Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн ажил эрхлэлтийн байдал**

*Шилжин ирэгсдийн ажил эрхлэлтийн байдал:*

Энэхүү судалгаанд шилжин суурьшсан нутгууд болох Улаанбаатар хот, Дархан-Уул, Төв аймагт шилжин ирсэн 15-64 насны 1765 хүн хамрагдсаны 885 нь буюу тэн хагас нь Улаанбаатар хотод шилжин суурьшигчид байлаа.

Эдгээр хүн амын 56.7 хувь нь эмэгтэй, 43.3 хувь нь эрэгтэй хүн ам байгаа ба 45-49 насны бүлгээс бусад бүх насны бүлэг бүрт эмэгтэйчүүдийн тоо өндөр байгаа хандлага ажиглагдаж байна. Шилжин ирэгсдийн насны бүтцийг авч үзвэл ерөнхийдөө 15-24 насанд төвлөрсөн (43.7 хувь) бөгөөд нас ахижын хэрээр шилжих хөдөлгөөнд оролцох нь багассан байна.

Шилжин ирэгсдийн дотор зах зээлд ойртох (37.1 хувь), ажиллах (33.6 хувь), суралцах (32.5 хувь) зэрэг нь шалтгааны улмаас шилжигсэд өндөр хувийг эзэлж байлаа.



**Эх сурвалж: ХАССТ, Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөнийн микротүвшний судалгаа 2000.**

Үүний дараагаар амьдралын нөхцлөө сайжруулах, хүүхдүүдийнхээ ирээдүйг бодох, төрөл саднаа бараадах зэрэг шалтгаанууд орж байна. Улаанбаатар хотод шилжин суурьшсан нийт хүн амын 592 нь буюу 66.9 хувь нь шилжин ирснээсээ хойш ямар нэгэн ажил эрхэлсэн бөгөөд эдгээр хүн амын 558 нь буюу 94.2 хувь нь одоогийн байдлаар ажил эрхэлж байна. Ажил эрхэлж байгаа хүн амын нас, хүйсийн бүтцийг үзвэл 45-49 наснаас бусад бүх насанд эмэгтэй хүн амын ажил эрхлэлт өндөр байгаа бөгөөд энэ нь эмэгтэй шилжигсдийн хувийн жин өндөр байгаатай холбоотой. (Зураг 5) Ажил эрхлэлтийг хүйсээр ялган авч үзэхэд төдийлөн ялгаа багатай байна. (Эрэгтэй ба эмэгтэй хүн амын хүн амын ажил эрхлэлт харгалзан 66.1, 67.5 хувь) Эрэгтэй хүн амын хувьд 20-24 нас, эмэгтэй хүн амын хувьд 15-19 нас нь ажил эрхлэлтийн хамгийн идэвхтэй ўе байна.

Ажил эрхэлж байгаа 10 хүн тутмын 7 нь бүрэн дундаас дээш боловсролтой буюу ямар нэгэн мэргэжил эзэмшсэн хүмүүс байгаагаас ажил эрхлэлтэнд боловсролын түвшин шууд нөлөөтэй гэж хүчин зүйл гэдгийг хэлж болохоор байна.

Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн 51.5 хувь нь нэг сар хүртэлх, 34.8 хувь нь нэг жил хүртлэх, үлдсэн нь нэг жилээс дээш хугацаанд хүлээсний эцэст ажилд орсон ба ажил эрхэлж байгаа хүмүүсийн хувьд ажилд орсон дундаж хугацаа нь 105.76 өдөр буюу 3 сар, 15 хоног байна. Энэ үзүүлэлт хүйсийн хувьд ялгаа багатай буюу эрэгтэй хүн амын хувь 3 сар 9 хоног, эмэгтэй хүн амын хувьд 3 сар 21 хоног байна.

#### **Хүснэгт 2. Хүн амын хувь, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр**

Ажил эрхлэлтийн байдал	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Төрийн/төсвийн байгууллага	8.6	9.8	9.3
Төрийн өмчийн ААН, байгууллага	3.4	1.6	2.4
Хувийн ААН, байгууллага	17.2	13.3	15.0
Төрийн бус байгууллага	1.1	0.4	0.7
Хувираа ажил, наймаа хийдэг	14.9	7.6	10.8
Сурдаг	15.4	26.1	21.5
Гэрийн ажилтай	1.0	4.0	2.7
Малчин	1.3	0.4	0.8
Ажил эрхлээгүй	37.1	36.8	36.9
Бүгд	66,1	67,5	66.9
Тоо	383	502	885

**Эх сурвалж:** ХАССТ, Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа 2000

Улаанбаатарт шилжин ирсэн 5 хүн тутмын нэг нь (21.5 хувь) суралцаж байгаа нь шилжих хөдөлгөөнд 15-24 насныхны ихээр оролцсонтой холбоотой. Түүнчлэн суралцах нь шилжихэд хүргэж буй нэг томоохон шалтгаан билээ. Харин гурав дахь шатны сургуульд суралцагсдын хүйсийн ялгаа нэлээд өндөр байгаа нь ажиглагдаж байна. Хувийн ААН, байгууллага дахь ажил эрхлэлт нь төрийн/төсвийн байгууллага дахь ажил эрхлэлтээс 5.7, төрийн өмчийн ААН/байгууллага дахь ажил эрхлэлтээс 12.6 пунктээр өндөр үзүүлэлт байна. Энэ нь нэг талаас ихэнх үйлдвэр, ААН-үүд хувьчлагдаж, шинээр хувийн ААН, байгууллагууд нэмэгдэж байгаатай, нөгөөтэйгүүр хувийн ААН-д ажилд ороход харьцангуй хялбар байдагтай холбоотой болов уу. Мөн ажил эрхэлж байгаа хүмүүсийн дийлэнх нь ногдож буй хоёрдогч ба гуравдагч салбарууд ихэвчлэн хувийн байгууллагууд байна. (ҮСГ, 2000)

Ажил эрхлэлтийн байдлыг хүйсээр авч үзэхэд, хувиараа ажил, наймаа хийдэг эрэгтэйчүүдийн хувь эмэгтэй хүн амас бараг хоёр дахин өндөр байгаа нь зах дээр худалдаа эрхлэгчид, валютын ченжүүд, таксины жолоочид зэрэг ихэвчлэн албан бус секторт ажил эрхэлж буй эрэгтэй хүн амын хувь эмэгтэйчүүдээс өндөр байгаагаар тайлбарлагдана. Харин гэрийн ажилтай эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс даруй 4 дахин өндөр байгаа нь хүүхэд, өвчтөн, өндөр настан асрах зэрэг үнэлгээгүй ажилд эмэгтэй хүн ам түлхүү оролцдог хандлага Улаанбаатар хотын хувьд ч адилхан байгааг харуулж байна.

Ажил эрхлэлтийн тогтвортой байдлыг авч үзэхэд шилжин ирсэн эрэгтэй хүн амын 14.6 хувь, эмэгтэй хүн амын 12.4 хувь нь анх ажиллаж байсан ажлын байраа сольсон байна. Эрхэлдэг ажлаа сольсон хүмүүсийн ихэнх нь буюу 65.8 хувь нь 15-34 насныхан, 88.6 хувь нь бүрэн дундаас дээш боловсролтой хүмүүс байжээ. Үүнээс боловсролын түвшин

өндөртэй хүмүүс хүссэн ажлын байрандаа сонголт хийж ажиллах боломж боловсрол багатай хүмүүсийг бодвол харьцангуй өндөр байдаг гэж хэлж болохоор байна. Ажлын байраа сольсон 2 хүн тутмын нэг нь хувийн байгууллагад ажиллаж байсан бол ердөө 5 хувь нь төрийн өмчийн ААН, байгууллагад ажиллаж байжээ. Энэ нь төрийн/төсвийн болон төрийн өмчийн ААН/байгууллагуудтай харьцуулахад хувийн байгууллагуудын ажлын нөхцөл муу, цалингийн түвшин доогуур байдалтай холбоотой байна. Нөгөө талаар хувийн байгууллагуудад ажилд орсон тохиолдолд ажил олгогч, ажилчин хоёрын хооронд хөдөлмөрийн гэрээ тэр болгон байгуулдаггүйтэй ч холбон тайлбарлаж болно.

Шилжин ирээд ажил эрхлэхгүй байгаа нийт хүн амд ажил хайгаад олдохгүй байгаа гэдэг шалтгаанаар ажил эрхлэхгүй байгаа хувь өндөр байна. (41 хувь) Үүнээс шилжин ирэгсэд ажил эрхлэх сонирхолтой, эдийн засгийн идэвхтэй хүмүүс байна гэж хэлж болох юм. Үүний дараагаар ажил хийх шаардлагагүй гэсэн шалтгаан (20 орчим хувь) орж байгаа ба ийм хариулт өгсөн хүмүүсийн хувь бараг тэн хагас нь ядуу бус дундаас дээш орлоготой хүмүүс байна. Шилжин ирсэн хүн амын дунд тахир дутуугийн группт, мэдлэг хүрэхгүй, тохирох ажил олдохгүй зэрэг шалтгаанаар ажил эрхлэхгүй байгаа хүн амын хувийн жин хамгийн бага буюу 1.5-3.4 хувь байгаа нь хамгийн их дурьдагдсан шалтгаанаас даруй 37.6-39.5 пунктээр бага үзүүлэлт байна.

Улаанбаатар хотод шилжин ирээд ажил эрхэлж байгаа нийт хүн амын 1/3-с илүү нь шилжих шийдвэрээ гаргахдаа ажил эрхлэх зорилгыг агуулсан бөгөөд, ажил эрхлэх зорилготойгоор шилжин ирэгсдийн 77.6 хувь нь одоогийн байдлаар ямар нэгэн ажил эрхэлж байна.

### **Шилжигчдийн ахуй амьдралд ажил эрхлэлт нөлөөлөх нь**

**Хүснэгт 3. Хүн амын хувь, ажил эрхлэлтийн байдал, шилжин ирсний дараа амьдралын нөхцөл байдалд гарсан өөрчлөлтөөр**

Хэмжүүрүүд	Үзүүлэлтүүд										
	Ажил эрхлэлтийн байдал		Орлого		Боловсрол, мэргэжлийн чадвар		Орон сууцны нөхцөл байдал		Эрүүл мэнд		Зах зээл, худалдан авах, худалдаалах боломж
	Ажил эрхэлж байгаа	Ажил эрхлээгүй	Ажил эрхэлж байгаа	Ажил эрхлээгүй	Ажил эрхэлж байгаа	Ажил эрхлээгүй	Ажил эрхэлж байгаа	Ажил эрхлээгүй	Ажил эрхэлж байгаа	Ажил эрхлээгүй	Ажил эрхэлж байгаа
Сайжирсан	57,7	11.9	51,8	20,5	51,8	16	31,7	19,8	15,6	16	84,8
Хэвээрээ	28,1	45,7	31	46,4	45,2	72,4	50	60,8	80,1	75,1	10,9
Доройтсон	3,8	27,3	3,6	22,9	1,4	9,1	16,3	15,4	3,6	8,2	4,4
Мэдэхгүй	9,5	13	12	9,2	1,3	2,5	1,8	3,0	0,2	0,7	1,0
Хамааралгүй	0,9	2,1	1,6	1,0	0,3		0,2	1,0	0,5		0,7
Бүгд	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
Тоо	558	327	558	327	558	327	558	327	558	327	327

**Эх сурвалж:** ХАССТ, Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микротүвшний судалгаа 2000

Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн тэн хагасаас илүү нь ажлын нөхцөл болон цалин хөлсний хувьд өмнөхөөсөө илүү сайн ажил эрхэлж байгаа нь маш “эерэг” үзүүлэлт юм. Иймээс ч ажил эрхлээгүй хүмүүстэй харьцуулахад, ажил эрхэлж байгаа хүн амын хувьд ахуй, амьдралд нь дэвшил, дээшлэлт гарсан үзүүлэлт олон байна. Харин ажил эрхлээгүй хүн амын хувьд амьдрал, ахуйд нь гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлогч үзүүлэлтүүдийн ихэнхэд онцын өөрчлөлт гараагүй буюу доройтсон хандлага ажиглагдлаа. Үүнээс хүн амын ажил эрхлэлт нь амьжиргааны түвшинд нөлөөлөгч гол үзүүлэлт гэж хэлж болох бөгөөд хүмүүс ажилгүй байснаар наад захын идэж уух, өмсөж хэрэглэх хэрэгцээгээр дутагдаад зогсохгүй, бие бялдар, оюун санааны хувьд хоцрогдож, улмаар хотын хүн амын дунд ядуурал, тэгш бус эмзэг байдал нэмэгдэх, нийгмийн сөрөг үзэгдлүүд газар авахын үндэс болно.

### **Улаанбаатар хотод шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтэнд нөлөөлөгч хоёр хүчин зүйлийн (хамаарлын) шинжилгээ**

Улаанбаатар хотод шилжин ирсэн хүмүүсийн хувьд ажил эрхлэлтэнд нөлөөлөгч гэж үзэж буй хүчин зүйлүүд нь ажил эрхлэлтийн байдал буюу бидний авч үзэж байгаагаар таамаглагдаж буй хүчин зүйлтэй ямар хамааралтай байна вэ, цаашид олон хүчин зүйлийн шинжилгээнд тухайн хувьсагчийг авах нь хэр бодитой вэ гэсэн асуултанд хариулт өгөх зорилгоор хоёр хүчин зүйлийн хамаарлын шинжилгээг хийсэн болно.

1. *Дэвшүүлж буй буюу тэг таамаглал  $H_0$ :* Хүн ам зүйн хүчин зүйлүүд болох шилжигчийн нас, боловсролын түвшин, өрхийн ам бүлийн тоо, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүд болох Улаанбаатарт шилжин ирэхээс өмнөх байршил, шилжилтийн шалтгаан, өрхийн сарын хэрэглээний нэг хүнд ногдох түвшин гэсэн үзүүлэлтүүд нь ажил эрхлэлтийн байдалд нөлөөлнө, өөрөөр хэлбэл эдгээр хувьсагчдын хооронд статистик хамаарал оршино.
2. *Өрсөлдөгч таамаглал  $H_1$ :* Дээрх хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүд нь ажил эрхлэлтийн байдалтай хамааралгүй.
3. *Статистик шалгуур:* Ажил эрхлэлт ба түүнд нөлөөлнө гэж авч үзэж байгаа хувьсагчуудын хоорондын хамаарлыг хамгийн их үнэний хувь бүхий аргад үндэслэх  $\chi^2$ - шалгуураар үнэлэв. Хамаарлын эрч хүчийг Крамерийн V нэрлэсэн хэмжигдэхүүнээр тодорхойлно.
4. *Итгэх түвшин-g*  $\alpha = 0.05$  буюу үнэлгээний алдааг хамгийн ихдээ 95% байхаар тооцсон.
5. *Түүвэр олонлогийн тархалт-ыг (r-1)(c-1)* гэсэн чөлөөний зэрэг бүхий  $\chi^2$  тархалтаар тархана гэж үзнэ.
6. *Шалгуур муж-ийг чөлөөний зэрэг (df)* болон итгэх түвшинг ашиглан үнэлсэн утгаа хүснэгтийн онолын утгатай харьцуулан үнэлсэн.

## Хүн ам зүйн хүчин зүйлс ба ажил эрхлэлтийн хамаарал

**Хүснэгт 4. Хүн ам зүйн хүчин зүйлс ба ажил эрхлэлтийн хоорондын хамаарал, хүйсээр**

Хүн ам зүйн хүчин зүйл	Ажил эрхэлдэг хүн ам Эрэгтэй	Ажил эрхэлдэг хүн ам Эмэгтэй
Нас		
$\chi^2$	22,855	66,368
Df	2	2
Cramer's V	0,744	0,614
Боловсролын түвшин		
$\chi^2$	19,108	29,879
Df	2	2
Cramer's V	0,854	0,917
Өрхийн ам бүлийн тоо		
$\chi^2$	15,209	9,558
Df	3	3
Cramer's V	0,456	0,377

**Тайлбар:**  $V \rightarrow 1$  Хоёр хувьсагчийн хүчтэй хамаарлыг,  $V \rightarrow 0$  сувалтар хамаарлыг,  $V < 0$  хамааралгүй болохыг харуулна. Бүх хувьсагчуудийн хувьд таамаглагдаж байгаа болон барагцаалсан ач холбогдлын түвшин нь  $P=0.000$  гэж тодорхойлогдсон.

Хүн ам зүйн хүчин зүйлүүд нь ажил эрхлэлтийн байдалтай статистикийн өндөр ач холбогдол бүхий хамааралтай байна. Иймээс хүн ам зүйн хүчин зүйлүүд болон ажил эрхлэлтийн байдал нь хамааралгүй гэсэн  $H_1$  таамаглалыг няцаах үндэслэлтэй гэдгийг дээрх хүснэгтийн үр дүн харуулж байна. Тухайн шилжигчийн нас нь ажил эрхлэлтийн байдалтай хүчтэй, боловсролын түвшин нь маш хүчтэй, өрхийн ам бүлийн тоо нь дунд зэрэг хамааралтай байна.

## Нийгэм эдийн засгийн хүчин зүйлс ба ажил эрхлэлтийн хамаарал

**Хүснэгт 5. Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс ба ажил эрхлэлтийн хоорондын хамаарал, хүйсээр**

Нийгэм, эдийн засгийн зүйн хүчин зүйл	Ажил эрхэлдэг хүн ам Эрэгтэй	Ажил эрхэлдэг хүн ам Эмэгтэй
Шилжин ирэхээс өмнөх байршил		
$\chi^2$	16,051	15,029
Df	5	5
Cramer's V	0,86	0,95
Шилжилтийн шалтгаан		
$\chi^2$	14,449	9,519
Df	1	1
Cramer's V	0,794	0,718
Орон сууцны нөхцөл		
$\chi^2$	11,855	5,921
Df	2	2
Cramer's V	0,121	0,157
Өрхийн нэг хүнд ногдох сарын хэрэглээний түвшин		
$\chi^2$	21,655	22,921
Df	4	4
Cramer's V	0,576	0,666
Бүртгэлийн статус		

$\chi^2$	1,247	2,541
Df	1	1
Cramer's V	0,056	0,091

**Тайлбар:**  $V \rightarrow 1$  Хоёр хувьсагчийн хүчтэй хамаарлыг,  $V \rightarrow 0$  Хоёр хувьсагчийн сулаатар хамаарлыг харуулна. Өрхийн орон сууцны нөхцөл, бүртгэл гэсэн хувьсагчуудаас (0.122 ба 0.325) бусад хувьсагчуудийн хувьд таамаглагдаж байгаа болон барагцаалсан ач холбогдлын түвшин нь  $P=0.000$  гэж тодорхойлогдсон.

Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүд ба ажил эрхлэлтийн хооронд тодорхой хамаарал оршиж байгаа бөгөөд шилжилтийн шалтгаан ба шилжин ирэхээс өмнөх байршил зэрэг нь ажил эрхлэлтэнд маш хүчтэй нөлөө үзүүлж байна. Ялангуяа шилжин ирэхээс өмнөх байршил болон эмэгтэй хүн амын ажил эрхлэлт хоорондоо бараг төгс гэж хэлж болохоор хамааралтай байна. Шилжигчийн орон сууцны нөхцөл, бүртгэл зэрэг нь ажил эрхлэлтийн байдалтай бараг хамааралгүй, эдгээр үзүүлэлтүүдийн хооронд статистик ач холбогдол оршихгүй байгаа учраас олон хүчин зүйлийн шинжилгээнд оруулаагүй.

### Улаанбаатар хотод шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтэнд нөлөөлөгч олон хүчин зүйлийн шинжилгээ

Өмнө авч үзсэн хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүд нь ажил эрхлэлтийн байдалтай хамааралтай нь тогтоогдсон билээ. Тэгвэл эдгээр хувьсагчуудын хамаарлын зүй тогтол чухам ямар хуулиар явагдаж байна вэ, өөрөөр хэлбэл ажил эрхлэлтийн байдалд хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс хэрхэн нөлөөлж байна гэдгийг ложистик регрессийн тэгшитгэлээр үнэлэв.

#### Хүснэгт 6. Эрэгтэй хүн амын ажил эрхлэлтэнд нөлөөлөгч зүйлийн ложистик регрессийн үр дүн, сонгосон үл хамаарах хувьсагчуудаар

Үл хамаарах хувьсагчид	Логарифм/Магадлалын харьцаа	
	Загвар А	Загвар В
1. ХҮН АМ ЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛС		
Нас		
15-24	1.000	1.000
25-44	1.075***	2.822***
45+	0.183**	0.922**
Боловсролын түвшин		
Бүрэн дундаас дээш	1.92**	2.01***
Бүрэн дунд ба түүнээс доош	0.299	1.71*
Боловсролгүй	1.000	1.000
Өрхийн ам бүлийн тоо		
1	1.000	1.000
2-5	0.299	0.224
6-9	1.238**	2.482*
10+	0.561	0.496
2. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛС		
Шилжин ирэхээс өмнөх байршил		
Нийслэл	0.265	
Аймгийн төв	10.202*	
Тосгон	20.638	
Сумын төв	21.415	
Хөдөө	1.000	
Гадаад		
Шилжилтийн шалтгаан		
Ажиллах	5.125**	

Бусад		1.000
Сарын хэрэглээний түвшин		
Нэн ядуу	1.112	
Ядуу	1.151	
Бага орлоготой	1.000	
Дундаж орлоготой	2.001	
Өндөр орлоготой	0.954	
$\chi^2$	434.564	437.888
$R^2$	0.589	0.713

**Тайлбар:**  $P<0.05$  түвшинд ач холбогдлын коэффициентийг тооцөв.  $0.05>P>0.01$  Хоёр хувьсагчийн сул хамаарлыг (\*),  $0.01>P>0.0001$  Дунд зэрэг хамаарлыг (\*\*),  $P<0.0001$  Хүчтэй хамаарлыг (\*\*\*) .

ЗАГВАР А: Хүн ам зүйн хүчин зүйлс ба шилжигч эрэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн хамаарлыг харуулсан загвар

ЗАГВАР В: Хүн ам зүй, нийгэм эдийн засгийн хүчин зүйлс ба шилжигч эрэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг харуулсан загвар

ЗАГВАР А-ийн хувьд хүн ам зүйн хүчин зүйлүүд нь статистикийн ач холбогдол бүхий хамааралтай байна. Ажил эрхлэлтийн хамгийн идэвхтэй гэж хэлж болох 25-44 насны эрэгтэйчүүдийн ажил эрхлэх магадлал 15-24 насны эрэгтэй хүн амын ажил эрхлэх магадлалаас 1.08 дахин өндөр, харин ахимаг насны хүн амын ажил эрхлэх магадлал 15-24 насныхны ажил эрхлэх магадлалаас бага байна. ( $P=0.000$ )

Огт боловсролгүй эрэгтэйчүүдийг бодвол бүрэн дундаас дээш боловсролтой эрэгтэйчүүдийн ажил эрхлэх магадлал 2 дахин ( $P=0.009$ ) өндөр байгаа нь ажил эрхлэлт ба боловсролын түвшний хоорондын зэрэг хамаарлыг харуулж байна.

Ганцаараа шилжин ирсэн эрэгтэйчүүдийг бодвол, 6-9 ам бүлтэй өрхийн гишүүдийн ажил эрхлэлт 1.2 дахин өндөр байна. Энэ нь ганцаараа шилжин ирэгсдийн гол шалтгаан нь суралцах явдал байгаатай холбоотой бөгөөд, гэр бүлээрээ шилжин ирсэн өрхийн гишүүд амьжиргаагаа дээшлүүлэхийн тулд ямар нэгэн байдлаар ажил эрхэлдэг гэж хэлж болохоор байна.

А загварыг өргөтгөөд, хавсарсан нөлөөллөөр дахин үнэлснээр ач холбогдолтой үзүүлэлтүүд хэвээр хадгалагдаж, үнэний хувийн харьцаа өссөн ( $\chi^2$ ) бөгөөд, загварын бодитой байдал нэмэгдсэн хандлага ажиглагджээ. (Загвар В) Сонгож авсан хүн ам зүйн үзүүлэлтүүдийн шилжигч эрэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн байдлыг тайлбарлах чадвараас хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийн нь шилжигч эрэгтэй хүн амын ажил эрхлэлтийг тайлбарлах чадвар нь сайн байна. Дээрх хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд ба шилжигч эрэгтэй хүн амын ажил эрхлэлтийн хооронд 0.713 буюу хүчтэй гэж хэлж болохоор хамаарал оршиж байгаа бөгөөд, шилжигч эрэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн байдал дахь дээрх үзүүлэлтүүдийн нөлөөлөл 71.3 хувь, бусад үзүүлэлтүүдийн нөлөөлөл 28.7 хувь байна.

Хөдөөнөөс шилжин ирсэн эрэгтэй хүн амтай харьцуулахад аймгийн төвөөс Улаанбаатарт шилжин ирсэн эрэгтэй хүмүүсийн ажил эрхлэх магадлал нь 10 дахин өндөр ( $P=0.040$ ) байгаа нь хөдөөнөөс шилжин ирэгсэд ихэвчлэн малчид буюу мэргэжил боловсролгүй, ажлын дадлага муутай хүмүүс байдагтай холбоотой юм. Ажил эрхлэх зорилгоор шилжин ирсэн эрэгтэйчүүдийн хувьд ажил эрхлэх магадлал нь бусад зорилгоор шилжин ирсэн эрэгтэй хүн амынхаас 5 дахин өндөр байна. ( $P=0.289$ )

Үүнээс, Улаанбаатар хотод шилжин ирэгсэд маань зорилгоо тодорхой хэмжээгээр биелүүлж байна гэж дүгнэж болохоор байна.

Харин тухайн өрхийн амьжиргааны үзүүлэлт нь эрэгтэй шилжигчийн хувьд ажил эрхлэлтийн байдалтай хамааралгүй гарчээ.

Ложистик регрессийн загварын тэгшитгэлийг логарифмын харьцааг ашиглан шугаман регрест шилжүүлэх ба тэгшитгэлийг гаргаснаар хүн ам зүйн болон нийгэм,, эдийн засгийн хүчин зүйлсийн эрэгтэй хүн амын ажил эрхлэлтэн дэх нэлөөллийн зүй тогтлыг харж болно.

Улаанбаатарт шилжин ирсэн эрэгтэй хүн амын ажил эрхлэлт ба хүн ам зүй, нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдийн хамаарлын тэгшитгэл. Үүнд:

$Y$ -	Ажил эрхлэлт
$X_1$ -	Нас
$X_2$ -	Гэр бүлийн хэмжээ
$X_3$ -	Боловсролын түвшин
$X_4$ -	Шилжин ирэхээс өмнөх байршил
$X_5$ -	Шилжилтийн шалтгаан
$X_6$ -	Сарын хэрэглээний түвшин

$$Y = -4.590 + \begin{pmatrix} 0.281 \\ 1.458 \end{pmatrix} x_1 + \begin{pmatrix} -2.076 \\ -1.128 \\ -1.399 \end{pmatrix} x_2 + \begin{pmatrix} 5.278 \\ 4.712 \end{pmatrix} x_3 + \begin{pmatrix} 1.526 \\ 0.194 \\ 0.538 \\ 0.251 \\ 0.368 \end{pmatrix} x_4 + \begin{pmatrix} 0.815 \\ 1.254 \end{pmatrix} x_5 + \begin{pmatrix} -0.141 \\ -0.045 \\ -0.254 \\ -0.273 \end{pmatrix} x_6;$$

-4.590 нь хамаарах хувьсагчийн босоо тэнхлэгтэй огтлолцох утга юм. Тэгшитгэлээс хараад, эрэгтэй хүн амын ажил эрхлэлтийн байдал нь шилжигчийн настай эерэг, өрхийн ам бүлийн тоотой сөрөг, боловсролын түвшинтэй эерэг, шилжилтийн шалтгаантай эерэг, сарын хэрэглээний түвшинтэй сөрөг хамааралтай байна. Шилжигчдийн наснаас бусад бүх үзүүлэлтүүд тогтмол байхад, нас нь ажил эрхлэлтийн байдалд 1.739 нэгжээр нэлөөлнэ. Хамгийн хүчтэй, эерэг нэлөө үзүүлж буй хүчин зүйл нь шилжигчдийн боловсрол, хамгийн бага нэлөөтэй нь шилжигчийн сарын хэрэглээний түвшин байна. Харин гэр бүлийн хэмжээ нь хамгийн хүчтэй сөрөг нэлөөг үзүүлж байна. Өөрөөр хэлбэл тухайн өрхийн ам бүлийн тоо өсөх буюу гэр бүлийн хэмжээ нэмэгдэхэд ажил эрхлэлт нь буурдаг гэсэн зүй тогтол ажиглагдаж байна.

#### Хүснэгт 7. Эмэгтэй хүн амын ажил эрхлэлтэнд нэлөөлөгч зүйлийн ложистик регрессийн үр дүн, сонгосон үл хамаарах хувьсагчуудаар

Үл хамаарах хувьсагчид	Логарифм/Магадлалын харьцаа	
	Загвар А1	Загвар В1
1. XYН АМ ЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛС		
<i>Nas</i>		
15-24	1.000	1.000
25-44	2.320**	1.325*
45+	9.810	4.296
Боловсролын түвшин		
Бүрэн дундаас дээш	1.001*	8.945***
Бүрэн дунд ба түүнээс доош	0.04	4.215
Боловсролгүй	1.000	1.000

Өрхийн ам бүлийн тоо		
1	1.000	1.000
2-5	0.220	0.105
6-9	0.544	0.324
10+	0.561	0.247
2. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛС		
Шилжин ирэхээс өмнөх байршил		
Нийслэл	1.000	
Аймгийн төв	4.602**	
Тосгон	0.823	
Сумын төв	0.584*	
Хөдөө	1.244	
Гадаад	1.445	
Шилжилтийн шалтгаан		
Ажиллах	2.444***	
Бусад	1.000	
Сарын хэрэглээний түвшин		
Нэн ядуу	1.754	
Ядуу	0.478	
Бага орлоготой	1.000	
Дунд орлоготой	1.521	
Өндөр орлоготой	0.689*	
$\chi^2$	551.280	558.236
$R^2$	0.518	0.781

**Тайлбар:**  $P<0.05$  түвшинд ач холбогдлын коэффициентийг тооцөв.  
 $0.05>P>0.01$  Хоёр хувьсагчийн сул хамаарлыг (\*),  $0.01>P>0.0001$  Дунд зэрэг хамаарлыг (\*\*),  $P<0.0001$  Хүчтэй хамаарлыг (\*\*\*)

ЗАГВАР А1: Хүн ам зүйн хүчин зүйлс ба шилжигч эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн хамаарлыг харуулсан загвар

ЗАГВАР В1: Хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс ба шилжигч эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг харуулсан загвар

Улаанбаатарт шилжин ирсэн эмэгтэй хүн амын хувьд тодорхойлсон хүн ам зүйн хүчин зүйлс, хүн ам зүйн ба нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийн ажил эрхлэлтэн дэх нөлөөллийг харуулсан загвар нь эрэгтэй хүн амын хувьд тодорхойлогдсон загвартай адилхан хандлагатай гарсан байна.

Загвар А1-ийн хувьд шилжигч эмэгтэйчүүдийн нас, боловсролын түвшин нь ажил эрхлэлтийн байдалтай статистик хамааралтай гарч, харин өрхийн ам бүлийн тоо төдийлөн нөлөөлөлгүй байна.

Загвар В1-ийн хувьд үнэний хувийн харьцаа өсөж, энэхүү загварт багтсан үзүүлэлтүүдийн шилжигч эмэгтэй хүн амын ажил эрхлэлтийг тайлбарлах чадвар нэмэгджээ. Өөрөөр хэлбэл, дан хүн ам зүйн үзүүлэлтүүдээс хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд нь ажил эрхлэлтийн байдалд хүчтэй нөлөөлж байгаа төдийгүй эдгээр үзүүлэлтүүдийн хамаарах хувьсагч дахь нөлөөлөл нь 78.1 хувь байна. Харин 21.9 хувь нь загварт багтаагүй бусад үзүүлэлтүүдийн нөлөөлөл байгаа ажээ.

Огт боловсролгүй эмэгтэйчүүдийг бодвол бүрэн дундаас дээш боловсрол эзэмшсэн эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт 8.9 дахин өндөр ( $P=0.025$ ) байгаа нь эрэгтэй хүн амтай харьцуулахад 4 дахин өндөр үзүүлэлт байна. Энэ нь боловсролгүй ч гэсэн ажил эрхлэх боломж эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүдийн хувьд өндөр байгаа гэсэн үг юм.

Шилжин ирэхээс өмнөх байршилын хувьд хөдөөнөөс шилжин ирсэн эмэгтэйчүүдтэй харьцуулахад аймгийн төвөөс шилжин ирэгсдийн хувьд

ажил эрхлэлт нь бараг 4 дахин өндөр ( $P=0.003$ ) байхад, сумын төвөөс шилжин ирэгсдийн ажил эрхлэх магадлал ялимгүй бага байна. ( $P=0.042$ )

Ажил эрхлэх зорилгоор шилжин ирсэн эмэгтэйчүүдийн ажил эрхлэх магадлал бусад шалтгаанаар шилжих хөдөлгөөнд оролцсон эмэгтэйчүүдийн ажил эрхлэх магадлалаас 2 дахин өндөр байна. Хэрэглээний түвшин эрэгтэй хүн амтай харьцуулахад нь эмэгтэй хүн амын ажил эрхлэлтэнд илүүтэй нөлөө үзүүлж байна. Сарын хэрэглээний зардлын түвшин нь харьцангуй доогуур буюу бага орлоготой эмэгтэйчүүдийг бодвол өндөр орлоготой эмэгтэйчүүдийн ажил эрхлэх магадлал 0.7 дахин бага байгаагаас ( $P=0.049$ ) амьжиргааны түвшин өндөртэй өрхийн эмэгтэй гишүүдийн хувьд ажил эрхлэлт доогуур байж болох юм гэж хэлж болохоор байна.

Улаанбаатарт шилжин ирсэн эмэгтэй хүн амын ажил эрхлэлт ба хүн ам зүй, нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдийн хамаарлын тэгшитгэлийг доорх байдлаар илэрхийлж байна.

$$Y = -5.987 + \begin{pmatrix} 1.037 \\ 2.232 \end{pmatrix} X_1 + \begin{pmatrix} -1.494 \\ -0.729 \\ -0.702 \end{pmatrix} X_2 + \begin{pmatrix} 6.573 \\ 7.468 \end{pmatrix} X_3 + \begin{pmatrix} -0.530 \\ 5.289 \\ 5.311 \\ 5.359 \\ 5.042 \end{pmatrix} X_4 + \begin{pmatrix} 6.964 \\ 7.607 \end{pmatrix} X_5 + \begin{pmatrix} -0.738 \\ -0.301 \\ -0.380 \\ -0.253 \end{pmatrix} X_6;$$

Эмэгтэй хүн амын ажил эрхлэлтэнд хамгийн хүчтэй нөлөөг байршил, хамгийн бага нөлөөг нас үзүүлж байхад, хамгийн хүчтэй сөрөг нөлөөг шилжигчийн сарын хэрэглээний түвшин үзүүлж байна. Өрхийн ам бүлийн тоо нэгжээр өөрчлөгдхөд эмэгтэй хүн амын ажил эрхлэлт 2.925 нэгжээр буурна. Эсрэгээр шилжигч эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нэгжээр өсөхөд тэдний ажил эрхлэлт нь 14.041 нэгжээр өснө.

## Дүгнэлт

Улаанбаатар хотод шилжин суурьшсан 10 хүн тутмын 6-7 нь шилжин ирснээсээ хойш ямар нэгэн ажил эрхэлсэн бөгөөд эдгээр хүн амын 94.2 хувь нь одоогийн байдлаар ажил эрхэлж байна. Ажил эрхэлж байгаа хүн амын дотор хувийн ААН/байгууллагад ажиллагсад болон хувиараа ажил/наймаа хийж байгаа хүмүүсийн хувийн жин харьцангуй өндөр байна.

Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн тэн хагасаас илүү нь ажлын нөхцөл болон цалин хөлсний хувьд өмнөхөөсөө илүү сайн ажил эрхэлж байгаа ба тэдний хувьд орлого, худалдан авах худалдаалах боломж, орон сууцны нөхцөл, эрүүл мэнд зэрэг үзүүлэлтүүдэд нэлээд ахиц гарсан эерэг үр дүн харагдаж байна.

Шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтийн байдалд нөлөөлнө гэж таамагласан хүчин зүйлүүд болох шилжигчийн нас, боловсролын түвшин, өрхийн ам бүлийн тоо, шилжин ирэхээс өмнөх байршил, шилжилтийн шалтгаан, сарын хэрэглээний түвшин зэрэг хувьсагчид бүгд ажил эрхлэлтийн байдалтай статистикийн ач холбогдол бүхий хамааралтай, хамаарлын хүч нь харилцан адилгүй байна. Эдгээр үзүүлэлтүүдийн эрэгтэй хүн амын ажил эрхлэлтийг тайлбарлах чадвар 71 хувь, эмэгтэй хүн амын ажил эрхлэлтийг тайлбарлах чадвар 78 хувь байна.

Шилжигч эрэгтэй хүн амын ажил эрхлэлтэнд хамгийн хүчтэй ээрэг нөлөөтэй хүчин зүйл нь боловсролын түвшин байхад, сарын хэрэглээний түвшин төдийлөн нөлөөтэй үзүүлэлт биш байв. Ерөнхийдөө 25-44 насны, бүрэн дундаас дээш боловсролтой, аймгийн төвөөс, ажиллах зорилгоор шилжин ирсэн эрэгтэйчүүдийн ажил эрхлэх магадлал хамгийн өндөр байна. Энэ хандлага эмэгтэй хүн амын хувьд ч адилхан байна. Гэхдээ шилжигч эмэгтэй хүн амын ажил эрхлэлтэнд хамгийн хүчтэй нөлөө үзүүлж байгаа хүчин зүйл нь байршил байхад, насны нөлөөлөл маш бага байгаа юм.

### **Ном зүй**

1. НХХЯ, НҮБХАС, ХАССТ. “Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа”, УБ хот, 2000 он
2. НҮБХАС, ҮСГ. “Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөн хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа”, УБ хот, 2002 он
3. НҮБХАС, ҮСГ. “2000 оны хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн”, УБ хот, 2001 он
4. НҮБХАС, ҮСГ. “Хүн амын эдийн засгийн идэвхи: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа”, УБ хот, 2002 он
5. ОУХБ. “Монгол дахь албан бус хэвшил”, УБ хот, 2001 он
6. МУ-ЫН ЗГ, НҮБХХ. “Монголын хүний хөгжлийн илтгэл”. УБ хот, 1997 он
7. МУ-ЫН ЗГ, НҮБХХ. “Монголын хүний хөгжлийн илтгэл”. УБ хот, 2000 он
8. МУ-ЫН ЗГ, НҮБХХ. “Монголын хүний хөгжлийн илтгэл”. УБ хот, 2003 он
9. НХХЯ, НҮБХАС. “Хүн ам ба хөгжил дээд хэмжээний уулзалт”, УБ хот, 2001 он
10. ҮСГ, НҮБХХ. “Хүн амын амьжиргааны түвшний судалгаа”, УБ хот, 1999 он
11. ҮСГ. “Монгол Улсын статистикийн эмхэтгэл”, УБ хот, 2000 он
12. ҮСГ. “Монгол Улсын статистикийн эмхэтгэл”, УБ хот, 2001 он
13. ҮСГ. “Монгол Улсын статистикийн эмхэтгэл”, УБ хот, 2002 он
14. НҮБХАС, МХАХН, ХАССТ. “Нийгмийн статистикийн үндэс”, УБ хот, 2002 он
15. НҮБХАС, МХАХН, ХАССТ. “Монголын хүн амын сэтгүүл”, УБ хот, дугаар 6, 2002 он
16. НҮБХАС, МХАХН, ХАССТ. “Монголын хүн амын сэтгүүл”, УБ хот, дугаар 8, 2003 он
17. UNPFA. “Readings in Population research methodology”, USA, 1993
18. IUSSP. “Basic data needed for the study of urbanization”, Belgium, 1974
19. IUSSP. “The measurement of urbanization and projection of urban population”, Belgium, 1975
20. Layth C.Alwan. “Statistical process analysis”, USA, 2000

# **СУРГАЛТ**

---

## СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙН АСУУДАЛД

Д. Чимгээ  
МУИС, ЭЗС-ийн багш, док /PhD/

Манай улсын эрдэм шинжилгээ, судалгааны төв, хүрээлэн, институт, бизнес эрхэлж буй пүс, компани болон төр, олон нийтийн байгууллага, бие даасан эрдэмтэн судлаачид улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжлийн судалгаа, шинжилгээ хийдэг.

. Улс үндэстний хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхэд улам нарийн төвөөгтэй болж байгаа өнөө үед нэг талаас судалгаа, шинжилгээний ажлын ач холбогдол өндөрсөж, хамрах хүрээ нь ч өргөжиж байхад нөгөө талаас уг ажил нь судлаачдын зүгээс өндөр мэдлэг, чадвар, хүч чармайлтыг шаардсан нарийн ажил болон өөрчлөгдөж байна.


.Практикаас харахад манай судлаач, шинжээчид судалгааныхаа мэдээллийг цуглуулах, цуглуулсан мэдээлэлдээ дүн шинжилгээ хийхдээ ихээхэн цаг хугацаа зарцуулж байгаа нь ажиглагддаг. Иймээс энэ байдалд дүгнэлт хийж судалгааны мэдээллийг богино хугацаанд үр дүнтэй боловсруулах нэгэн арга замын талаар уншигч олондоо өгүүлж саналаа хуваалцахыг судлаач зорьжээ.

Манай улсын эрдэм шинжилгээ, судалгааны төв, хүрээлэн, институт, бизнес эрхэлж буй пүс, компани болон төр, олон нийтийн байгууллага, бие даасан эрдэмтэн судлаачид улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжлийн судалгаа, шинжилгээ хийдэг ба эдгээр ажлын үр дүнт нийгмийн хөгжилд, байгууллагын бодлого, шийдвэр, стратеги, зорилго, үйл ажиллагаанд тусган ашигладаг билээ. Улс үндэстний хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхэд улам нарийн төвөөгтэй болж байгаа өнөө үед нэг талаас судалгаа, шинжилгээний ажлын ач холбогдол өндөрсөж, хамрах хүрээ нь ч өргөжиж байхад нөгөө талаас уг ажил нь судлаачдын зүгээс өндөр мэдлэг, чадвар, хүч чармайлтыг шаардсан нарийн ажил болон өөрчлөгдөж байна.

Аливаа судалгааны ажил тухайн байгууллага, хувь хүний зүгээс ихээхэн хөрөнгө, хүч, цаг хугацааг шаарддаг бөгөөд үүнд судалгааны мэдээлэл цуглуулах, боловсруулах, шинжлэх ажил техник ажиллагаа их байдаг нь ч нөлөөлдөг. Практикаас харахад манай судлаач, шинжээчид судалгааныхаа мэдээллийг цуглуулах, цуглуулсан мэдээлэлдээ дүн шинжилгээ хийхдээ ихээхэн цаг хугацаа зарцуулж байгаа нь ажиглагддаг. Иймээс энэ байдалд дүгнэлт хийж судалгааны мэдээллийг богино хугацаанд үр дүнтэй боловсруулах нэгэн арга замын талаар уншигч олондоо өгүүлж саналаа хуваалцахыг миний бие зорилоо.

Энэ арга бол SPSS for Windows программ хангамжийг судалгааны мэдээллийг боловсруулах, шинжлэхэд ашиглах явдал юм. Тус аргыг судалгааны мэдээллийг боловсруулах уламжлалт арга болон сүүлийн үеийн компьютерийн программ ашиглан боловсруулах аргуудтай харьцуулбал илүү боловсронгуй бөгөөд нийгмийн статистикийн тоон шинжилгээний олон нарийн аргуудаар мэдээллийг богино хугацаанд шинжлэх, үр дүнгийн хүснэгтүүдийг байгуулах боломжтой.

### Зураг 1. SPSS программын цонх



**SPSS for Windows** программ нь Америк, Англи, Австрали, Омнөд Солонгос зэрэг өндөр хөгжсөн орнуудад түгээмэл хэрэглэгддэг бөгөөд сүүлийн үед дэлхийн бусад орон, тухайлбал манай улсад хэрэглээ нь улам ихэсч байгаа программуудын тоонд зүй ёсоор орж байгаа юм. Энэ программын онцлогуудаас дурдвал:

- Windows системийн орчинд ажилладаг;
- Статистикийн болон түгээмэл хэрэглэгддэг тоон шинжилгээний аргуудыг багтаасан;
- Төрөл бүрийн судалгаа, түүний дотор анкет, асуулгын төрлийн судалгааны мэдээлэл боловсруулдаг;
- Туршлага багатай хэрэглэгч ч энгийн шинжилгээний аргуудыг ашиглан тооцоолол хийх боломжтой;
- Хэрэглэгчтэй харилцан ярилцаж, ажиллах зарчимд тулгуурласан;
- Энгийн хүснэгтийн хэлбэрээр мэдээллийг оруулах, харах, засварлах системтэй;
- Excel зэрэг бусад программуудтай мэдээлэл солилцох боломжтой;
- Өндөр чадварын дүрслэл бүхий горимд графиктай ажиллах, түүнд засвар хийх боломжтой;
- Үр дүнгийн баримт, тайлан, маягтуудыг төрөл бүрийн формат ашиглан боловсруулах, засвар хийх, хэвлэн гаргах чадвартай;
- Hypertext форматаар нэмэлт лавлах системийг багтаасан зэрэг болно.

Энгийн нэг жишээн дээр SPSS программын зарим боломжуудыг ашиглах замаар энэ программын ажиллагааны талаар ерөнхий ойлголт өгье. Жишээлбэл, бид хадгаламж эзэмшигчдийн банканд итгэх итгэлийг тодорхойлох зорилгоор судалгаа явуулж түүний дагуу цуглувансан мэдээлэлдээ шинжилгээ хийх шаардлагатай байна гэж үзье.

1. Эхлээд судалгааны мэдээллээ цуглувлахын тулд судалгааны загвараа гаргах хэрэгтэй. Үүнийг гүйцэтгэж Загвар 1-д харуулав.

## Загвар 1. ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДЭЭС АВАХ АСУУЛГА

Албан хэрэгцээнд  
Тусгай дугаар

1. Та аль дүүрэгт амьдардаг вэ?
- 1) Баянгол
  - 2) Сүхбаатар
  - 3) Чингэлтэй
  - 4) Баянзүрх
  - 5) Хан-Уул
  - 6) Сонгино Хайрхан

2. Таны нас?
- 1) 18-25
  - 2) 26-35
  - 3) 35-50
  - 4) 50-65
  - 5) 65-аас дээш

3. Та манай хадгаламж эзэмшигч болоод хэдэн жил болж байгаа вэ?
- 1) 0-2
  - 2) 3-4
  - 3) 5-6
  - 4) 7-8
  - 5) 9-10
  - 6) 11- ээс дээш

4. Манай банкны үйлчилгээ танд ямар санагддаг вэ?
- 1) Сайн
  - 2) Дунд
  - 3) Муу

5. Манай банкны хадгаламжийн хүүг та юу гэж үздэг вэ?
- 1)Өндөр
  - 2)Боломжийн
  - 3)Бага
  - 4)Хэтэрхий бага
  - 5)Мэдэхгүй

6. Та манай банканд итгэдэг үү?
- 1) Итгэдэг
  - 2) Үгүй
  - 3) Мэдэхгүй

7. Та манай хадгаламжаас бусад үйлчилгээгээр үйлчлүүлдэг үү?
- 1) Тийм
  - 2) Үгүй

2. Цуглуулсан мэдээллийг SPSS программд оруулахын тулд кодчлолыг хэрхэн ашиглаж болохыг Хүснэгт 1-д үзүүллээ.

**Хүснэгт 1. Хадгаламж эзэмшигчдээс авах асуултыг кодчлох систем**

Хувьсагчийн нэр (Variable name)	Өгөгдлийн төрөл (Type)	Хувьсагчийн утга (Variable label)	Кодчлол/ Утга (Coding details/Value labels)
IDNUM	Number 1-3	Дэс дугаар	Хүн бүрд дугаар өгч ялгана.
REGION	Number 4(1)	Та аль дүүрэгт амьдардаг вэ?	1=Баянгол 2=Сүхбаатар 3=Чингэлтэй 4=Баянзүрх 5=Хан-Уул 6=Сонгино Хайрхан
AGE	Number 5(1)	Таны нас?	1=18-25 2=26-35 3=35-50 4=50-65 5=65-аас дээш
HOWYEARS	Number 6(1)	Та манай хадгаламж эзэмшигчээр хэдэн жил болж байгаа вэ?	1=0-2 2=3-4 3=5-6 4=7-8 5=9-10 6=11- ээс дээш
QSERVICE	Number 7-8(2)	Манай банкны үйлчилгээ танд ямар санагддаг вэ?	1=Сайн 2=Дунд 3=Муу -9= Орхигдсон
RATE	Number 9-10(2)	Манай банкны хадгаламжийн хүрг та юу гэж үздэг вэ?	1=Өндөр 2=Боломжийн 3=Бага 4=Хэтэрхий бага 5=Мэдэхгүй -9= Орхигдсон
TRUST	Number 11(1)	Та манай банканд итгэдэг үү?	1=Итгэдэг 2=Үгүй 3=Мэдэхгүй
OTHERSER	Number 12(1)	Та манай бусад үйлчилгээгээр үйлчлүүлдэг үү?	1=Тийм 2=Үгүй

3. Асуулга, анкетаар авсан судалгааны мэдээллийг оруулах тохиолдолд SPSS программ дээр асуултуудыг хувьсагчдаар төлөөлүүлж илэрхийлдэг. Судалгааны загварын дагуу цуглуулсан мэдээллээ SPSS программд оруулахын тулд эхлээд загварынхаа бүтцийг Variable view (Хувьсагчийг харах) горимд тодорхойлж өгөх хэрэгтэй. Загварын бүтцийг оруулсны дараа дэлгэцийн агуулга Зураг 2-д үзүүлсэн байдалтай болно.

**Зураг 2. Судалгааны загварын бүтцийг оруулах**

	Name	Type	Width	Decimals	Label	Values	Missing	Columns	Align	Measure
1	idnum	Numeric	3	0	Дэс дугаар	None	None	6	Right	Scale
2	region	Numeric	1	0	Та албан дүүрэгт а	{1, Баянгол}...	None	8	Right	Nominal
3	age	Numeric	1	0	Таны нас?	{1, 16-26}...	None	8	Right	Scale
4	howyears	Numeric	1	0	Та манай хадгала	{1, 0-2}...	None	8	Right	Scale
5	qservice	Numeric	2	0	Манай банкны үйл	{1, Сайн}...	-9	8	Right	Nominal
6	rate	Numeric	2	0	Манай банкны ха	{1, Өндөр}...	-9	8	Right	Nominal
7	trust	Numeric	1	0	Та манай банканд	{1, Итгэдэг}...	None	8	Right	Nominal
8	otherser	Numeric	1	0	Та манай банкны	{1, Тийм}...	None	8	Right	Nominal
9										
10										
11										
12										
13										
14										
15										
16										
17										
18										
19										
20										
21										
22										
23										
24										
25										
26										
27										
28										

4. Дараа нь Data view (Мэдээлэл харах) горимд кодчлох схемийг ашиглан оруулахад бэлэн болгосон мэдээллээ бичиж өгнө. Энэхүү оруулсан мэдээлэл нь SPSS программ дээр хэрхэн дүрслэгдэхийг Зураг 3-д үзүүлэв. Эндээс харахад мэдээлэл оруулах ажиллагаа Excel программтай ижил төстэй байгааг уншигчид анзаарч байгаа байх.

**Зураг 3. Судалгааны мэдээлэл оруулсан байдал**

	idnum	region	age	howyears	qservice	rate	trust	otherser	var	var
1	100	1	2	1	1	1	1	2		
2	101	2	1	2	2	2	2	2		
3	102	3	3	3	3	1	1	2		
4	103	1	4	1	1	2	2	2		
5	104	2	5	3	2	1	3	2		
6	105	3	2	4	3	2	3	1		
7	106	4	3	5	1	1	2	2		
8	107	5	2	3	1	2	1	1		
9	108	6	4	2	1	1	1	1		
10	109	6	5	3	2	2	2	2		
11	110	2	3	4	2	3	3	2		
12	111	3	2	5	-9	1	1	2		
13	112	4	1	2	1	2	2	1		
14	113	5	1	6	2	3	3	1		
15	114	6	2	1	3	.	1	1		
16	115	2	3	1	2	2	2	2		
17	116	3	4	1	3	2	3	2		
18	117	1	5	2	2	2	1	1		
19	118	1	4	1	2	1	2	2		
20	119	3	2	1	2	-9	3	1		
21	120	5	1	3	-9	1	1	2		
22										
23										
24										
25										
26										


5. Мэдээллээ үнэн зөв оруулсны дараа та шинжилгээгээ эхэлж болно. Энгийн зарим нэг шинжилгээнүүдийг хийж үзүүлье. Тухайлбал, Судалгаанд хамрагдсан нийт хадгаламж

эзэмшигчдийг насны интервалаар бүлэглэсэн тархалтыг тооцож гаргая. Үүний тулд программын цэсийн:

Analyze ----- Descriptive Statistics ----- Frequencies

командуудыг дэс дараалан ажиллуулсны дараа дэлгэцэнд гарч ирэх асуулгын цонхонд AGE буюу Таны нас? гэсэн хувьсагчийг сонгож насны интервалаар давтамжийг (Frequency) тодорхойлно. SPSS нь шинжилгээний хариуг Output нэртэй үр дүнгийн цонхонд харуулдаг (зураг 4).


Зураг 4. Хадгаламж эзэмшигчдийг насны интервалаар бүлэглэсэн тархалт



6. SPSS программ нь мэдээллийн харагдах хэлбэрийг сайжруулах зорилготой форматийн олон хэрэгслүүдтэй бөгөөд эдгээрийг та бүхэн ашиглан үр дүнгийн хүснэгтуүдэд үсгийн фонтийн нэр, хэмжээ, өнгө өөрчлөх, налуу, тод, голлуулж бичих, шинэ текст оруулах зэрэг өөрчлөлтүүдийг хялбархан хийх боломжтой. Энэ ажиллагаа Microsoft Office-ийн багцад орох Word, Excel, Power Point зэрэг программууд дээр хийгддэг форматлах үйл ажиллагаатай адилхан хийгддэг тул та бүхэнд эдгээр боломжуудыг ашиглахад хялбар байх болно. Энэ ажиллагааг хийснээр та судалгааны мэдээлэл боловсруулалтынхаа эцсийн үр дүнг харахад эвтэйхэн, уншихад ойлгомжтой хэлбэрт


хөрвүүлж улмаар хэвлэн авч чадах юм. Жишээ болгон өмнө үзүүлсэн үр дүнгийнхээ харагдах хэлбэрийг сайжруулан үзүүлье.

Зураг 5. Үр дүнгийн харагдах хэлбэр



- SPSS программын график байгуулах, засварлах систем нь их боловсронгуй. Жишээлбэл, өмнө хийсэн шинжилгээний үр дүнг графикаар дүрслэн харья.


Зураг 6. Үр дүнг графикаар харуулсан байдал



- SPSS программ нь шинжилгээний үр дүн, хүснэгт, баримт бичгүүдийг өндөр түвшинд боловсруулан хэвлэдэг бөгөөд

үүгээрээ энэ чиглэлээр ашиглагддаг бусад программуудтай харьцуулбал ихээхэн давуу талтай. Жишээ нь эцсийн үр дүнг хэвлэхийн өмнө урдьчилан харж болдог (Зураг 7,8).

**Зураг 7. Шинжилгээний үр дүнг графикаар хэвлэхийн өмнө**



**Зураг 8. Шинжилгээний үр дүнг хэвлэхийн өмнө**

Таны нас? * Та манай хадгаламж эзэмшигч болоод хичнээн жил болж байгаа вэ? * Та манай банканд итгэдэг үү? * Та манай банкны бусад үйлчилгээгээр үйлчлүүлдэг үү?								
Count								
Тийм	Итгэдэг	Таны нас?	Та манай хадгаламж эзэмшигчээр хичнээн жил болж байгаа вэ?					
			0-2	3-4	5-6	7-8	9-10	11-12
Үгүй	Итгэдэг	Нас	26-35	1	1			2
			51-65		1			1
			65-аас дэш		1			1
Мэдэхгүй	Дун	Нас	18-25	1				1
			Дун		1			1
								1
Үгүй	Итгэдэг	Нас	18-25				1	1
			26-35	1			1	2
			36-50		1			1
Мэдэхгүй	Дун	Нас	18-25				1	1
			36-50	1			1	2
			51-65	2				2
Үгүй	Итгэдэг	Нас	65-аас дэш		1			1
			Дун	3	1	1	1	6
								3
Мэдэхгүй	Нас	Нас	36-50				1	1
			51-65	1				1
			65-аас дэш		1			1
Мэдэхгүй	Дун	Нас						3

Эцэст нь өгүүлэхэд, уншигч та бүхэнд SPSS программын тухай, түүний зарим нэг боломжуудыг жишээн дээр товчлон үзүүллээ. Хэрвээ та судалгааны ажил эрхэлдэг бол энэхүү программыг ашигласнаар нийгмийн статистикийн тоон шинжилгээний олон аргуудаар судалгааныхаа мэдээллийг автоматаар, богино хугацаанд, өндөр

нарийвчлалтай тооцон гаргаж чадахаас гадна таны судалгааны мэдээлэл боловсруулах ажил тань бүтээл өндөртэй байна гэдэгт итгэж болно.

Энд өгүүлсэн программ хангамжийн талаар зохих мэдлэгийг олгох, түүнийг ашиглах чадварыг эзэмшүүлэх сургалтыг МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль дээр явуулдаг. Мөн ХАССТөв дээр үндэсний судлаачдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг “Нийгмийн судалгааны статистик шинжилгээ SPSS программыг ашиглах нь” сэдвээр зохион байгуулж байна.

Уншигч та уг программтай холбоотой санал, хүсэлтээ дараах хаягаар ирүүлээрэй.

Монгол Улсын Их Сургууль,  
Эдийн Засгийн Сургууль,  
Хун Ам Сургалт Судалгааны Төв.  
Бага тойруу 7, Шуудангийн хайрцаг 46а/301,  
И-мэйл: [prtc@ses.edu.mn](mailto:prtc@ses.edu.mn)  
[enebol@yahoo.com](mailto:enebol@yahoo.com)

### Номзүй

1. SPSS 10.0, 11.5 программ хангамж
2. <http://www.spss.com>

# ОЛОН УЛСЫН ХҮН АМЫН СТАТИСТИКИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ БА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Д.Тунгалаг

ОУХДС-ийн сургалтын албаны дарга, доктор /PhD/

Судлаач энэхүү бүтээлээрээ хүн амын мэдээллийн гол эх үүсвэрүүдийн нэг болох хүн амын тооллогын түүхийг З үе шаттайгаар авч үзсэн бөгөөд тооллогын асуулгад ямар ямар үзүүлэлтүүдийг оруулж авч үзэж байсан талаар дэлгэрэнгүй танилцуулахыг зорьжээ.

Түүнчлэн хүн амын тооллого болон мэдээллийн бусад эх үүсвэрүүдийн хоорондын уялдаа холбоо, тооллогын үр дүнд үндэслэн тооцдог үзүүлэлтүүдийг хэрхэн тооцдог талаар авч үзсэн байна.

Эцэст нь судлаач тооллогын мэдээлэлд үндэслэн хүн амын хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг тооцоход нас дэвшилтийн арга хэрэглэдэг талаар болон хэтийн тооцоог хийх хамгийн энгийн арга болох бүрэлдэхүүний аргын талаар төвч мэдээлэл хүргэж байна.

## Хүн амын тооллогын түүхэн үе шатууд

Хүн амын мэдээлэл авах нэг гол эх үүсвэр бол хүн амын тооллого юм.

Хүн амын нэвтэрхий тольд дурьдсанаар тооллогын өнөөгийн түүх З үе шаттай.

Нэгдүгээр үе шатанд (XVIII-XIX зууны эхний хагас) хүн амын тооллого явуулах суурь тавигдсан гэж үздэг. Тэр үед хүн амын тооллого АНУ, Англид 10 жил тутам, Франц, Шведэд 5 жил тутам, Австралид 3-4 жилд нэг удаа хийгддэг байсан бол Норвеги, Исланд, Данид тогтмол биш явагдаж байв. Энэ үе шатанд тооллогын хөтөлбөр нь бүх хүн амыг хамардаггүй байсан. Тухайлбал, АНУ-д 1790 оны тооллогоор зөвхөн өрхийн тэргүүний нэр, цагаан арьстан эмэгтэйчүүдийн тоо, боолчуудын тоог тусгаж байжээ. Францын 1801 оны тооллогод хүйс, гэрлэсэн эсэх талаар ердөө хоёрхон асуулт байсан. Харин Английн 1801 оны тооллого нь худалдаа, газар тариалан, аж үйлдвэрт ажиллаж байгаа өрхийн тэргүүнд л хамаарлтай байв.

Хоёрдугаар үе шатанд (XIX зууны хоёрдугаар хагасаас XX зууны эхний хагас хүртэл) хүн амын тооллого нь Европын бараг бүх орнууд, Америк тив, Ази, Африкт явагдаж байсан байна. Хүн амын тооллогын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан хүн бол Бельгийн эрдэмтэн А.Кетле юм. Тэрээр Бельгийн 1846 оны тооллогыг нэг хоногийн хугацаатай явуулахаар боловсруулсан ба тооллого явуулах үед оршин суугчдын байгаа газрыг (бэлэн хүн ам) анх удаа тусгасан хүн юм. Энэ үеэс эхлэн олон улсын хүн амын тооллогын орчин үеийн зарчим (нэг өдрийн, анкет бөглөх, бичиг үсгийн мэдлэг, шилжих хөдөлгөөн, төрөлт, нас баралт г.м.) үүссэн гэж үздэг. Бэлэн хүн амаас гадна суурин хүн ам гэсэн ойлголт гарч ирсэн.

Тооллого явуулах, үр дүнг боловсруулах шинжлэх ухааны үндэслэл 1853 онд Брюссельд болсон Олон улсын статистикийн конгрессын нэгдүгээр чуулганаар, дараа нь 1872 онд болсон түүний Петербургийн чуулганаар тавигджээ. Тооллогонд оролцож байгаа хүн

амын үндсэн категори, тооллогын программын шаардлагууд, түүнийг явуулах хугацааны талаар нарийвчлан хэлэлцжээ.

Хүн амын тооллогын онол, практикийн хөгжлийн гуравдугаар үе шат (орчин үеийн) нь Арабын орнуудад хүн амын тооллого явуулж эхэлсэн ХХ зуны дунд үеэс эхэлжээ.

Энэ үе шатанд хүн амын тооллогын программын ажиллаж буй эсэх, шилжих хөдөлгөөний талаарх асуултанд нэлээд анхаарах болсон. АНУ, Япон, Баруун Герман, Энэтхэг, Филиппин зэрэг орнуудад зөвхөн суурин хүн амыг, Их Британи, Бруней, Танзани, Туркэд зөвхөн бэлэн хүн амыг тоолж байсан байна. Орос, Болгар, Унгар, Итали зэрэг орнуудад бэлэн ба суурин хүн амыг зэрэг тоолж байв.

Хүн амын тооллогын янз бүрийн программаар төрөл бүрийн мэдээ цуглуулах нь олон улсын зэрэгцүүлэлт хийхэд хүндрэлтэй гэдэг нь ойлгомжтой. Иймд НҮБ хүн амын тооллогын талаар дэлхий нийтийн нийцүүлсэн зарчмыг боловсруулахад ихээхэн ажил хийж байна. НҮБ-ын боловсруулсан аргачлал нь тооллогын тусламжтайгаар үндэсний хэмжээнд хүн амын бүртгэлийг хөгжүүлэх үндэс болдог. НҮБ хүн амын тооллогыг ихэнх орнуудын дэмжиж байгаагаар 10 жилд нэг удаа явуулж байх санал боловсруулсан.

Тооллогын үед хүн амыг хоёр үндсэн категори болгон хуваадаг. Энэ нь суурин ба бэлэн хүн ам юм. Суурин хүн амд хүн амын тооллогын үед байсан газраас үл шалтгаалан тухайн газарт амьдарч байгаа хүн ам багтдаг. Бэлэн хүн амд тооллого явагдаж байх үед тухайн газарт амьдарч байгаа хүн ам орно. Суурин хүн амыг тоолоход *тур* эзгүй хүн ам, бэлэн хүн амыг тоолоход *тур* суугаа хүн ам гэж ялгадаг. Хүн амыг суурин ба бэлэн гэж хуваах нь эдийн засгийн чухал утга агуулдаг. Жишээ нь орон байр, сургууль, эмнэлгийн хэрэгцээг тооцохын тулд суурин хүн амын тоог, харин нийтийн тээвэр, дэлгүүр, үйлчилгээний хүрээний хэрэгцээг тооцохын тулд бэлэн хүн амын тоог ашигладаг.

Орчин үеийн хүн амын тооллого нь хүн амын талаар нэлээд дэлгэрэнгүй мэдээлэл өгдөг. Хүн амын тооллого явуулахын тулд *тооллогын программ* боловсруулдаг. Дэлхийн ихэнх орнуудад тооллогын программыг анкетийн хэлбэрээр шуудангаар тараадаг. Тухайн программын асуултанд зарим тохиолдолд зөвхөн хүн амын төрсөн он, нас хүйс, гэрлэсэн эсэх, хүүхдийн тоо гэх мэт үзүүлэлтүүд байдаг бол зарим тохиолдолд ажиллаж буй газар, үйл ажиллагааны төрөл, байдал (хувиараа эрхлэх аж ахуй, хөлсний ажилчин гэх мэт), орлогын эх үүсвэр гэсэн үзүүлэлтүүдийг тусгасан байх жишээтэй. Үүнээс гадна хүн амын боловсрол, мэргэжлийн түвшин, суралцсан хугацаа зэргийг асуусан байдаг. Мөн түүнчлэн тооллогын асуултанд аль улсын иргэн, дайнд оролцсон эсэх, сэтгэл мэдрэлийн байдал, тахир дутуугийн зэрэг, шашин шүтлэг, төрөлх болон ярианы хэл гэх мэт асуултууд орсон тохиолдол ч байдаг.

Тооллогын хуудасны эдгээр асуултыг бөглөхөд зайлшгүй шаардлагатай нэг зүйл бол тооллого явуулах үед хаана, ямар газар байсан талаар тодорхой тусгах явдал юм. Ийм маягаар байнгын оршин суугчдын байгаа газар, өөр газар байсан хугацаа зэргийг тодорхой зааж, түүний үндсэн дээр дотоод, гадаад *шилжих хөдөлгөөнийг* тодорхойлдог байна. Заримдаа илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах зорилгоор хэдэн жил гэр бүл байсан, хэдэн удаа гэрлэсэн, салсан шалтгаан зэрэг асуултуудыг оруулж өгдөг. Мөн амьдралын нөхцлийн талаар хэдэн өрөө байртай, халаалтын эх үүсвэр гэх мэт асуултууд ч нэлээд оруулдаг.

Хүн амын тооллогын эдгээр асуулгууд үндсэндээ хүн амын ерөнхий мэдээллийг харуулахаас гадна практикт энэ судалгаа нь нэлээд гүнзгий ач холбогдолтой. Үндэсний онцлогоос хамаарч хүн амын тооллого нь нийгэм, эдийн засгийн онцгой мэдээлэл болж чаддаг. Жишээ нь, АНУ-д гадаад шилжилт хөдөлгөөн чухал байдаг учраас тухайн орны хүн амын тооллогод өмнө нь амьдарч байсан газар маш чухал үзүүлэлт болдог ажээ. Энэтхэгт гэхэд ямар үндэстэн гэдэг нь чухал байдаг бол дорно дахины орнуудад шашин шүтлэгийн асуулт гол асуулга болдог.

Хүн амын талаарх мэдээллийн хэрэгцээ нь манай эриний өмнөх З дахь мянганд Азийн орнуудад тооллого үүссэн тэр үеэс эхэлсэн гэж үздэг.

Эртний Грек, Япон, Хятад, Энэтхэг зэрэг улсуудад тогтмол хийгдэж байсан тооллого нь татвар төлөгчид, цэргийн албан хаагчдын талаар тодорхой мэдээллийг өгдөг байсан. Иисус Христийн Назаретэд амьдарч байсан эцэг, эх түүний төрсөн газар Вифлеемд ирж римчүүдийн явуулж байсан тооллогод оролцож байсан түүх бий. Римийн эзэнт улсад тооллого хатуу хяналтын доор явагддаг байжээ.. Цензийн асуултын хариу нь тангаргаар хийгдэж их хугацаа зарцуулдаг байснаас гадна асуулганд хариулж байгаа хүн өөрийнхөө гал голомтын тухай мэдээлийг (өрхийн гишүүд, өмчийн талаар) зайлшгүй өгөх ёстой байсан.

Тамын шүүлтийн тухай ном (Domesday Book) нэрээр алдаршсан 1086 оны Английн цензийн тодорхойлолт одоо хүртэл хэрэглэгдсээр байна.

### **Хүн амын тооллого, хүн амын тооцоо хоёрын хоорондын уялдаа**

Олон улсын хүн амын статистикийн практикт 10 жил тутам явагддаг хүн амын тооллогын хооронд жил бүр хүн амын бүртгэл хийгддэг. Энэ нь сүүлийн хүн амын тооллогын материалд нэмэлт тооцоо хийнэ. Үүний утга нь тухайн газарт оршин суугаа хүн амын тоон дээр шинээр төрсөн хүний тоо, тухайн газар нутагт шилжиж ирсэн хүний тоог нэмж түүнээс нас барсан хүний тоо, тухайн газар нутгаас шилжиж явсан хүний тоог хасч тодорхойлдог. Шилжин ирэгсэд, шилжин явагсад, төрсөн, нас барсан хүний бүртгэлийг засаг захиргааны нэгж бүрт тусгай алба хариуцан гүйцэтгэдэг.

Хүн амын тоог жил бүрийн 1-р сарын 1-ний өдрөөр тооцон гаргадаг бөгөөд жилийн өмнө хүн амын тооны өөрчлөлт хийх урьдчилсан хувилбарыг зохиодог. Хүн амын тооны үнэлгээг 2 категориор (бэлэн ба суурин хүн амаар) хийдэг. Тухайн жилийн 12-р сард хүн амын тооны үнэлгээг хийхдээ хүн амын ердийн хөдөлгөөний дүнг эхний 10 сарын байдлаар (дараа жилд тооцогдох), шилжих хөдөлгөөний дүнг эхний 9 сарын байдлаар (дараа жилд тооцогдох) ашигладаг. Хүн амын тооны эцсийн үнэлгээ 3-р сард хийгддэг.

Ийм маягаар тооллого хоорондын хүн амын тооцоог дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

*Оны эхний хүн амын тоо + Төрөгсдийн тоо + Шилжин ирэгсдийн тоо -  
Нас барагсдын тоо - Шилжин явагсдын тоо = Оны эцсийн хүн амын  
тоо.*

Хүн амын тооллого, хүн амын бүртгэлийн хооронд шууд холбоо байх нь ойлгомжтой. Хүн амын талаарх мэдээллийг авах гурав дахь эх үүсвэр нь хүн амын тооллогын материал, тухайн жилүүдийн хүн амын

тооны үнэлгээг ашиглан хүн амын хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг тооцох явдал юм.

### **Хүн амын хэтийн тооцоо хийх арга**

Хүн амын хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг тооцоходо нас дэвшилтийн аргыг хэрэглэдэг. Энэ арга бол хүн амын тооллогоор бүртгэгдсэн өөрийнхөө насны бүлэгт байгаа хүн амын тоо ( $S_x$ , t) нь жилийн дараа хүн амын насны дараагийн бүлэгт шилжих ба бүгд биш зөвхөн дундаж наслалтын коэффициент ( $P_x$ )-ын тусламжтайгаар нас баралтын хүснэгтэнд байгаа нас барагсдыг хасч тооцдог арга юм. Хэрэв

( $S_x$ , t)-г ( $P_x$ )-ээр үржүүлбэл жилийн дараа дараагийн насны бүлэгт ( $S_x+1$ ,  $t+1$ ) шилжсэн хүний тоо гарна. Дараа дараагийн жилийн хүн амын тоог гаргахдаа энэ үйлдэл давтагдах бөгөөд шилжих хөдөлгөөний сальдо, өөрөөр хэлбэл шилжиж ирсэн, шилжиж явсан хүн амын ялгавар, төрсөн, нас барсан хүн амын хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг тооцож гаргадаг. Энэ үзүүлэлт нь төрөх насны эмэгтэйчүүдийн (15-49 насны) тоог насны бүлэг бүрийн төрөлтийн коэффициентоор үржүүлсэнтэй тэнцүү. Хүн амын хүлээгдэж буй гүйцэтгэлийг дараах томьёогоор тооцно.

Үүнд:

$$S(x+1, t+1) = S(x, t) \times P(x, t) + W(x, t)$$

$W(x, t)$ - хүн амын механик хөдөлгөөний сальдо

Энэ арга (экстраполяци) нь 5-аас илүүгүй жилийн доторх тооцоог хийхэд ашиглагддаг. Хэрэв урт хугацааны хэтийн тооцоо хийх болбол хүн амын байдал, түүний хөгжилтэй салшгүй холбоотой бусад хүчин зүйлүүдийн өөрчлөлтийг тусгасан хэтийн үнэлгээ хийх гурван төрлийн аргыг ашигладаг. Ийм аргачлалыг НҮБ-ын статистикийн байгууллагууд хүн амын хэтийн тооцоо хийхэд ашиглаж байна. Өөрөөр хэлбэл, дээрх байгууллагууд эерэг (оптимистический), сөрөг (пессимистический), дундаж (средний) гэсэн гурван төрлийн хэтийн тооцоо зохиож байна. Өнөөдөр НҮБ-ын хүн амын хэтийн тооцоо хамгийн үнэн зөв мэдээлэл болж мэргэжилтнүүдийн дунд өндөр нэр хүндтэй байна.

Олон улсын хүн амын статистикийн үзүүлэлтүүдийн системд дараах үзүүлэлтүүд хамарагдана. Үүнд:

- Нийт хүн амын тоо
- Хүн амын нийгмийн бүтэц
- Нас, хүйсний бүтэц
- Ердийн хөдөлгөөн
- Гэрлэлтийн байдал
- Дотоод шилжих хөдөлгөөн
- Гадаад шилжих хөдөлгөөн

## **МОНГОЛ УЛСЫН ЯСТАНГУУДЫН ТОО, БАЙРШИЛД ГАРЧ БҮЙ ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙН АСУУДАЛД**

**M. Баянтар**

**Доктор, МУИС-ийн профессор, МУИС, Газарзүй- Геологийн  
факультет, Нийгмийн газарзүй- Аялал жуулчлалын  
тэнхимийн багш.**

**Г. Нямдаваа**

**Доктор, дэд профессор, УИХ-ын гишүүн.**

**З. Баярмаа**

**Газарзүйч, бус нутаг судлаач магистр**

Өнөөдөр манай оронд хорь гаруй ястан оршин сууж байна. 2000 оны байдлаар манай улсын хүн амын 92.8 хувийг халх, казах, дөрвөд, буриад, баяд ястан 7.2 хувийг бусад ястанууд эзэлж байна. Нийт хүн амын 81 хувийг халх ястан эзлэн дийлэнх олонхи болж, монгол ахуй, зан заншил, нийгэм эдийн засгийн онцлогийг бүрдүүлж байна.

Энэхүү ажилд Монгол Улсын ястнуудын өсөлт болон байршилтад гарсан өөрчилөлтүүдийг тооллогын онуудаар харьцуулж үе тус бүрийн онцлогийг авч үзсэн байна. Ястнуудын өсөлттөд хүн амзүйн үзүүлэлтүүд, түүний дотор насны бүтцийн ялгаатай байдал ихээхэн нөлөөлж байна. Түүнчилэн ястнуудын нутагшилт, түүнд гарч байгаа өөрчлөлт ч харилцан адилгүй байна. Хэдийгээр хүн амын өсөлт, шилжилт, нутагшилт ийнхүү харилцан адилгүй дүр зурагтай байгаа ч монгол үндэстнийг бүрдүүлж байгаа ястнуудын дотор элдээ хэлбэрийн тэмцэл, ястан хоорондын зөрчил байхгүй юм..

Нэг талаар Үндсэн хуулийн дагуу иргэд хүссэн газартаа амьдран суух эрхээр хангагдсан, нөгөө талаас даяарчлагдаж байгаа өнөө үед үндэстэн ястан бур өөрийн өвөрмөц ёс заншил, соёл, уламжлалын ололттой зүйлүүдээ хадгалан хамгаалах, үр хойч үедээ өвлүүлэх талаар санаачлагатай ажиллах шаардлагатай байгааг бүтээлд тусгажээ.

Монгол Улсын нийт хүн амд үндэстэн, ястнууд ямар байр суурь эзэлдэг, тэдгээрийн байдал хэрхэн өөрчлөгдөж байгааг тодорхойлох нь хүн амын газарзүйн судалгааны нэг гол зүйл байдаг. Манай улс нийт 9 удаа хүн амын тооллогыг явуулсан бөгөөд 1956 оноос хойш их тооллогыг статистикийн байгууллага мэргэжлийн хэмжээнд бэлтгэн явуулж, боловсруулсан байна. Иймд бид үндэстэн, ястнуудын эзлэх хувь, түүний өөрчлөлтийн онцлогийг илрүүлэхийн тулд эхний ээлжинд 1956, 2000 онуудын хүн амыг тооллогын материал дээр харьцуулан шинжилж үзэв. Халх ястан нь манай орны нийт хүн амд дийлэнх олонхийг бүрдүүлдэг хамгийн том угсаатны бүлэг бөгөөд энэ хугацаанд эзлэх хувийн жин тасралтгүй өссөөр ирсэн байна. Халх ястны дараа нийт хүн амын 4,3 хувийг эзлэж байгаа казахууд орж байна. Дөрвөд, баяд, буриад, дарьганга, захчин, урианхай зэрэг бусад ястангууд нь нийт хүн амын 1,1-2,8 хувийг тус тус эзлэж байна. Нийт хүн амд халх ястны эзлэх хувь 1956 онд 75,6 хувь байснаа 2000 онд 81,5 хувь болж бусдаасаа түлхүү өссөн нь 1992 оноос хойш казах иргэдийн шилжилттэй холбоотой.

**Хүснэгт 1. Монгол Улсын нийт хүн амд ястны эзлэх хувь. 1956-2000 тооллогоор.**


Ястан үндэстний нэр	Халх	Казах	Дервэд	Буриад	Баяд	Дарынгага	Урианхай	Захчин	Дархад	Торгууд	Өөлд	Хотон	Мянгад	Барга	Үзэмчин	Бусад
1956 он	75.6	4.3	3	2.9	1.9	2	1.9	1.3	1.9*	0.6	0.6	0.3	0.3	0.3	0.2	1.7
2000 он	81.5	4.3	2.8	1.7	2.1	1.3	1.1	1.3	0.7	0.5	0.6	0.4	0.2	0.1	0.1	0.7

**Эх үүсвэр:** УСГ, Статистикийн эмхэтгэл, 2000

**Тэмдэглэл:** Дархад\*- 1956 оны хүн амын тооллогын материалд дархад ястанг урианхай ястантай хамтатгасан тул 1963 оны тооллогын дүнгээр авав.

1956 оноос хойш нийт хүн амд баяд, захчин, өөлд, хотон ястнуудын эзлэх хувь тогтвортой хадгалагдаар ирсэн бөгөөд үзэмчин, барга, буриад, болон бусад гэсэн ангилалд багтаж буй ястнуудын тоо нэмэгдсэн ч гэсэн нийт хүн амд эзлэх хувь нь буурсан байна. Энэ нь эдгээрээс бусад ястангуудын хүн ам илүү их өссөн болон халх ястны хүн амын тоо зарим тохиолдолд механикаар өсөж байсантай холбоотой юм.

**Зураг 1. Монгол Улсын нийт хүн амд халх ястны эзлэх хувийн өсөлт**



1956 он



2000 он

Манай улсын ястангуудын хүн амын өсөлт хэрхэн явагдаж ирснийг олон жилийн тооллогын материалд тулгуурлан өөр хооронд нь харьцуулж үзье. 1956 оноос өмнөх хүн амын тооллогын материалд боловсруулалт хийгдээгүй байсан тул түүнээс хойшхи тооллогын материалыг ашиглан эхний ээлжинд ястан тус бүрийн үнэмлэхүй тоогоор харьцуулан үр дүнг хүснэгт 2-т харуулав.

**Хүснэгт 2 Монгол Улсын үндэстэн, ястны тоон өсөлт  
(1956-2000 он хүртэл)**

Үндэстэн ястан	Он					
	1956	1963	1969	1979	1989	2000
Бүгд	845481	1017162	1188271	1538980	1987274	2365269
Халх	639141	775376	911079	1235806	1610424	1934674
Казах	36729	47735	62812	84305	120506	102983
Дөрвөд	25667	31339	34725	45053	55208	66706
Буриад	24625	28523	29772	29802	35444	40620
Баяд	15874	19891	25479	31053	39233	50824
Дарьганга	16852	18587	20603	24564	29040	31909
Урианхай	15772	14399	15662	18957	23478	25183
Захчин	10833	13140	15057	19475	22998	29766
Дархад	**	8826	10174	10716	14757	19019
Торгууд	4729	6028	7119	8617	10050	12628
Өөлд	4907	5614	6876	8857	9188	14634
Хотон	2603	2874	4056	4380	6076	9014
Мянгад	2518	2712	3222	4173	4760	6028
Барга	2458	2343	2305	1999	2130	2506
Үзэмчин	2046	2070	2127	2030	2086	2386
Орос	13444	8905	1433	196	140	158
Хятаад	16157	21981	725	344	247	173
Бусад	11125	6819	35045	8653	1509	8128

**Эх сурвалж** \*-Монгол Улсын хүн ам Статистик 70 жил, УБ 1994

-Хүн ам, орон сууцын 2000 оны тооллого., УБ 2001

**Тэмдэглэгээз-** \*\* - 1956 оны хүн амын тооллогоор Дархад ястанг Урианхай ястантай хамтаган тоолсон байна.

Энэхүү бодит тоон үзүүлэлтээс өсөлтийн явц, хэлбэлзлэлийг илүү тодорхой гаргах зорилгоор ястан тус бүрийн хүн амын тоо тухайн үед жилд дунджаар ямар байсныг тооцон харьцуулалт хийж, үе тус бүрийн онцлогийг авч үзье.

**Хүснэгт 3 Монгол Улсын ястны жилийн дундаж өсөлт, хувиар.  
(1956-2000 оны тооллогоор)**

Үндэстэн, ястан	1956-1963	1963-1969	1969-1979	1979-1989	1989-2000
Халх	2.7	2.7	3.1	2.6	1.8
Казах	3.8	4.6	2.9	3.6	-1.5
Дөрвөд	2.8	1.7	2.6	2.0	1.9
Буриад	2.1	0.7	0.01	1.7	1.3
Баяд	3.2	4.2	1.9	2.3	2.6
Дарьганга	1.4	1.7	1.7	1.6	0.9
Урианхай	-1.2	1.4	1.9	2.1	0.7
Захчин	2.7	2.3	2.6	1.6	2.6
Дархад	0	2.4	0.5	3.2	2.5
Торгууд	3.5	2.8	1.9	1.5	2.3
Өөлд	1.9	3.4	2.5	0.3	4.7
Хотон	1.4	5.9	0.7	3.3	4.0
Мянгад	1.1	2.9	2.6	1.3	2.4
Барга	-0.6	-0.2	-1.4	0.6	1.6
Үзэмчин	0.2	0.4	-0.4	0.2	1.3
Дундаж өсөлт	1,6	2,5	1,5	1,8	1,9

**Эх сурвалж** \*-Монгол Улсын хүн ам Статистик 70 жил, УБ 1994

-Хүн ам, орон сууцын 2000 оны тооллого., УБ 2001

Монгол Улсын ястны жилийн дундаж өсөлт харилцан адилгүй бөгөөд 1956-1963 оны хоорондох жилийн дундаж өсөлт 1,6 хувь байгаагаас үзвэл тухайн хугацаанд хүн амын өсөлт казах, торгууд, баяд ястны хувьд хамгийн өндөр буюу дундаж өсөлтөөс 2 дахин их байна. Харин урианхай ястан тооны хувьд өсөөгүй харин ч буурсан нь 1956 оны тооллогоор Дархад Урианхай ястанг хамтатган тоолсон, 1963 онд тус тусад нь тоолсонтой холбоотой юм. 1956-1963 оны хоорондох өсөлт нь - 1,2 хувь болсон байна. Барга ястны өсөлт -0,6% хувиар буурсан тухайн үеийн хүн амын тооллогын үед барга ястан нь өөрсдийгөө халх гэж бүртгүүлэх болсонтой холбоотой байж болох юм. 1963-1969 оны хооронд ястны жилийн дундаж өсөлт 2,5 хувь байгаа бөгөөд нийт угсаатан ястны хувьд харьцангуйгаар өсөлт ихэссжээ. Харин хотон, казах, баяд ястны өсөлт илүү байгаа ба дархад, захчин, халх ястны өсөлт дундаж орчимд, харин хамгийн бага өсөлттэй ястанд буриад, үзэмчин орж байна. Барга ястны өсөлт нь өмнөх үеэсээ буурчээ. 1969-1979 оны хоорондох нийт хүн амын жилийн дундаж өсөлт 1,5 хувь байгаа нь өмнөхөөс буурсан байна. Гэвч үзэмчин барга, бусад ястны хүн амын өсөлтийн оргил үе бөгөөд барга, үзэмчин болон зарим ястан өөрсдийгөө халх гэж бүртгүүлэх болсны улмаас халх ястны өсөлт тасралтгүй нэмэгдэж, зарим нэг ястны өсөлт буурсан мэт харагдах явдал гардаг байв.

1979-1989 оны хоорондох ястны жилийн дундаж өсөлт 1,8 хувь байгаа бөгөөд барга, үзэмчин ястны тоон өсөлт өмнөх үеүдээс бага зэрэг нэмэгдсэн боловч хамгийн бага өсөлттэй хэвээр байна. Хамгийн өндөр өсөлттэй (3.6 хувь) нь казах ястан байгаа нь өмнөх үеүдтэй харьцуулахад тогтвортой байна. Харин өөлд, дөрвөд, мянгад ястнуудын өсөлт өмнөхөөсөө буурчээ. Энэ нь эдгээр ястан өөрсдийгөө халх гэж бүртгүүлэх болсон, мөн хүн амынх нь дунд ахмад насны хүн амын эзлэх хувийн жин их байдаг зэргээр тайлбарлагдана. Ер нь угсаатан зүйчдийн судлаж бичсэнээр цөөн тоотой угсаатан, ястанг социализмийн үед өөрсдийгөө халх гэж бүртгүүлэх болсон нь тухайн үеийн нийгэм, улс төрийн байдалтай холбоотой юм. Энэ нь тухайн ястны хүн амын тоо буурах, нөгөө ястны тоо нэмэгдэхэд мэдэгдэхүйц нөлөөлж байв. 1989-2000 оны хоорондох ястны дундаж өсөлт 1,9 хувь байгаа бөгөөд барга, үзэмчин ястны хүн амын өсөлт нэмэгдэж, улсын дунджид ойртсон байна. Харин казах ястны өсөлт 1,5 хувиар буурсан нь 1992 оноос хойш Монгол Улсын казах иргэд “Хөдөлмөрийн гэрээ” гэдэг ерөнхийлсөн нэрийн дор Казахстанд бөөнөөрөө очих болсонтой холбоотой юм. Үүнийг үндэсний хэл соёл, үр удмаа бодсон түүхийн гүнзгий учир шалтгаантай гэж тайлбарлаж байсан билээ. Гэвч үнэн хэрэг дээрээ төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн тогтолцоонд шилжих явцад гарсан амьдралын бэрхшээл нөлөөлсөн нь тодорхой. 1994 онд Казахстан, Монгол Улсын хооронд Казахстанд сайн дураараа нүүн очих журам ба иргэний харьяаллын тухай боловсруулсан гэрээгээр, хэрэв Монгол Улсын казахууд Казахстаны харьяат болно гэвэл Монгол Улсын харьяатаас гарсан байх шаардлагатай юм.

1991 оноос хойш Монгол Улсаас 65 мянга орим казахууд Казахстанд шилжин суурьшжээ. Тэдний олонхи нь Казахстан улсын иргэн болох хүсэлт гаргасан байна. Казахстаны тал бараг 32 мянган хүнийг (31884) өөрийн харьяатад авсан гэж 2001 онд албан ёсоор мэдэгджээ. /1.x-3/

Бусад ястны өсөлттэй харьцуулахад казахуудын өсөлт их байгаа нь нэг гэр бүл дэх хүүхдийн тоо их, төрөлт их байдагтай холбоотой.

Дээрхи ястны хүн амын өсөлтийн харилцан адилгүй байдалд үндэслээд дараах 4 бүлэгт ангилж болохоор байна. Энэ нь бидний судалгааны үр дүнд тулгуурласан хүн амын өсөлтийн онцлогоор хийсэн ангиллын оролдлого юм.

#### Хүснэгт 4. Монгол Улсын үндэстэн, ястнуудын жилийн дундаж өсөлтийн ангилал.

Ангилал	Үзүүлэлт	1956-1963	1963-1969	1969-1979	1979-1989	1989-2000	Дундаж
Хамгийн их өсөлттэй	>4	Хотон, казах, баяд				Хотон, өөлд	
Өсөлт ихтэй	4-2	Казах, баяд, торгууд, дөрвөд, халх, буриад, захчин	өөлд, мянгад, захчин, торгууд, дархад, халх,	Халх, казах, дөрвөд, захчин, торгууд, захчин, мянгад	Казах, халх, дөрвөд, баяд, урианхай, дархад, хотон	Баяд, захчин, дархад, торгууд, захчин, дөрвөд, дархад	Хотон, баяд, казах, халх, өөлд, торгууд, захчин, дөрвөд, дархад
Бага өсөлттэй	2-0	Өөлд, хотон, мянгад, буриад, даръганга, урианхай, үзэмчин	Дөрвөд, буриад, даръганга, урианхай, үзэмчин	Баяд, урианхай, даръганга, дархад, торгууд, хотон,	Буриад, даръганга, захчин, торгууд, өөлд, мянгад, барга, үзэмчин	Халх, дөрвөд, буриад, даръганга, урианхай, мянгад, барга, үзэмчин	Мянгад, даръганга, буриад, урианхай, үзэмчин
Өсөлтгүй	0>	Урианхай, барга	Барга	Буриад, барга, үзэмчин		Казах	Барга

**Эх сурвалж** \*-Могол Улсын хүн ам Статистик 70 жил, УБ 1994  
-Хүн ам, орон сууцын 2000 оны тооллого., УБ 2001

Угсаатан, ястны өсөлтийн явцыг тухайн жилийн дундаж өсөлтөөр гаргахаас гадна 1956 оноос хойшхи 44 жилийн дараах хугацаатай харьцуулан авч үзэхэд хотон, баяд, халх ястан бараг гурав дахин өссөн байхад барга, үзэмчин ястны тоо бараг нэмэгдээгүй шахам байна.


#### Хүснэгт 5 Монгол Улсын үндэстэн, ястны тоон өсөлтийн харьцуулалт (1956, 2000 оны үзүүлэлтээр)

Үндэстэн, ястан	1956	2000	Өсөлтийн ерөнхий хувь
Халх	639141	1934674	302,7
Казах	36729	102983	280,4 <sup>1</sup>
Дөрвөд	25667	66706	260
Буриад	24625	40620	165
Баяд	15874	50824	320,2
Даръганга	16852	31909	190
Урианхай	15772	25183	160
Захчин	10833	29766	274,7
Дархад	8826*	19019	215,4

Торгууд	4729	12628	267
Өлд	4907	14634	298
Хотон	2603	9014	346,3
Мянгад	2518	6028	240
Барга	2458	2506	102
Үзэмчин	2046	2386	116,6
<b>Дундаж өсөлт</b>			<b>235,8</b>

**Эх сурвалж** \*-Монгол Улсын хүн ам Статистик 70 жил, УБ 1994

-Хүн ам, орон сууцын 2000 оны тооллого., УБ 2001




Монгол оронд 1921 оны хувьсгал ялж улмаар 1950- иад оноос улс орон тайван замаар хөгжих болсон тэр цагаас эхлэн үндэстэн ястан бие биендээ аажмаар ойртон нягтарснаас ялгагдах зарим онцлог нь бүдгэрэх болсон. 1960-иад оноос хотжих процесс улам хүчтэй явагдаж өхөлсэн тэр цагаас угсаатан, ястан нь хот суурин газар бараадан суурьшихи болж ингэснээр хот маягийн амьдралд орж, түүндээ зохицон хэл яриа, ахуй, оюуны, соёлын харилцан ижил хэв шинжид алгуур шилжсээр байна. Харин хөдөө орон нутаг, алс бөглүү сумдад буй (Хөвсгөл аймгийн нутагт буй Цаатан ястан гэх мэт) зарим ястан одоог хүртэл ястны өвөрмөц байдлаа илүүтэй хадгалсаар байна.

Юуны өмнө 1992 оны Үндсэн хуульд "Монгол Улсын иргэн оршин суух газраа өөрөө сонгоно"-гэсэн хуулийн заалт гарсан нь үндэстэн, ястныг ойртуулан нэгдэн нийлэх, үйл явцад нөлөөлж байна.

Ястны өсөлт харилцан адилгүй байгаа нь тэдний тархалт, суурьшилт, хөдөлмөр эрхлэлт, нас хүйсийн бүтэцтэй холбоотой. Энэ харилцан адилгүй байдлыг барга, дөрвөд, хотон ястны өсөлтөн дээр харьцуулан үзүүллээ. Хотон ястны тоо бусад ястны тоотой харьцуулахад бага боловч жилийн дундаж өсөлт нь хамгийн их байна.

**Зураг 2 Барга, дөрвөд, хотон ястны хүн амын өсөлт (1956-2000 он)**




Одоо бид Монгол Улсын ястны насны бүтцийн онцлогийг авч үзье. Монгол орны ястангуудын эзлэх хувь, өсөлтийн байдал өөр хоорондоо ихээхэн харилцан адилгүй болохыг өмнөх хэсэгт бид авч үзлээ. Энэ харилцан адилгүй байдалд хүргэж байгаа байгаль, нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлүүдийн дотор хүн амын өөрийн бүтэц бүрэлдэхүүний байдал ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Үүний нэг үзүүлэлт нь ястны насны бүтэц харилцан адилгүй байгаа явдал юм. Энэ онцлогийг илрүүлэхийн тулд голлох зарим ястны насны бүлгийг харьцуулан авч үзэв.

**Хүснэгт 6 Монгол Улсын ястны эзлэх хувь, насны бүлгээр (2000 он)**

Насн бүлэг	Халх	Казах	Дөрвөд	Буриад	Баяд	Бусад
Бүх хүн ам	1934674	102983	66706	40620	50824	169462
0-14	35.5	42.5	36.8	30.6	37.1	36.4
15-24	21.2	20.6	20.0	19.6	19.7	20.3
25-34	17.3	15.5	16.5	15.8	16.8	16.0
35-44	12.7	10.1	12.5	14.6	12.5	12.0
45-54	5.9	4.6	6.2	8.2	6.1	6.2
55+	7.4	6.7	8.0	11.2	7.8	8.9
Бүгд	100%	100%	100%	100%	100%	100%

**Эх сурвалж** Хүн ам, орон сууцын 2000 оны тооллого., УБ 2001

**Зураг 3 Монгол Улсын ястны насны бүтэц, хувиар. (2000 он)**



Хүснэгт 6, зураг 3-аас хараад ястан бүрийн насны бүтэц өөр хоорондоо ихээхэн ялгаатай байна. Тухайлбал: казах иргэдийн дунд 15 хүртэлх насны хүүхэд 43 хувийг эзэлж байгаа нь бусад ястнай харьцуулахад хамгийн залуу бүтэцтэй болохыг илэрхийлж байна. Энэ нь казах эмэгтэйчүүдийн төрөлт бусад ястнаас харьцангуй өндөр байдагтай холбоотой. Харин буриад ястны дотор өндөр настнуудын эзлэх хувь өндөр байна. Эдгээрээс хамаараад үндэстэн, ястны өсөлтийн явц, ирээдүйн төлөв байдал харилцан адилгүй болдог байна.

1990-д оноос хойш манай улсын нийгэм-эдийн засгийн байдалд ихээхэн өөрчлөлт орсон нь үндэстэн, ястны нутагшилтанд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Учир нь хөдөөд нутаг эзгүйрч, зах зээлийн хэрэгцээ, бөөгнөрлийг дагасан чадварлаг нэг хэсэг нь, нөгөө талаас амьдралын эх үүсвэргүй болсон зарим нь хот суурин газар бараадан сургууль соёл эзэмшиж, хүн амын шилжилт эрчимжиж байгаа нь цус ойртох зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд гарах нөхцлийг үгүй болгох сайн талтай. Харин ястан, үндэстний өвөрмөц онцлог, ялангуяа уламжлалт зан заншлынхаа эерэг сайн талыг нь хадгалан үлдээх талаар анхаарах хэрэгтэй юм.

Одоо бид ястны нутагшилтанд гарсан өөрчлөлтийг авч үзье.

Хүн амын шилжих хөдөлгөөнд тусгайлан тогтоосон засаг захирагааны болон газарзүйн нэгжүүдийн хооронд, түүнчлэн газар нутгийн байршилын хувьд явагдах хүн амын суурьшлын өөрчлөлтийг хамааруулна.

Хүн амын шилжих хөдөлгөөнд хотууд нийгэм, эдийн засгийн дэвшил, шинэчлэлт, соёл боловсролын татах төв болдог ба шилжилт нь амьдралын шинэ бололцоо, өөрчлөх боломж нь болдгоороо онцлог юм. Манай улсын хувьд 1960-аад оноос хотжих процесс эрчимжин, хот суурин газар бараадах их нүүдэл эхэлсэн бөгөөд, шинээр ашигт малтмалын нөөц, орд газруудыг ашиглах шинэ шинэ үйл ажиллагааны нөлөөгөөр хүн амын шилжих хөдөлгөөн эрчимжсэн.

Хүн амын шилжих хөдөлгөөнд залуу үеийнхэн илүү их хувийг эзэлдэг нь тэдний сурч боловсрох, шинэ амьдрал эхлэх зэрэг үйл ажиллагааны дүн юм.

Хүн амын шилжилтээс ястны шилжилтийг ялган үзэх нь бэрхшээлтэй бөгөөд нийгэм, эдийн засгийн нөхцөл, нөлөөллөөр бий болдог шилжилт нь үндэстэн, ястны хэсэг бүлгээрээ нүүн, очсон газраа тухайн ястны бөөгнөрлийг үүсгэдэг байна. Үүний нэг тод жишээ бол 1990 ооос хойш шинэ Үндсэн хуулийн заалтын дагуу өнөөдөр Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудыг тойрсон суурьшлын шинэ хэлбэрүүд бий болж байна. Статистикийн мэдээ материалыаас үзвэл 1989 онд Дархан-Уул аймагт Дөрвөд ястны эзлэх хувь 2,9 байсан 2000 оны тооллогын үед 4,2 хувь болон өссөн байна. Мөн баяд ястны эзлэх хувь 1989 онд 1,6 хувь байсан бол 2000 онд 3,5 хувь болон өсчээ. Энэ нь хүн амын шилжих хөдөлгөөнийг чөлөөтэй болгон, иргэд өөрийн ажиллаж, амьдарч чадах орон зайгаа өөрөө сонгон, тэмүүлж амьдрах нийгмийн шаардлагатай холбоотойгоор бий болсон шилжилт юм. Харин Төв хэсгийн үйлдвэржсэн бүсэд хүн ам өссөн байхад Баруун аймгуудад дээрхи ястны өсөлт харьцангуйгаар буурсан байна

Халхчуудын нутаглах газар нутгийн талбай их, хүн амын нягтшилт харилцан адилгүй, тэдний нутаглаж байгаа төв ба умард нутаг дахь үйлдвэрлэх хүчний хөгжлийн хурдац, төвлөрөл манай улсад хамгийн өндөр байсантай уялдаж хүн амын шилжих хөдөлгөөн эрчимжин, хүн

амын байршил нутагшилтанд орон нутаг, аймгийн төдийгүй улс орны хэмжээнд ихээхэн өөрчлөлт гарчээ. Халхчуудын 40 хувь нь шилжих хөдөлгөөнд хамрагдаж, улс орны аль ч хэсэгт оршин сууж байсан хэдий ч шилжигсдийн ихэнх нь хотууд, тосгон суурингүүд болон Төв, Сэлэнгэ, Булган аймгийн газар тариалан голлон эрхэлдэг сумдад шилжин суурьшжээ. Халхчуудын энэхүү байршилт, шилжих хөдөлгөөн нь Монголчуудын шилжих хөдөлгөөний төрх байдлыг тод хадгалсан байна.

Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт 1930-аад он хүртэл дөрвөд ястнууд нутаглаж байсан бөгөөд 1950-аад оноос эхлэн шилжин суурьшсаар одоо энэ суманд цөөн тооны өрх үлджээ.

Үндэстэн, ястны нутагшилт, түүнд гарсан үндсэн өөрчлөлтүүд дотроос буриадууд нэн өвөрмөц ул мөр үлдээсэн. Энэхүү үйл явдлуудаас 1918 оноос хойшиг үеийг нь тодруулан дурьдвал:

- 1918-1924 онуудад Буриад Монголоос Монгол нутаг руу чиглэсэн нүүдэл эхэлсэн. 1921 онд Д.Сүхбаатар, С.Данзан нар Зөвлөлт Оросын удирдлага (В.И.Ленин, В.Чечерин)-тай уулзахдаа 7 зүйл асуудал тавьсны нэг нь буриадууд Монголд нүүж ирэхэд чөлөөтэй боломж олгох тухай асуудал байсан. Энэ талаар нааштай тохиролцоонд хүрч 1923-1924 онд Монголын Засгийн газарт буриадын асуудал хариуцсан хороо байгууллагдаж, Ерөөгийн, Ононгийн, Улзын буриад хошууд зохион байгуулж байжээ. /7.x-33/
- 1924 оны 10-р сарын 28-нд БНМАУ-ын Засгийн Газрын 42-р хурал, Улсын Анхдугаар Их Хурлаас (тэр үеийн нэр томъёогоор) 4316 буриад өрхийн 16093 иргэнийг Монгол Улсын харьяатад хуульчлан бататгав хэмээн БНМАУ-ын Анхдугаар Их Хурлын протоколд тэмдэглэсэн байдаг юм.
- Казахууд баруун Монголд 1860-1870 оны хооронд орж ирсэн. Ингээд 1868-1875 хоорондох хугацаанд тодорхой газар нутаг эзэмшин, суурьшиж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд ойролцоогоор 10000 орчим казах иргэд Монголд орж ирсэн байна. Тэд Ховд голын эх, одоогийн Сагсай, Улаан Хус, Цэнгэл, Даян сумуудын нутагт урианхай ноёдоос газар түрээслэн авч суурьших болжээ. 1912 онд Монголын баруун хязгаарт гарсан үймээний үед казахууд ихээр хэлмэгдэж, казахуудын нэг хэсэг нь Алтайн уулсыг даваж Шинжаан руу, нөгөө хэсэг нь Оросын нутагт орж Чүйн гол орчим нутаглаж байгаад 1913-1914 онд Ар Монголын баруун хязгаар нутагт буцан ирж суурьшсан байна.

### **Байршилтын өнөөгийн онцлог**

Үндэстэн, ястан бүр оршин суугаа нутгийн байгалийн нөхцөл, нийгэм, эдийн засгийн орчин нөхцөлдөө зохицуулан аж ахуйгаа эрхлэн явуулах үйлдвэрлэлийн өвөрмөц дадлага, туршлага хуримтлуулж зарим нь өвөрмөц орон сууц, суурин газрыг үүсгэн бий болгосон байдаг. Эдгээр өвөрмөц онцлогууд нь орчин үеийн хүн амын байршилт, шилжих хөдөлгөөн, эдийн засгийн амьдралд зохих хэмжээгээр нөлөөлдөг болохоор ийм өвөрмөц аж ахуйн хэвшил, дадал туршлагыг судлах нь хүн амын газарзүйн нэг гол судлах зүйл болж байна. /20.x-73/

Монгол нутагт одоогийн байдлаар монгол, түрэг угсааны гуч шахам ястнууд амьдарч байгаа бөгөөд монгол угсааны ястан нийт хүн амын 93,5 хувийг эзлэн нийт нутаг дэвсгэрийн 97 хувьд нь тасралтгүй үргэлжилсэн нутагшилттайгаар оршин суудаг.

Монгол үндэстнийг бүрдүүлэх эдгээр 20 гаруй уgsаатан, ястнаас **халх ястан** хамгийн их хувийг (81 хувь) эзлэх бөгөөд Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Булган, Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Хөвсгөл аймгийн ихэнх нутаг, Ховд аймгийн Буянт, Дарви, Цэцэг, Чандмань сумд, Мөст сумын зүүн хагас, Увс аймгийн Баруунтуруун, Завхан, Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан сумдын нутгаар оршин сууна.

**Хотгойд ястан** нь Завхан аймгийн Нөмрөг, Баянхайрхан, Баянтэс сумдад 1,4 хувь нь, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Цагаан-Уул, Арбулаг, Бүрэнхайран, Төмөрбулаг сумдын нутаг, Түнэл, Тосонцэнгэл сумдын зарим хэсэгт хотгойд ястны 86 хувь, Улаанбаатар хотод 6 хувь нь оршин суудаг.

**Дарьгангачууд** 31,9 мянга орчим хүн амтай бөгөөд гарал үүслийн хувьд Монголын олон хошуудаас сүрэгчээр цугларч нутагшсан монголчууд бөгөөд Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотод, Баяндэлгэр, Онгон, Наран сумдын бүх нутаг, Халzan, Асгат сумдын нэлээд хэсэгт дарьгангачуудын 82,6 хувь нь оршин суудаг. Дарьгангачуудын 9 орчим хувь нь Улаанбаатар хотод, 4 орчим хувь нь Дархан, Эрдэнэт хотууд, Төв, Сэлэнгэ аймагт, 2 хувь нь Дорнод аймагт оршин сууж байна.

**Буриадууд** нь 40,6 мянга орчим бөгөөд, тэдгээрийн 42 хувь нь Дорнод аймгийн Баян-Уул, Дашибалбар сумдад, Цагаан-овоо сумын ихэнх нутаг, Чулуунхороот сумын баруун хэсэг, Норивлон сумдад, Хэнтий аймгийн Дадал, Батширээт сумдын бүх нутаг, Хэнтий аймгийн нутгийн хойд хагаст 15,3 хувь нь, Булган аймгийн Тэшиг, Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумдад, Ханх хорооны зарим хэсэгт оршин сууна. Буриад ястны хүн амын 1/4 нь Улаанбаатар хотод, мөн ийм хэсэг нь Өндөрхаан, Дархан, Сүхбаатар, Эрдэнэт, Булган, Мөрөн хотуудад оршин сууж байна.

**Дөрвөдүүд** нь Баруун Монголын ойрад угсааны ястан бөгөөд ойролцоогоор 66,7 мянга орчим дөрвөд ястан оршин сууж байна. Дөрвөдүүд ийн 54,2 хувь нь Увс аймгийн Бөхмөрөн, Давст, Өлгий, Өмнөговь, Сагил, Түргэн, Ховд сумдын бүх нутаг, Наранбулаг сумын ихэнх хагас, Тариалан сумын сумын нилээд нутагт, Ховд аймгийн Дөргөн сумын ихэнх нутагт 7,8 хувь нь, 20 орчим хувь нь Улаанбаатарт, 13,2 хувь нь Орхон, Дархан-Уул, Төв, Сэлэнгэ аймгуудад оршин сууж байна.

**Баядууд** нь 51 мянга орчим хүн амтай бөгөөд 62,4 хувь нь Увс аймгийн Зүүнговь, Малчин, Хяргас, Тэс сумдын бүх нутаг, Наранбулаг сумын зүүн хагаст оршин сууна. 1980-аад оноос баядууд Улаанбаатар, Улаангом, Дархан, Эрдэнэт хотууд, Төв, Сэлэнгэ аймгуудад шилжин суурьших болсон. Улаанбаатар хотод баяд ястны хүн амынх нь 1/5 орчин нь оршин суудаг. 12,6 хувь нь Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Булган аймгуудад байдаг.

**Захчин ястан** нийт 30 орчим мянга бөгөөд хүн амынх нь 72,7 хувь нь Ховд аймгийн Манхан, Зэрэг, Алтай, Мөст, Үенч сумдад, 23,1 хувь нь Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудад, Улаанбаатарт хотод оршин сууж байна. **Урианхай ястан** нийт 25 мянга орчим хүн ам бөгөөд хүн амынх нь 26 хувь нь Ховд аймгийн Ховд хот, Мөнххайрхан суманд, 26 хувь нь Баянөлгий аймгийн Алтай, Булган, Буянт сумдад, 37,7 хувь нь Улаанбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл, Дархан-Уул аймгуудад оршин сууж байна.

**Дархад ястан** нь 19 мянга орчим бөгөөд хүн амынх нь 85 хувь нь Хөвсгөл аймгийн Баянзүрх, Ренчинлхүмбэ, Улаан-Уул, Цагааннуур

сумдад, 9,6 хувь нь Улаанбаатар, Сэлэнгэ, Орхон аймгуудад оршин сууж байна.

Торгуудууд 12 мянга орчим бөгөөд 55,4 хувь нь Ховд аймгийн Булган суманд, 27 хувь нь Улаанбаатар хотод, 13,7 хувь нь Дорнод, Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудад оршин байна.

**Өөлдүүд** 14,5 мянга орчим бөгөөд 44,4 хувь нь Ховд аймгийн Ховд, Эрдэнэбүрэн сумдад, 22,5 хувь нь Улаанбаатар хотод, 19 хувь нь Архангай аймагт, 11 хувь нь Баянхонгор, ГовьАлтай, Завхан, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон аймгуудад оршин байна.

**Хотонгуудын** нь бараг 70 орчим хувь Увс аймгийн Тариалан суманд оршин суух бөгөөд Дархан-Уул, Орхон, Улаанбаатар хотод үлдэх хувь нь оршин сууж байна.

**Мянгадууд** 6 мянга орчим бөгөөд Ховд аймгийн Мянгад суманд мянгад ястны 70 орчим хувь оршин суудаг. Үлдэх хувь нь Улаанбаатар, Дархан-Уул, Орхон, Увс, Сэлэнгэ аймгуудад амьдрал сууна.

**Казахууд** бол өнөөдрийн Монгол Улс дахь түрэг угсааны хамгийн том төлөөлөгч юм. Казахууд 103 мянга орчим бөгөөд хүн амынх нь 78 хувь нь Баян-өлгий аймгийн Улаанхус, Толбо, Дэлүүн, Булган, Баяннуур, Сагсай, Алтанцөгц, Цэнгэл, Ногооннуур сумдад, 9,7 хувь нь Ховд аймгийн Ховд, Булган сумдад, 11 орчим хувь нь Улаанбаатар, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгуудад оршин сууж байна.

**Цаатангууд** нь Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын уул тайгаар нутаглана. Цаатан гэдэг нь цаа бугатан гэсэн үгийн товчлогдсон дуудлага юм. Гэрийн цаа буга нь цайвар цагаан өнгөтэй байдгаас энэ нэр үүсчээ. Хилийн шугам өөрчлөгдж, Тарисын раашааны хавь нутаг, Долоон хөшиг, Тэнгис нурууд, Билимын хөндий хилийн цаана үлдэх болсны улмаас тэнд нутаглаж байсан цаатан нар Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Ренчинлхүмбэ суманд шилжин ирж суурьшсан юм. Тэр үед амьдрал нэн ядуу, анх нүүж ирэх үед 300 гаруйхан цаатан, 150-200 хүн шилжин ирж суурьшсан бол одоо 1400 гаруй цаатан, 30 гаруй цаатан өрхөд 200 гаруй хүн тайгад аж төрж байна. Мөн Цагааннуур, Улаан-Уул сумын төвд 150 шахам, Улаанбаатар хот, Сэлэнгэ аймагт 100 шахам цаатангуд оршин сууж байна. Цаатангууд өөр хоорондоо тыва хэлээр, бусадтай монгол хэлээр ярьдаг. Улаан- Уул сумын цаатнуудыг тайгын, Ренчинлхүмбэ сумынхныг зүүн тайгын цаатангуд гэдэг. 1980-аад оны эхээр Цагааннуур сумыг байгуулахад Улаан-Уул сумын баруун тайгынхан Цагааннуур суманд шилжин суурьшжээ. Манай улсад одоо нийтдээ 300 шахам цаатнууд оршин суудаг. Цаа малладаг хүмүүсийг дотор дархад, халх, дөрвөд хүмүүс ч бий.

Ховд аймгийн Буянт суманд 400 гаруй **мончоого-урианхайчүүд** шилжин ирж нутаглажээ. Түрэг хэлтэнд багтах цөөн тооны чантуу/ узбек/ нар Ховд хот, түүний орчим оршин сууж ногооны ажил эрхлэж байсан бөгөөд манай улсад нийт 380 орчим узбекүүд байна.

Бусад угсаатан, ястнуудын тоо дээрхи ястангуудтай харьцуулахад бага бөгөөд хүн амын дунд эзлэх хувь нийлээд 2 хүрэхгүй хувийг эзлэх тул нутагшилт, байршилтыг нь бичээгүй болно.

